

**ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН ХОРООНЫ  
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА  
2026 оны 5 дугаар сарын 12-ны өдөр, Мягмар гараг**

<b>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</b>	1
<b>Хуралдааны товч тэмдэглэл:</b>	2-5
<b>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</b>	6-48

---

- 1. Эрүүгийн хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2025 оны 10 дугаар дүгнэлтийг хүлээн зөвшөөрсөнтэй холбогдуулан боловсруулсан, анхны хэлэлцүүлэг/** 6-26
  - 2. Улсын дээд шүүхийн шүүгчид нэр дэвшигчийг танилцуулах тухай** 26-33
  - 3. Монгол Улсын нэгдсэн төсвийн 2027 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2028-2029 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төсөл /Засгийн газар 2025.05.01-ний өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Төсвийн болон Эдийн засгийн байнгын хороонд хүргүүлнэ/** 33-48
-

**Монгол Улсын Их Хурлын 2026 оны хаврын ээлжит чуулганы  
Хууль зүйн байнгын хорооны  
05 дугаар сарын 12-ны өдөр /Мягмар гараг/-ийн  
хуралдааны товч тэмдэглэл**

Улсын Их Хурлын гишүүн Л.Соронзонболд ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 28 гишүүнээс 15 гишүүн хүрэлцэн ирж, 53.6 хувийн ирцтэйгээр хуралдаан 15 цаг 37 минутад Төрийн ордны “Үндсэн хууль” танхимд эхлэв.

Томилолттой: Б.Баярбаатар, С.Одонтуяа, Г.Уянгахишиг, Д.Цогтбаатар, С.Эрдэнэболд;

Чөлөөтэй: Э.Батшугар, Б.Дэлгэрсайхан, Л.Мөнхбаатар, Д.Пүрэвдаваа, Б.Тулга.

**Нэг.Эрүүгийн хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2025 оны 10 дугаар дүгнэлтийг хүлээн зөвшөөрсөнтэй холбогдуулан боловсруулсан, анхны хэлэлцүүлэг/**

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын Нийтийн эрх зүйн хэлтсийн дарга Д.Энхтөр, Улсын ерөнхий прокурорын газрын Хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагаанд хяналт тавих хэлтсийн дарга Ч.Мөнх-Эрдэнэ, Цагдаагийн ерөнхий газрын Хуулийн хэлтсийн дарга Б.Батзориг, мөн газрын Мөрдөн байцаах албаны Хүний эрх, халдашгүй байдлын гэмт хэрэг мөрдөн шалгах хэлтсийн дарга Б.Дашцэрэн, Монгол Улсын Их сургуулийн Үндсэн хуулийн эрх зүйн хүрээлэнгийн захирал Х.Сэлэнгэ нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын асуудал эрхлэх газрын дарга Б.Хатантуул, мөн газрын Хууль зүйн байнгын хорооны ажлын албаны зөвлөх Д.Нямбаяр, референт Б.Баярсайхан, Л.Хурцбилэг нар байлцав.

Төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх ажлын хэсгээс гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн, ажлын хэсгийн ахлагч Х.Тэмүүжин танилцуулав.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-т заасны дагуу Эрүүгийн хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэв.

Төслийн 1, 2, 3 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн О.Алтангэрэл, Ц.Сандаг-Очир, Н.Алтанхуяг, Х.Баасанжаргал, А.Ариунзаяа, Б.Пүрэвдорж, П.Сайнзориг, Д.Ганбат нарын тавьсан асуултад Улсын Их Хурлын гишүүн Х.Тэмүүжин, Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг, Цагдаагийн ерөнхий газрын Мөрдөн байцаах албаны Хүний эрх, халдашгүй байдлын гэмт хэрэг мөрдөн шалгах хэлтсийн дарга Б.Дашцэрэн, Монгол Улсын Их сургуулийн Үндсэн хуулийн эрх зүйн хүрээлэнгийн захирал Х.Сэлэнгэ нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн, ажлын хэсгийн ахлагч Х.Тэмүүжин хуулийн төсөлтэй холбогдуулан ажлын хэсэг дахин хуралдаж, төслийг зүйл бүрээр нь хэлэлцэх

шаардлагатай тул Эрүүгийн хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг хойшлуулах горимын санал гаргав.

**Л.Соронзонболд:** Улсын Их Хурлын гишүүн Х.Тэмүүжингийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 9

Татгалзсан: 8

Бүгд: 17

52.9 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Горимын санал дэмжигдсэн тул Эрүүгийн хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг хойшлуулав.

*Уг асуудлыг 16 цаг 52 минутад хэлэлцэж дуусав.*

***Хоёр.Улсын дээд шүүхийн шүүгчид нэр дэвшигчийг танилцуулах тухай***

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга П.Золзаяа, Улсын дээд шүүхийн шүүгчид нэр дэвшигч Т.Өсөхбаяр нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын асуудал эрхлэх газрын дарга Б.Хатантуул, мөн газрын Хууль зүйн байнгын хорооны ажлын албаны референт Б.Баярсайхан, Л.Хурцбилэг нар байлцав.

Нэр дэвшигчийн талаарх танилцуулгыг Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга П.Золзаяа танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг, О.Алтангэрэл, Д.Ганбат, Л.Соронзонболд нарын тавьсан асуултад Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга П.Золзаяа, нэр дэвшигч Т.Өсөхбаяр нар хариулж, тайлбар хийв.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн О.Алтангэрэл Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

*Уг асуудлыг 17 цаг 21 минутад хэлэлцэж дуусав.*

***Гурав.Монгол Улсын нэгдсэн төсвийн 2027 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2028-2029 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төсөл /Засгийн газар 2025.05.01-ний өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Төсвийн болон Эдийн засгийн байнгын хороонд хүргүүлнэ/***

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Ж.Энхбаяр, Эдийн засаг, хөгжлийн дэд сайд С.Даваасүрэн, Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга И.Батхүү, мөн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга Л.Энх-Амгалан, Хөгжлийн нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын дарга Б.Мөнгөнсүх, Хөрөнгө оруулалтын бодлогын газрын дарга Б.Мөнх-Эрдэнэ, Худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааны бодлогын газрын дарга Д.Эрдэнэтуяа, Төсвийн хүрээний төлөвлөлтийн хэлтсийн дарга О.Мягмардорж,

Эдийн засгийн бодлого, төсөөллийн хэлтсийн дарга Ц.Мөнхдэлгэр, Хөгжлийн төсөл, хөрөнгө оруулалтын удирдлагын хэлтсийн дарга Б.Төгөлдөр, Салбар дундын бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга З.Райымбек, Тогтвортой хөгжил, нийгмийн бодлогын хэлтсийн дарга П.Чандмань, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Анар, мөн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Дэлгэржаргал, Санхүүгийн бодлогын газрын дарга С.Тулга, Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Н.Мягмар, мөн яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга Н.Отгонбаяр, Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн дарга Ж.Дэлгэрсайхан, мөн зөвлөлийн гишүүн А.Энхбат, Н.Энхбаяр, Шүүхийн ерөнхий зөвлөлийн гүйцэтгэх нарийн бичгийн дарга Б.Эрдэнэтулга, Хүний эрхийн Үндэсний Комиссын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Захиргаа, удирдлагын газрын дарга Т.Ихтамир, Авлигатай тэмцэх газрын Тамгын хэлтсийн дарга З.Баасанням, Улсын ерөнхий прокурорын туслах прокурор, Хэрэг эрхлэх газрын дарга Д.Чулуунбат, Цагдаагийн ерөнхий газрын Санхүү, ар талын албаны дарга Д.Батчулуун, Хил хамгаалах ерөнхий газрын дарга Ж.Бямбасүрэн, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын Тэргүүн дэд дарга А.Намсаманд, Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Д.Давааням, Шүүх шинжилгээний ерөнхий газрын дарга Н.Ганбаяр, Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах улсын комиссын Ажлын албаны дарга Л.Очирсүрэн, Дотоод хэргийн их сургуулийн дэд дарга Ц.Азбаяр, Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлгийн захирал Т.Нарантуяа, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зөвлөлийн ажлын албаны дарга Ж.Батбуян нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын асуудал эрхлэх газрын дарга Б.Хатантуул, мөн газрын Хууль зүйн байнгын хорооны ажлын албаны референт Б.Баярсайхан, Л.Хурцбилэг, Төсвийн байнгын хорооны ажлын албаны зөвлөх Ё.Энхсайхан нар байлцав.

*Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-т заасны дагуу Монгол Улсын 2027 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2028-2029 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэв.*

Төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг, Х.Баасанжаргал, О.Номинчимэг, Б.Пүрэвдорж, Л.Соронзонболд нарын тавьсан асуултад Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Ж.Энхбаяр, Хил хамгаалах ерөнхий газрын дарга Ж.Бямбасүрэн, Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Д.Давааням, Улсын ерөнхий прокурорын туслах прокурор, Хэрэг эрхлэх газрын дарга Д.Чулуунбат, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зөвлөлийн ажлын албаны дарга Ж.Батбуян, Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Н.Мягмар, Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, Шүүх шинжилгээний ерөнхий газрын дарга Н.Ганбаяр, Шүүхийн ерөнхий зөвлөлийн гүйцэтгэх нарийн бичгийн дарга Б.Эрдэнэтулга, Хүний эрхийн Үндэсний Комиссын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Захиргаа, удирдлагын хэлтсийн дарга Т.Ихтамир нар хариулж, тайлбар хийв.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Л.Соронзонболд Төсвийн болон Эдийн засгийн байнгын хорооны хуралдаанд танилцуулахаар тогтов.

*Уг асуудлыг 18 цаг 18 минутад хэлэлцэж дуусав.*

Байнгын хорооны хуралдаанаар 3 асуудал хэлэлцэв.

*Хуралдаан 2 цаг 41 минут үргэлжилж, 28 гишүүнээс 18 гишүүн хүрэлцэн ирж, 64.3 хувийн ирцтэйгээр 18 цаг 18 минутад өндөрлөв.*

**Тэмдэглэлтэй танилцсан:**

ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН  
ХОРООНЫ ДАРГА

Д.ЦОГТБААТАР

**Тэмдэглэл хөтөлсөн:**

ХУРАЛДААН ЗОХИОН  
БАЙГУУЛАХ ГАЗРЫН  
ШИНЖЭЭЧ

Э.СУВД-ЭРДЭНЭ

## ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

**Л.Соронзонболд:** Байнгын хорооны эрхэм гишүүдийн өдрийн амар амгаланг айлтгая. Байнгын хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирсэн тул Хууль зүйн байнгын хорооны 2026 оны 5 дугаар сарын 12-ны өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 7.8-д заасны дагуу хуралдааны ирцийг танилцуулъя.

Улсын Их Хурлын гишүүн Оюунсайханы Алтангэрэл, Норовын Алтанхуяг, Хүрэлбаатарын Баасанжаргал, Дамбын Батлут, Халтмаагийн Баттулга, Жудагийн Баярмаа, Гонгорын Дамдинням, Ухнаагийн Отгонбаяр, Бөхчулууны Пүрэвдорж, Пүрэвжавын Сайнзориг, Цэндийн Сандаг-Очир, Лхагвасүрэнгийн Соронзонболд, Хишигдэмбэрэлийн Тэмүүжин, Даваагийн Цогтбаатар, Саруулсайханы Цэнгүүн нарын гишүүд хуралдаа хүрэлцэн ирсэн байна. Байнгын хорооны хуралдааны ирцийг танилцуулж дууслаа.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

1.Эрүүгийн хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2025 оны 10 дугаар дүгнэлтийг хүлээн зөвшөөрсөнтэй холбогдуулан боловсруулсан, анхны хэлэлцүүлэг

2.Улсын дээд шүүхийн шүүгчид нэр дэвшигчтэй танилцах асуудал.

3.Монгол Улсын нэгдсэн төсвийн 2027 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2028-2029 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төсөл Засгийн газар 2026 оны 5 дугаар сарын 1-ний өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Төсвийн болон Эдийн засгийн байнгын хороонд хүргүүлнэ.

Хэлэлцэх асуудлаар саналтай гишүүн байна уу. Саналтай гишүүн байхгүй байна. Хэлэлцэх асуудалдаа оръё.

**Эрүүгийн хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэж эхэлье.**

Эрүүгийн хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийн танилцуулгыг ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Хишигдэмбэрэлийн Тэмүүжин танилцуулна.

**Х.Тэмүүжин:** Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Эрүүгийн хуулийн 13.16 дугаар зүйлд “хүний нэр төр, алдар хүнд, хуулийн этгээдийн ажил хэргийн нэр хүндэд халдсан, илт худал мэдээллийг олон нийтэд тараасан бол 450 нэгжээс 1300 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл 240 цагаас 720 цаг хүртэлх хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл 1 сараас 3 сар хүртэлх хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах ял шийтгэнэ.” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн 1 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн эрх чөлөө хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн, 16 дугаар зүйлийн 16 дахь заалтын үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, үг хэлэх, хэвлэн нийтлэх эрх чөлөөтэй,

мөн зүйлийн 17 дахь заалтын төр түүний байгууллагаас хууль ёсоор тусгайлан хамгаалбал зохих нууцад хамаарахгүй асуудлаар мэдээлэл хайх, хүлээн авах эрхтэй. 70 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн Үндсэн хуульд хууль бүрнээ нийцсэн байвал зохино гэж заасныг тус тус зөрчсөн байна гэсэн Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2025 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн 10 дугаар дүгнэлтийг Монгол Улсын Их Хурлын 2025 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн нэгдсэн хуралдаанаараа хэлэлцэн хуралдаанд оролцсон гишүүдийн олонх уг дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэж үзэж, Монгол Улсын Их Хурлын Үндсэн хуулийн цэцийн 2025 оны 10 дугаар дүгнэлтийн тухай 2025 оны 123 дугаар тогтоолыг баталсан билээ.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 84 дүгээр зүйлийн 84.5 дахь хэсэгт энэ зүйлийн 84.3-д заасан хууль, тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг холбогдох Байнгын хороо боловсруулж, нэгдсэн хуралдаанаар оруулна гэж заасан.

Монгол Улсын Их Хурлын даргын 2026 оны 1 дүгээр сарын 5-ны өдрийн 2 дугаар захирамжаар Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2025 оны 10 дугаар дүгнэлтийг Улсын Их Хурал хүлээн зөвшөөрсөнтэй холбогдуулан Эрүүгийн хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулж, Байнгын хорооны болон чуулганы нэгдсэн хуралдааны хэлэлцүүлэх бэлтгэх, санал, дүгнэлтийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг байгуулсан бөгөөд ажлын хэсгийн ахлагчаар Монгол Улсын Их Хурлын гишүүн Х.Тэмүүжин, гишүүдэд Монгол Улсын Их Хурлын гишүүн А.Ариунзаяа, Х.Баасанжаргал, Б.Батбаатар, Н.Батсүмбэрэл, А.Ганбаатар, С.Замира, С.Зулпхар, Ч.Лодойсамбуу, Л.Мөнхбаясгалан, Ц.Мөнхтуяа, О.Саранчулуун, П.Сайнзориг, Г.Уянгахишиг, Б.Хэрлэн, Ө.Шижир нар ажилласан болно.

Ажлын хэсэг хуулийн төслийн талаар холбогдох байгууллагуудаас санал авч, олон нийтийн хэлэлцүүлэг зохион байгуулж, ажлын хэсгийн хуралдаанаар холбогдох байгууллагын саналыг сонсож, 5 удаа хуралдаж, хуулийн төслийг дараах байдлаар боловсрууллаа. Тодруулбал,

1. Эрүүгийн хуулийн 13 дугаар зүйлийн 13.14 дүгээр зүйл буюу худал мэдээлэл тараах гэмт хэргийн зохицуулалтыг хүчингүй болсонд тооцож, хүний нэр төр, алдар хүндийг хамгаалах асуудлыг Эрүүгийн хуулийн системчлэлийн хувьд хүний хувийн улс төрийн эрх, эрх чөлөөний эсрэг гэмт хэрэгт хамааруулах нь зохимжтой гэж үзэж, хүний үндсэн эрхийн хязгаарлалтад тавих нийтлэг болон тусгай шаардлагад нийцүүлж, тус хуулийн 14 дүгээр бүлэгт 14.10 дугаар зүйл буюу Гүтгэх гэмт хэргийг зохицуулалт нэмж тусгасан.

2. Гүтгэх гэмт хэргийг зохицуулалтаар хүний нэр төр, алдар хүнд, улмаар тухайн хүний талаар гарах нийтийн үнэлэмж, түүнтэй холбоотой эрх, хууль, ёсны ашиг сонирхлыг Эрүүгийн хуулиар хамгаалахаар тусгасан бөгөөд ингэхдээ хүний нэр төр, алдар хүндийг хамгаалах болон үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх чөлөө хоорондын зохистой тэнцвэрийг хангах зарчмыг хориглосон болно.

3. Гэмт хэргийн объектив болон субъектив талын шинжийг тодорхой болгож, худал эсвэл хуурч мэдээллийг мэдсээр зориуд бэлтгэж, хүний нэр төр, алдар хүндийг гутаах зорилгоор хэвлэл, мэдээллийн хэрэгсэл, нийтийн сүлжээ, цахим хуудас, хурал, цуглаан болон эдгээртэй адилтгах олон нийтэд хүрэх боломжтой хэлбэрээр нийтлэх болон байршуулах, түгээх, амаар илэрхийлэх зэргээр олон

нийтэд тараах үйлдлийг уг гэмт хэрэгт хамааруулсан бөгөөд үүний улмаас хохирол хор уршиг учирсан бол гэмт хэрэгт тооцохоор тусгасан.

4.Гэмт хэргийн субъект нь эрүүгийн хариуцлага хүлээх чадвартай этгээд байх бөгөөд албан тушаалын байдлаа ашиглаж үйлдсэн бол хүндрүүлэх нөхцөл байдалд хамааруулахаар зохицуулсан. Түүнчлэн өөртөө эсвэл бусдад болон эдийн бус ашигтай байдал бий болгох зорилгоор хиймэл оюунд суурилсан технологи ашиглаж, захиалгаар бүлэглэж үйлдсэн, түүнчлэн бусдын эрх, хууль ёсны ашиг сонирхолд ноцтой хор уршиг учирсан тохиолдолд хүндрүүлэх нөхцөлд хамааруулах болсон.

5.Хүний үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх чөлөөг хамгаалах зорилгоор нийтийн ашиг сонирхолтой холбоотой асуудлаар үзэл бодлоо илэрхийлэх, нийтийн албан тушаалтныг шүүмжлэх үйл баримтын шинжтэй мэдээлэлд үндэслэн үнэлэлт, дүгнэлт өгөх, тухайн үед үнэн гэж үзэж үзэх хангалттай бодит үндэслэсэн мэдээлэл тараах, мөн нийтийн сүлжээ, цахим орчинд мэдээллийг өөрчлөхгүйгээр дахин түгээх, санал сэтгэгдэл бичих зэрэг үйлдлийг гэмт хэрэгт тооцохгүй байхаар зохицуулсан. Түүнчлэн бусдын гэмт хэрэг үйлдсэн талаар эрх бүхий байгууллагад мэдэгдэж, эрүүгийн хэрэгт гэрчээр оролцож байгаа бол тухайн этгээдийн гүтгэлгийн шинжтэй үйлдэл нь Эрүүгийн хуулийн 21 дүгээр бүлэг буюу Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны эсрэг гэмт хэрэгт хамаарах тул гүтгэх гэмт хэрэгт хамаарахгүй байхаар зохицуулсан.

6.Нийтийн албан тушаалтан олон нийтийн шүүмжлэлд хүлээцтэй хандах ёстой бөгөөд олон нийтэд тараасан мэдээлэл нь эсхүл хуурамч болох талаар үндэслэл бүхий тайлбар хийсээр байтал уг мэдээллийг худал эсхүл хуурамч болохыг мэдсээр байж түүний нэр төр, алдар хүндийг гутаах зорилгоор удаа дараа олон нийтэд тараасан тохиолдолд тухайн этгээдийн уг үйлдлийг үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөтэй холбоотой хамгааллын зохицуулалт хамаарахгүй байхаар тусгасан.

7.Хүний нэр төр, алдар хүндийг гутаах зорилго, худал мэдээлэл, хуурамч мэдээлэл, олон нийтэд тараасан ноцтой хохирол, хор уршиг зэргийг ойлгомжтой тодорхой болгох зорилгоор аутентик тайлбарыг хийсэн болно.

8.Эрүүгийн хуулийн 13.11 дүгээр зүйлд заасан хувь хүний нууцыг задруулах гэмт хэргийн хүндрүүлэх нөхцөлд хүний хувийн мэдээллийг хүний нэр төр, алдар хүндийг гутаах зорилгоор хууль бусаар задруулсан үйлдлийг нэмж тусгасан.

9.Хуулийн төслийг Эрүүгийн хууль болон бусад хууль тогтоомжтой нийцүүлэн боловсруулж, төслийн хууль хоорондын нийцлийг хангасан болно.

Байнгын хорооны эрхэм гишүүд ээ,

Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье. Анхаарал тавьсанд баярлалаа.

**Л.Соронзонболд:** Танилцуулга хийсэн Тэмүжин гишүүнд баярлалаа. Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан хуралдаанд оролцож байгаа албан тушаалтнуудыг танилцуулъя.

Мөнх-Эрдэнэ УЕПГ-ын Хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагаанд хяналт тавих хэлтсийн дарга, ахлах прокурор, Энхтөр Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын Нийтийн эрх зүйн хэлтсийн дарга, Батзориг Цагдаагийн

ерөнхий газрын Хуулийн хэлтсийн дарга, Дашцэрэн Цагдаагийн ерөнхий газрын Мөрдөн байцаах албаны Хүний эрх, халдашгүй байдлын гэмт хэрэг мөрдөн шалгах хэлтсийн дарга, Сэлэнгэ МУИС-ийн Үндсэн хуулийн эрх зүйн хүрээлэнгийн захирал.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39.10-д заасны дагуу хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцье.

Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт, саналтай гишүүд нэрсээ өгнө үү. Ариунзаяа гишүүнээр тасаллаа. Сандаг-Очир гишүүний микрофоныг нээе.

**Ц.Сандаг-Очир:** Гишүүддээ өдрийн мэнд хүргэе. Тэгээд энэ цэцийн дүгнэлттэй холбогдуулаад Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудал орж ирж байна. Маш олон нийтийн дунд эргэлзээ төрүүлсэн, талцал хуваагдлыг бий болгосон, энэ нэрийн дор гүтгэх, худал мэдээлэл тараах асуудал өнгөрсөн хугацаанд тэгээд хэвлэл мэдээлэл, сэтгүүлч нар маань энэ хүрээнд мэдээллийн эх сурвалж тодорхойгүй янз бүрийн мэдээлэл тарааснаасаа болж шүүх дээр янз бүрийн байдлаар ял авах, байцаагдах, шалгагдах ийм асуудлууд зөндөө гарлаа гэдэг асуудлууд, энэ нь өөрөө эргээд хэвлэл мэдээллийн салбарт, хэвлэлийн салбарынхны дуу хоолойг хааж байна, боож байна гэдэг ийм асуудлууд бол хүчтэй яригдсан. Энэ нь эргээд өөрөө бас бид бүхэн чинь хуульд 1 оруулаад л, Зөрчлийн хуулиар асуудлыг шийдээд л ингээд л явж ирсэн түүхтэй. Тэгээд өнөөдөр Цэц бол энийг бол хууль зөрчсөн юм байна гээд ингээд гаргажээ.

Ингээд гүтгэх гэдэг Эрүүгийн хуульд тусгайлан заалт шинээр оруулж ирж байгаа юм байна. Худал мэдээлэл тараана гэдгийг бол бас тусгайлан Эрүүгийн хуулиас бол авч байгаа юм байна. Гүтгэх гэдэг гэмт хэргийн нэг шинэ зүйл заалт орж ирж байгаа нь бас субъектив байдлаар яаж гүтгэж байгаа юм. Гүтгэсэн, гүтгээгүй гэдгийг яаж тогтоох юм бэ. Яаж тогтоох юм. Хэн тогтоох юм. Энд гутаах, хүний нэр, төр алдар хүндийг гутаах зорилго гэж зорилго гэдгийг яаж, хэн тогтоох юм бэ. Нөгөө талаар тухайн хүний талаар бусдад сөрөг ойлголт төрүүлэх гэдгийг бас яаж тогтоох юм. Бас л субъектив байдлаар асуудалд хандах асуудал гарч ирэх үү, үгүй юу.

Тийм учраас яг гүтгэх гэдэг энэ гэмт хэргийнхээ шинж, энэ зүйл заалтынхаа тайлбарыг бас олон нийтэд яг хоёрдмол утгагүйгээр, тэгээд энэ талаар бас олон нийтийн дунд зөв мэдээлэл өгөхгүй бол бас л эргэлзээтэй, төөргөлдөлтэй асуудлууд хэвээр байсаар байна. Тийм учраас энэ гүтгэх гэдэг гэмт хэргийгээ маш тодорхой тайлбарлаж өгөөч Тэмүүжин гишүүн ээ.

Ингэснээр цаашдаа бас энэ хүний алдар, нэр хүндэд тодорхойгүй нотлох баримтгүй зүйлээр асуудалд ханддаг, мэдээ мэдээллийг түгээдэг ийм байдал гэмт хэрэг ер нь яаж сайжирна, буурна гэж ойлгох уу. Одоогийн байдлаар ер нь өнгөрсөн хугацаанд хэчнээн ийм гэмт хэрэг шүүх дээр шийдэгдэв. Цаашдаа энэ гэмт хэргийн гаралтыг яаж бууруулна гэж ойлгож байгаа вэ. Нийгэмд ер нь гүтгэлгийн асуудал хэрхэн яаж буурах вэ гэдгийг яаж тооцоо судалгаа гэдэг юм уу хийсэн юмнууд байна уу гэдгийг нэг тодруулж асууя.

**Л.Соронзонболд:** Ажлын хэсгийн ахлагч Тэмүүжин гишүүний микрофоныг нээе.

**Х.Тэмүүжин:** Үндсэн хуулийн цэцээс Эрүүгийн хуулийн 13.14-ийг Үндсэн хууль зөрчсөн байна гэж үзсэн. 13.14 буюу худал мэдээлэл тараах гэдэг энэ гэмт хэрэг

дотор бодит байдал дээрээ бол 3 гэмт хэрэг холиод биччихсэн байсан. Өргөн агуулгатай гэсэн үг. Худал мэдээлэл тараах гэдэг гэмт хэрэг бол бидний уламжлалт гүтгэх гэмт хэрэг гэдэг ойлголтоос бол тэс өөр гэмт хэрэг уг нь байлаа. Ер нь бол сүүлийн 20 жилд улс орнуудад шинээр хуульчилж байгаа, Эрүүгийн хууль руугаа ийм шинээр бичиж байгаа гэмт хэрэг. Худал мэдээлэл тараах гэдэг нь.

Худал мэдээлэл тараах гэмт хэрэг нь ямар агуулгатай вэ гэхээр анх бол манай 2 хөршөөс бараг эхэлсэн байх. Ардчилсан улс орнууд бол энэ бол дарангуйлагч буюу авторитар дэглэм өөрөө өөрийнхөө дэглэмийг хамгаалахын тулд Эрүүгийн хуульдаа ийм үг, үсэг оруулж ирж байна. Худал мэдээлэл тараах гэдэг гэмт хэрэг бичлээ гэж шүүмжилж байсан юм. Гэтэл 10-аад жилийн дараагаас Англиас авхуулаад энэ төрлийн гэмт хэргийг өөрсдөө бичиж эхэлсэн. Зорилго нь юу вэ гэхээр худал мэдээлэл тараасны улмаас үндэсний аюулгүй байдалд эрсдэл учирч байгаа тэр төрлийн гэмт хэргийг бол энэ гэмт хэргээр уг нь бичсэн юм байна лээ. Манайхаар бол материаллаг бүрэлдэхүүнтэй гэж хэлдэг. Худал мэдээлэл тараасны улмаас хүний амь нас эрсэдсэн, нийгэмд үзэн ядах буюу дайсагнах үзэл хавтгайрч нийгэм олон нийт хуваагдаж хүчирхийлэл гаарсан, эд хөрөнгийн томоохон хохирлууд учирсан гэх мэтчилэн ийм объектив хохирлуудыг бичиж байгаад, нийгэмд ийм байдал үүссэн бол энийг үүсгэсэн, худал мэдээллийг тараасан этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээнэ гэдэг энэ зарчмыг тавьсан юм байна лээ.

Манайх бол энэ төрлийн гэмт хэргийн гарчгийг тавиад, худал мэдээлэл тараах гэдэг гэмт хэргийн гарчиг тавьчхаад, дотор нь гүтгэх, доромжлох маягийн гэмт хэргээ биччихсэн. Тэгээд ерөнхийдөө бас хэт ерөнхий байдлаар томъёолчихсон учраас сүүлдээ энэ нь Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтэд дурдагдсанчлан иргэний үзэл бодлоо илэрхийлэх, үг хэлэх болон хэвлэн нийтлэх эрх, эрх чөлөө рүү хязгаарласан ийм хязгаарлалт ороод ирчихсэн байна. Тийм учраас Үндсэн хуулийн энэ зохих заалтуудыг бол зөрчсөн гэж бид үзэж байна. Ийм, ийм асуудлууд дээр бол анхаарах ёстой гээд тэр үндэслэл хэсэг дээр нэлээн дэлгэрэнгүй биччихсэн байна лээ.

Тэгээд үндэслэл хэсэг дотор байгаа зүйл дээрээ хүний нэр төрийг Эрүүгийн хуулиар хамгаалахыг бол Үндсэн хууль зөрчсөн гэж үзээгүй шүү. Энэ гэмт хэргээ томъёолохдоо хэтэрхий ерөнхий томъёолсон байгаа байдлаас чинь болоод иргэний үзэл бодлоо илэрхийлэх, хэвлэн нийтлэх эрх чөлөө хязгаарлагдаж байна гэдэг тийм тайлбар хийсэн. Тийм учраас бид худал мэдээлэл тараах .../минут дуусав/

**Л.Соронзонболд:** Тэмүүжин гишүүний микрофоныг нээе.

**Х.Тэмүүжин:** Худал мэдээлэл тараах гэдэг энэ гэмт хэргийг бол Эрүүгийн хуулиас бол хасаж байгаа. Тэрний дотор байгаа гүтгэх гэдэг гэмт хэргийг буцааж Эрүүгийн хуулийн тэгэхдээ хувь хүний эрх, эрх чөлөөний тэр хэсэг дээр нь яг ийм байдлаар томъёолбол боломжтой байна гэдэг байдлаар ажлын хэсгээс бол санал болгож байгаа. Энэ худал мэдээлэл тараах гэдэг гэмт хэргийн шүүхээр шийдэгдсэн хэргийг харахаар шүүхээр шийдэгдсэн статистик дотор сэтгүүлчийн орсон, холбогдсон хэрэг нь бол 2 байсан уу, 1 байсан уу, 5 сэтгүүлч холбогдсон. Хамгийн дуулиантай нь бол бид бол 2 гэмт хэргийг нь мэдэж байгаа. Бусад нь бол ерөөсөө иргэд хоорондоо гомдол, санал гаргасан. Энэнээс болоод гэр бүл салсан, ажлаасаа халагдсан, ийм хэмжээний хохирол учирсан гэдэг ийм статистик байгаа юм байна лээ.

Гэхдээ дахиад өөр нэг статистик харах юм бол цагдаагийн.../минут дуусав/

**Л.Соронзонболд:** Тэмүүжин гишүүний микрофон нээж, хариултыг гүйцээе.

**Х.Тэмүүжин:** Цагдаагийн байгууллага дээр шалгагдаж байгаа хэргийн бас цөөнгүй хэсэг нь сэтгүүлчидтэй холбоотой хэрэг байдаг. Иргэний үзэл бодлоо илэрхийлсэнтэй холбоотой асуудлууд байгаад байдаг. Тэгээд тэр нь залхаан цээрлүүлэх маягтай эффект өгөөд сэтгүүлчид нийтдээ ер нь бол энэ шүүхээр шийдэгдсэн дуулиантай 2, 3 хэргээс болоод хэвлэн нийтлэх болон үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө дээр ер нь бол аюул заналхийлэл болон хязгаарлалт тогтоогдоод байна гэдэг шүүмж явсан юм байна лээ.

Тэгээд ямар ч байсан Эрүүгийн хууль дээр энэ төрлийн гэмт хэрэг бичигдэнэ гэдэг нь бол мэдээж хэрэг энэ төрлийн маргаан, гэмт хэргийг багасгах зорилго л байгаа шүү дээ. Эрүүгийн хуулиас хасаад, иргэний журмаар бас маргалдаад асуудлаа шийдүүлж болно гэдэг байр суурьтай бас хүмүүс байгаа. Тэр нь дийлэнх нь бол манай сэтгүүлчид болон хүний эрхийн чиглэлээр ажилладаг төрийн бус байгууллагуудаас ирсэн зөвлөмж дотор бол ийм байгаа. Дээд шүүх болон хуулийн байгууллагууд болон Хууль зүйн яамнаас ирсэн зөвлөмж .../минут дуусав/

**Л.Соронзонболд:** Сандаг-Очир гишүүн тодруулъя.

**Ц.Сандаг-Очир:** Энд ингэж байгаа юм. Дараах тохиолдлыг энэ зүйлд заасан гэмт хэрэгт тооцохгүй гээд. Нийтийн ашиг сонирхолтой холбоотой асуудлыг хөндөж, үзэл бодлоо илэрхийлсэн бол гээд. Энэ бол нийтлэг асуудал. Тэгээд сэтгүүлчдийг үзэл бодлоо илэрхийлсэн, дуу хоолой болсны төлөө аливаа гэмт хэргийн шинжтэй Эрүүгийн хуулиар яллах ийм асуудал нь бас хэр хязгаарлагдаж байгаа вэ. Энийг манай хуулийнхан, мөрдөн байцаагч нараас авхуулаад ер нь тэр сэтгүүлчийн нийтэлсэн мэдээ мэдээллийг ямар зорилгоор, ямар агуулгаар яаж тавьсан бэ гэдгийг нь яаж ялгаж, тэгээд сэтгүүлчдийг хэвлэн нийтлэх эрх чөлөө, үүргээ гүйцэтгэсний төлөө эрүүгийн хариуцлага хүлээлгэхгүй байх тэр асуудлыг яаж хязгаарлаж байгаа вэ гэдгийг та нэг тайлбарлаж өгөөч.

**Л.Соронзонболд:** Ажлын хэсгийн ахлагчийн микрофон. Тэмүүжин гишүүний микрофоныг нээе.

**Х.Тэмүүжин:** Нэмэлтээр бас манай ажлын дэд хэсгээс тайлбарлах байх. Ер нь бол гэмт хэргийн үйлдлийг бичиж байгаа 14.10.1 дээр хүний нэр төр, алдар хүндийг гутаах зорилгоор гээд зорилго бичиж байна гэдэг бол зорилгыг нотлох бас их төвөгтэй байдаг. Тийм учраас хууль дээр зорилго бичиж байна гэдэг нь энэ гэмт хэрэг болно гэдэг өндөр шалгуурыг давна гэсэн үг болчхож байгаа байхгүй юу. Зорилгыг нь тогтоож чадахгүй л бол гэмт хэрэг биш болно гэсэн үг шүү дээ. Тэгэхээр энэ чинь өөрөө сэтгүүлчдийн болон иргэдийг үзэл бодлоо илэрхийлсэн болон хэвлэн нийцсэнийх нь төлөө энэ хууль чинь ингээд бөөнөөр нь асуудал үүсгээд байх юм биш биз дээ гэдэг болгоомжлол дээр бас 1 хаалт болно гэсэн үг.

2-т нь энэ гэмт хэргийн улмаас хүний эрх, хууль ёсны, ашиг сонирхолд хохирол, хор уршиг учирсан бол гээд дахиад материаллаг бүрэлдэхүүн тавьчихаж байгаа юм. Тэгэхээр хохирсон гэдэг хохирол, хор уршигийнх нь материаллаг бүрэлдэхүүн илрэхгүй бол бас дахиад гэмт хэрэг болохгүй гэсэн үг байхгүй юу. Тэгэхээр ингээд 2 том шалгуур гараад ирж байна гэсэн үг. Дээр нь дахиад энэ аутентик тайлбар хийсэнтэй холбоотойгоор юу болж байгаа вэ гэхээр тайлбарын хэсэг дээр түрүүний асуултад асуусан гутаах зорилго гэж юу хэлэх вэ гэхээр нөгөө үнэлэмжийг бууруулах санаа чиглэлтэй байна гээд бас хэмжигдэхүйц болгоод тавьчихаж байгаа

юм. Тэгэхээр Үндсэн хуулийн цэцийн энэ хэмжигдэхгүй, бүрхэг байгаа ерөнхий ойлголтууд чинь гэж ярьж байгаа зүйл дээр бид бол тодорхой хэмжээний хэмжигдэхүүн тавьчихаад, саяын таны асуулт дээр нийтийн ашиг сонирхолтой холбоотой хэлэлцүүлэг өрнүүлэх болон тийм шүүмж явбал энэ гэмт хэрэг рүү орж ирэхгүй шүү гэдэг тодорхойлолт тавьчихаар албан тушаалтантай холбогдуулаад нийтийн ашиг сонирхолтой шүүмж өрнүүлж байгаа, хэлэлцүүлэг өрнүүлж байгаа энэ үйл явц дотор өртөж байгаа мэдээллийг шууд хүнийг гүтгэж байна гэж үзэхгүй гэдэг ийм хэмжүүрийг бас тодорхой хэмжээгээр тавьчихаж байгаа юм.

Дээр нь дахиад 1 зүйл нь юу вэ гэхээр энэ ард байгаа.../минут дуусав/

**Л.Соронзонболд:** Сандаг-Очир гишүүн тодруулах уу. Сандаг-Очир гишүүн тодруулъя.

**Ц.Сандаг-Очир:** Тэгэхээр би энэ дээр жишээ нь Булгантуяа Улсын Их Хурал удирдсаныхаа төлөө, даргалсныхаа төлөө эрүүгийн ял авч болохгүйтэй адилхан хэвлэл мэдээллийнхэн ажлаа хийснийхээ төлөө, дуу хоолой болсныхоо төлөө, хэвлэн нийтлэх эрхээ эдэлснийхээ төлөө бас гэмт хэргийн буруутан болж болохгүй шүү. Энийг тэгэхдээ нийтээр нь хавтгайруулж бас ойлгож болохгүй. Тийм учраас энэ хуулийн өөрчлөлт нь бол гүтгэх гэдгийг маш тодорхой оруулж ирж байгаа нь бас сайшаалтай байна. Өнөөдрийн Монголын нийгэм бол бас гүтгэх гэдэг асуудлаар дүүрчихсэн байна. Бүх шатандаа. Тийм учраас энийг бас худал мэдээлэл тараах гэдгээс бас ялгах гэж, тэгэхдээ би амьдрал дээр яаж хэрэгжихийг сайн мэдэхгүй байна. Саяын яг таны хэлдэг шиг зорилго бүхий нэр хүнд, алдар хүнд, албан тушаалынх нь нэр хүндийг унах зорилгоор гэдгийг чинь бас л буруугаар хэрэглээд явчих, тэгээд хор хохир хохирол учирсан гэдгийг яаж тогтоох юм гэдгээс авхуулаад ийм субъектив байдлаар хандах нөхцөлүүд бас байгаад байна шүү. Тэгэхээр энэ чинь бас хууль цаашдаа амьдрал дээр бас л яг нэг мөр хэрэгжиж болохгүйгээр энэ хүүдийн дотор бас л нөгөө сэтгүүлчдийг буруутгах гэдэг юм уу, Эрүүгийн хуулиар яллах ийм нөхцөл байдал чинь бас бүрэн дүүрэн арилахгүй байх нөхцөл үүсчих вий дээ гэдэг дээр би бас санаа зовж л байна.

**Л.Соронзонболд:** Сандаг-Очир гишүүн үг хэллээ. Алтангэрэл гишүүний микрофоныг нээе.

**О.Алтангэрэл:** Эрүүгийн хууль бол нийгмийн харилцааг хамгаалдаг хууль. Хүний эд хөрөнгийг, эрүүл мэндийг, амь насыг, бүгдийг нь Эрүүгийн хуулиар хамгаалдаг. Өнөөдөр Монгол Улсад яг өнөөдөр бол Эрүүгийн хууль хүний нэр төр гээч зүйлийг хамгаалахгүй байгаа юм. Өнөөдөр амьдрал бол зөвхөн энэ төрийн ордон дотор юм уу, Улаанбаатар хотод үргэлжилдэггүй. Өнөөдөр сумын багш эмэгтэйг сумынх нь групп дээр элдвээр доромжилж бичээд, Цагаан хаданд ажиллаж байсан нөхөр нь ирээд хүчирхийлэл үйлдээд, цагдаа сэргийлэхээр явж байгаа асуудал байна. Гүтгэсэн этгээдийг олж өгөөч гээд эмэгтэй сумынхаа хэсгийн төлөөлөгч рүү хандахад өнөөдөр цагдаагийн байгууллага Эрүүгийн хуульд энэ төрлийн гэмт хэрэг байхгүй учраас ямар ч ажиллагаа хийх боломжгүй байгаа.

Өнөөдөр Иргэний хууль байгаа л гэнэ. Ер нь бол иргэн хүн сумын төвд, аймгийн төвд, хөдөө, ер нь иргэн хүн өөрөө нэхэмжлэл гаргаад, өмгөөлөгч аваад, шүүхэд хандаад хэдэн жил яваад асуудлаа шийдвэрлүүлнэ. Энэ дээр та нарт нээгээд өгчихсөн ингэж хаяж болохгүй. Бид нар ямар нэг байдлаар Эрүүгийн хуульдаа энэ асуудлыг оруулах ёстой. Би өөрөө хуульч, судлаачийн хувьд 10 гаруй жил энэ асуудлыг боловсронгуй болгох ёстой. Эрүүгийн хуульд байх ёстой гэдгийг дэмжиж

ярьж байгаа хүн байгаа юм. Энэ удаад орж ирж байгаа төсөл дээр харин аутентик тайлбар хийгээд, яг манай энэ сэтгүүлчдийн яриад байдаг зүйлүүдийг бүгдийг нь сайхан тусгачихсан байна. Тоо баримт худлаа мэдээлэхэд гэмт хэрэгт тооцохгүй болсон байна. Энэ нийтийн албан тушаалтан буюу төрийн албан хаагч улс төрд нөлөө бүхий албан хаагчид улс төрчдийг шүүмжлэхэд Эрүүгийн хуульд тооцохгүй болсон байна гээд зөндөө олон дэвшилттэй зүйл орж ирж байна.

Яг судлаад үзэх юм бол дэлхийн улс орнуудын 80 гаруй хувь нь энэ гүтгэх, доромжлохтой холбоотой харилцааг Эрүүгийн хуулиараа зохицуулж байгаа. Бид нар дэлхийн нийтийн жишгээс гажихгүй ээ. Өнөөдөр цагдаагийн байгууллага дээр хүн очоод өргөдөл гомдол гаргаад, намайг ингэж гүтгэлээ, ингэж дайрч доромжиллоо. Нэр усаа нууж ингэж гутаалаа, миний гэр бүл, үр хүүхэд рүү ингэлээ, насанд хүрээгүй хүүхэд рүү минь ингэж дайрч байна гэхэд цагдаагийн байгууллага өнөөдөр шалгах бололцоогүй л байгаа.

Тэгэхээр би ажлын хэсгийнхнээс нэн ялангуяа цагдаагийнхнаас асуух гэж байгаа юм. Одоо энэ гэмт хэрэг байхгүй болсноос хойш цагдаагийн байгууллага энэ асуудлыг яаж шийдэж байна. Хэчнээн иргэнээс өргөдөл гомдол ирэв. Цаашдаа ер нь энэ асуудал ингээд хуримтлагдаад яваад байвал ямар үр дүн гарахаар байна. Та бүхэн энэ дээр ямар байр суурьтай байна. Би энэ ажлын хэсэг, цагдаагийн байгууллагаас асуулт асууя.

**Л.Соронзонболд:** Ажлын хэсгийн гишүүн индэр дээрээс хариулна. Индэр дээрээс өөрийгөө танилцуулаад, хариулъя. Пүрэвдорж гишүүнийг нэмье.

**Б.Дашцэрэн:** Та бүхний амрыг эрье. Би Мөрдөн шалгах албаны Хүний эрх, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг мөрдөн шалгах хэлтсийн дарга, цагдаагийн дэд хурандаа Дашцэрэн гэж хүн байна. Саяын Алтангэрэл гишүүний асуусан асуултад хариулъя.

Цагдаагийн байгууллагад, 2022 оноос 2026 оныг өнөөдрийг хүртэл нийт 1046 хэрэг бүртгэлтийн хэрэг шалгагдсан байгаа. Үүнээс яг шүүхэд шилжүүлэх саналтай 135 хэргийг шүүхэд шилжүүлсэн байгаа. Мөн сэтгүүлч нартай холбоотой бол энэ хугацаанд 34 гомдлыг шалгасан. Яг сэтгүүлчидтэй холбоотой.

Мөн дээрээс нь сая 2025 оны 11 сарын 25-ны өдөр Үндсэн хуулийн цэцээс 10 дугаар дүгнэлт гарсантай холбогдуулан нийт иргэдээс 317 гомдол ирсэн. Тухайн 317 гомдлыг бол мөрдөн шалгах байгууллагаас хүлээн аваад, ямар ч байсан мөрдөн шалгах ажиллагааг нь явуулаад, тэгээд прокурорт танилцуулаад татгалзаж байгаа. Яг хуулийн зохицуулалттай холбоотойгоор Үндсэн хуулийн цэцэд түдгэлзүүлснээс хойш. Тэгэхээр иргэдээс цаашид бол маш их гомдол гаргах энэ хандлага өсөх, иргэдийн энэ нэр төрд халдах асуудал бол өргөдөл нь ихээр нэмэгдэж байгаа.

Тэгэхээр цагдаагийн байгууллага бол хуулиар батлагдаад нэгэнт ороод ирэх юм бол шалгах аас өөр арга байхгүй. Шалгана. Гэхдээ энэ хуульд орсон өөрчлөлтийн дагуу бид нар мөрдөн шалгах ажиллагаа явуулна л гэж ойлгож байгаа.

**Л.Соронзонболд:** Алтангэрэл гишүүн тодруулъя.

**О.Алтангэрэл:** Сая тэр өргөдөл гомдол гаргаж, өнгөрсөн жилүүдэд шалгачихсан статистик хэллээ. Тэгээд эндээс ер нь яг бодитой иргэдэд хохирол

учруулаад байгаа тодорхой төрлийн кэйс та нэрлэж чадах уу. Тийм бол тодорхой дурдаач.

**Л.Соронзонболд:** Индрийн микрофоныг нээе.

**Б.Дашцэрэн:** Эндээс нэг жишээ дурдах зүйл гэвэл нэрийг нь хэлээд яах вэ. Ер нь бол гэр бүлийн асуудал дээр аягүй их асуудал яригдаж байгаа. Ямар нэгэн групп дээр хуурамч хаягаас юм уу, фэйсбүүк сошиал орчинд портал хаягаас хуурамчаар эдний нөхөр тэр нь тэрэнтэй явалддаг, энэнтэй явуулдаг гэсэн асуудлаас болж гэр бүл 1 дүгээрт цуцлах, гэр бүл салах асуудал, дээрээс нь нөгөө хүн амиа хорлоход хүрэх гэж байгаа ийм асуудлууд бас байгаад байгаа юм. Тэр нь бол бодит жишээ. Шүүхээр ороод шийдвэрлэгдчихсэн ийм асуудал байгаад байгаа.

**Л.Соронзонболд:** Алтанхуяг гишүүний микрофоныг нээе.

**Н.Алтанхуяг:** Манай ажлын хэсгийнхэн сайн ажилласан байлгүй. Би энэ их сургуулийн юу гэлээ. Та миний нэг эргэлзээг тайлаадхаач. Яг иймэрхүү төрлийн юм яг Эрүүгийн хуулиар шийдэгддэг юм уу. Олон улсын практик дээр яг ямар байдаг юм. Иргэний гээд явахаар энэ сая Алтангэрэл гишүүний хэлж байгаа шиг юу ч биш болоод завхарчхаад ингээд байна уу. Энэ зайлшгүй ийм шаардлагатай юу.

Би бол ер нь нэг юмнаас их болгоомжилдог юм. Хэлмэгдүүлэлт л гарчих вий л гэж. Ялангуяа өнөөдөр энэ хууль хяналтын байгууллагын хүмүүс өөрснөө хариуцлага хүлээлгэдэг тэр механизм нь байхгүй байхад, тэгээд дээрээс дохио зангаагаар ажилладаг ийм нөхцөлд их л хэцүү л юм байна лээ л дээ. Алтангэрэл гишүүн ээ, би бол тийм юманд их санаа зовж байгаа юм. Үнэхээр хилс хэргээр хүнийг хэлмэгдүүлчхэж байгаа тэр этгээдүүд нь өөрснөө хариуцлага хүлээдэг тийм хууль зүй үүнтэй давхар явж байдаг бол болмоор байгаа. Жишээ нь, прокурор нь, жишээ нь мөрдөгч нь, жишээ нь шүүх нь. Тийм байгаа юм уу Баасанжаргал гишүүн. Хэрвээ тэгэхгүй бол энэ бол аймар хэлмэгдүүлэлт.

Би өөрөө энэ цагдаад бас миний нэр төрийг ингэлээ гээд ингэдэг явдаггүй юм байна лээ шүү дээ хөөрхий. Угаасаа ч бас тэгээд эд нар маань тэрийг илрүүлэх гээд жаахан тэгж байснаа тэгээд хаячихдаг л юм шиг байна лээ. Би бүр шүүхээр заргалдаад заргаа авч байсан. Би бас амьхандаа нэлээн их мөнгөөр торгочихвол бас хашрах болов уу гэж бодоод нэрийг нь хэлээд яах вэ тэрбум төгрөг нэхсэн чинь шүүх надад 1 сая төгрөгийн, тэр 1 сая төгрөг чинь өмгөөлөгчийнхөө хөлийг ч төлж барахгүй. Ингээд миний энэ салбарын мэдлэг угаасаа хомс учраас би ингээд ерөнхийдөө хүчин мөхөстөөд хаясан. Энэ зөвхөн миний асуудал биш байхгүй юу. Иргэний эрх энэ дээр асар их зөрчигдөөд л яваад байгаа юм л даа. Тэгээд Баасанжаргал байна, Алтангэрэл байна, Тэмүүжин байна, би бол та нарыг л харж даган баясах гэж байна. Надад бол ийм болгоомжлол байгаа шүү. Тэгээд та нэг үнэхээр олон улсын практикт бол ийм юмыг ингэдэг юм гэдгийг хэлээд өгөөч.

Сэтгүүлчдэд бас болгоомжлол байгаа шүү дээ. Эртээд тэр цагдаагийнхан нэг хүүхнийг аваад явлаа. Тэрийг ингэлээ гээд л ийм юм л бага гаргаж үзээрэй та нар минь. Тэгээд Цэцийнхээ тавьсан хоригийг зөв аваад, хуулиа зөв л найруулаад өгөөч гэж би хүсэж байна. Би асуултдаа хариулт авчихъя.

**Л.Соронзонболд:** Ажлын хэсгийн индрийн микрофоныг нээе.

**Х.Сэлэнгэ:** МУИС-ийн Үндсэн хуулийн эрх зүйн хүрээлэнгийн зүгээс Улсын Их Хурлын гишүүн Тэмүүжин гишүүний хүсэлтээр бид харьцуулсан судалгаа хийсэн. Ер нь эрүүгийн эрх зүйн шинжлэх ухааны хүрээнд бол гүтгэх гэмт хэрэг гэдэг бол аль эртнээс байсан, одоо ч байгаа. Гэмт хэргийн тодорхой нэг гэмт хэрэг гэж хэлж болно. Энэ харьцуулсан судалгааг аваад үзэх юм бол жишгийн болоод эх газрын эрх зүйн бүлийн хүрээнд бол гүтгэх гэмт хэрэг гэдэг бол тодорхой бүр хүний эрхийн эсрэг гэмт хэрэг гэдгээрээ маш том төрөлжсөн гэмт хэрэг байгаа.

Харин гүтгэх гэмт хэргийн дотор бол худал мэдээлэл тараах гэмт хэрэг гэдэг ийм зүйл заалт бол тодорхой хэмжээнд явж байна лээ. Харин энэ гүтгэх гэмт хэргээс гадна бусдын нэр хүндэд тодорхой баримт дээр үндэслэж бусдын нэр хүндийг гутаасан байгаа тохиолдолд баримтын үнэн зөвийг харгалзахгүйгээр эрүүгийн хариуцлага хүлээлгэдэг ийм жишиг бол олон улсын хэмжээнд байна. Тэр тусмаа энэ гэмт хэрэгт бол хорих ялтай ийм зүйл заалттай байгаад байгаа юм.

Тэгэхээр эндээс би юу гэж хэлэх гээд байна вэ гэхээр манай эрүүгийн эрх зүйн шинжлэх ухааны хувьд бол бусдын нэр хүндэд халдах, гүтгэх гэмт хэрэг гэсэн энэ 2 гэмт хэрэг бол тусдаа ийм зүйл заалттай гэмт хэрэг бөгөөд гүтгэх гэмт хэрэг дотор нь бол худал мэдээлэл тараах гэмт хэрэг явж байгаа. Манай судалгаа бол макро түвшний харьцуулсан судалгаа хийсэн.

Тэгэхээр дэлхий улс орнуудын хувьд бол энэ бусдын нэр хүндэд халдах, гүтгэх гэмт хэрэг бол албан ёсны хууль зүйн хариуцлага хүлээлгэдэг ийм зүйл заалт бүхий гэмт хэрэг байгаа. Энэ ажлын хэсгийн хүрээнд бид бол бүхэл бүтэн энэ манай хүрээлэнгээс харьцуулсан судалгаа хийгээд ийм том материал өгсөн байгаа. 1 жишээ хэлье. Жишээлэхэд, Япон Улсын Эрүүгийн хуулийн 230 дугаар зүйлд олон нийтийн өмнө баримт мэдээллийг дэлгэж, бусдын нэр хүндэд халдсан этгээдийг тухайн баримт мэдээлэл үнэн зөв эсэхээс үл хамаарч 3 жил хүртэл хугацаагаар албадан хөдөлмөр эрхлүүлэх эсвэл хорих ялаар шийтгэх, өөрөөр хэлбэл 3 жилийн хорих ялаар шийтгэх эсвэл 500 мянган иен хүртэл хэмжээний торгох ялаар шийтгэнэ гэсэн ийм заалт байгаад байгаа. Эндээс тусдаа гүтгэх гэмт хэрэгт тодорхой ийм нэлээн хэд хэдэн зүйл заалт бүхий ийм гэмт хэргийг бол хуульчилсан байгаа гэж хэлмээр байна. Тийм учраас хууль тогтоогч та бүхнийг Монгол Улсын Үндсэн хуулийн 19.1-д заасан хүний эрх чөлөөг бол хууль зүйн баталгааг хангана гэсэн энэ зүйл заалтаа хэрэгжүүлж, энэ ажлын хэсгээс оруулсан энэ .../минут дуусав/

**Л.Соронзонболд:** Алтанхуяг гишүүн тодруулъя.

**Н.Алтанхуяг:** Баярлалаа. Та нар судалгаа шинжилгээ хийж байгаа учраас үндэстэй юм ярьж байгаа гэж ойлгож байна. Би ажлын хэсгийн ахлагчаас асуух гэж байгаа юм. Энэ дээр ингээд биччихээд байна шүү дээ. Нийтийн албан тушаал эрхэлж байгаа эсхүл эрхэлж байсан хүнийг албан тушаал үйл ажиллагаатай нь холбогдуулан шүүмжилсэн тэрний дээд тал дээр үзэл бодлоо илэрхийлсэн эд нарыг яаж ялгадаг юм. Шүүмжилж байгаа үзэл бодлоо илэрхийлж байгаа юм. Шүүмжлэл гэж ер нь юу юм. Энэ яг нэгдсэн нэр томъёо байгаа юм уу. Ялгадаг юм уу. Дараа нь очоод нөгөө шүүх дээр чинь энийг ингээд өөр өөрөөр тайлбарлаад унахгүй биз. Тэмүүжин гишүүн. Та нарын нэр томъёогоо зөв сонгосон юм уу гэж.

Дараа нь нэг ийм асуулт байгаа юм. Бусдыг гэмт хэрэгт үйлдсэн гэсэн мэдээллийг олон нийтэд тараасан этгээд энэ дотор хууль хяналтын байгууллагын хүмүүс орж байгаа юу. Дээр үед бид нарын үед аймар мэдээлдэг байсан. Сүүлийн

үед бас ихэсчихсэн байна лээ шүү дээ. Тэр нөхөр бол шалгагдаж байгаа нь үнэн болно. Энэ болж байгаа юм уу, болохгүй байгаа юм уу. Иймэрхүү юм энэ дотор орж байгаа юм уу, орохгүй байгаа юм уу. Ийм хэдэн асуултад хариулт аваадахъя.

**Л.Соронзонболд:** Ажлын хэсгийн ахлагч Тэмүүжин гишүүний микрофоныг нээе.

**Х.Тэмүүжин:** Тэр нийтийн албан тушаал эрхэлж байгаа, эсхүл эрхэлж байсан хүнийг албан тушаа, үйл ажиллагаатай нь холбогдуулж шүүмжилсэн бол гээд. Энэ тохиолдолд шууд гэмт хэрэг болохгүй шүү гэдэг агуулга илэрхийлж байгаа юм. Дахиад тэр доор нэг ийм үг байгаа шүү. Нийтийн албан тушаал эрхэлж байгаа, эсхүл эрхэлж байсан хүн нь өөрийн албан тушаал үйл ажиллагаатай нь холбогдуулан олон нийтэд тараасан сөрөг мэдээлэлд тайлбар хийх бөгөөд уг мэдээллийг худал эсхүл хуурамч болох талаар үндэслэл бүхий тайлбар хийсээр байтал мэдээлэл тараасан этгээд энэ зүйлд заасан зорилго, сэдэл, агуулга хэлбэрээр удаа дараа олон нийтэд тараасан бол гээд энэ нь болохоор юуг илэрхийлж байгаа вэ гэхээр нийтийн албан тушаалтан өөрийнх нь үйл ажиллагаа, албан тушаалтай нь холбогдуулж иргэд шүүмж өрнүүлэх, эсхүл хардаж бичих юм бол шууд шүүх рүү гомдол гаргахгүй шүү гэсэн санаа шууд энд явж байгаа.

Та бол тайлбар хийх үүрэгтэй. Шүүмжлэхийг бол гүтгэхээс ялгаж энэ тохиолдолд бичиж байгаа бид. Яагаад гэвэл шүүмжлэх гэдэг чинь ер нь бол олон нийт нийтийн албан тушаалтантай холбогдуулан үйл ажиллагааг нь зөв явж байна уу, хууль ёсны явж байна уу гэдэг дээр хардаж, эргэлзэж асуулт асуух эрхтэй. Энэ асуултынхаа хүрээнд асуудалд шүүмжлэлтэй хандахыг нь энэ гэмт хэрэгт оруулахгүй шүү. Гүтгэх гэдэг нь бол тэр гэмт хэргийнхээ 1 дүгээр зүйл дээр маш тодорхой биччихсэн. Худал эсхүл хуурамч мэдээллийг мэдсээр байж нийтийн албан тушаалтан дээр гүтгэсэн ийм асуудал хөндөгдөх юм бол энэ асуудалтай нь холбогдуулаад шууд намайг гүтгэчихлээ гэж гомдол гаргахгүйгээр та тайлбар өгөх үүрэгтэй шүү. Яагаад гэвэл бусад хуулиар төр ил тод, нээлттэй байх үүднээс тайлбарлах ёстой. Тайлбарласаар баримт гаргаж хэлсээр .../минут дуусав/

**Л.Соронзонболд:** Баасанжаргал гишүүний микрофоныг нээе.

**Х.Баасанжаргал:** Надад нэг ийм асуулт байна. Уучлаарай би ажлын хэсэгт өөрөө хэдийгээр орсон ч гэсэн сүүлийн яг санал хураалттай хуралдаан дээр байгаагүй. Гадагшаа томилолтоор явж байсан учраас бас яалт ч үгүй асуух ... асууж болохгүй юм уу. Үг хэлэх юм уу.

Энэ нөгөө 2.2 дээр жишээ нь, манай уяачид хиймэл оюун ухаанаар бичлэг хийгээд, намайг тэвэрч аваад үнэрлээд байгаа юм уу, үнсээд байгаа юм уу тийм бичлэг хийгээд тараасан. Жишээ нь цахим орчин дээр. Тэр жишээ нь яг энэ 14.10-ын 2.2 луу орохоор харагдаад байгаа байхгүй юу. Тийм байгаа биз. Сөрөг гэх нь хаашаа юм. Тэрийг бас эерэг гэх нь хаашаа юм. Тэгээд тэр нь өөрөө мэдээлэл нь над дээр харагддаггүй, бусад хүмүүс дээр харагдаад байдаг. Над руу хуваалцахаар намайг блокчлоход надад огт харагдахгүй байгаа. Тэгэхээр энэ жишээ нь яг энэ эрүүгийн гэмт хэргийн хариуцлага хүлээхээр болж байна уу. Тэгэхээр нийтийн албан тушаалтай хамаарахгүй гэхээр нийтийн албан тушаалтны үйл ажиллагаатай холбогдуулж гээд байгаа байхгүй юу. Тэгэхээр тэрийг яг миний үйл ажиллагаатай холбоотой гэж тайлбарлах уу. Зөвхөн субъектээр нь юм уу, субъектийг нь үйлдэлтэй нь холбож, нэмж объектив байдлаар явах юм уу гэдэг ийм асуулт гэсэн үг байхгүй юу. Ийм кэйс яг бодитой кэйс гэсэн үг.

2 дугаарт тухайн үедээ хурал дээр хэрвээ байсан бол миний гол санал юу байсан бэ гэвэл сэтгүүлч, хэвлэл мэдээллийн байгууллагыг үндсэн үйл ажиллагаатай холбоотойгоор гаргаж байгаа мэдээлэл нь өөрөө энэ гэмт хэрэгт хамаарахгүй гэдэг байдал нэмж бичих боломж байсан уу л гэдэг ийм асуулт байгаа.

**Л.Соронзонболд:** Баасанжаргал гишүүн үг хэлж, санал хэллээ. Ариунзаяа гишүүн.

**А.Ариунзаяа:** Би мөн ажлын хэсэгт байгаа учраас үг хэлнэ. Мөн түүнчлэн Байнгын хороонд харьяалагддаггүй учраас Байнгын хорооны гишүүддээ хандаж үг хэлнэ. Та бүхэн маань бидний боловсруулсан энэ төслийг бас дэмжиж өгөхийг хүсэж байгаа юм.

Яагаад гэхээр ажлын хэсгийн хувьд зүгээр 13.14-ийг хүчингүй болгох нь хамгийн амархан үйлдэл. Ингээд 2025 оны 11 сарын 25-ны өдөр энэ 10 дугаар дүгнэлт гарангуут бараг 11 сарын 30-нд бид нар зүгээр л шууд хүчингүй болгочих ийм хууль оруулах боломжтой байсан.

Гэтэл нөгөө талдаа энд маш олон жирийн иргэдийн асуудал яригддаг учраас энэ Цэцийн дүгнэлтийг маш сайн үзэж харах юм бол Эрүүгийн хуулийн 13.14 дүгээр зүйл нь илт худал мэдээлэл тараахыг хориглох замаар хүний нэр төр, алдар хүнд, хуулийн этгээдийн ажил хэргийн нэр хүндэд хууль бусаар халдахаас хамгаалахад чиглэсэн үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, чөлөөнд тогтоосон хязгаарлалт мөн байна. Ингээд Үндсэн хуулиар 16 дугаар зүйлийн 13 дахь заалтын халдашгүй чөлөөтэй байх эрхийг нь хангасан, хамгаалсан ийм зохицуулалт байна. 13.14 бол зорчих эрхийг нь хязгаарласан нь хэтийдүүлсэн байна. Мөн түүнчлэн илүү тодорхой болгох хэрэгтэй байна гэсэн ийм дүгнэлт байгаа учраас 13.14-ийг тодорхой хэмжээнд өөрчлөн найруулах, яг жирийн иргэдийн эрх ашгийг хамгаалах асуудлыг нь зохицуулахаас өөр арга байхгүй учраас өдийг хүртэл ажлын хэсэг ажиллаж, маш олон хэлэлцүүлгүүдийг зохион байгуулж явсан юм. Ингээд тайлбартайгаар гаргаж байгаа.

Хэвлэл мэдээллийн байгууллагуудын хамгийн их санаа зовж байгаа асуудал нь өөрөө юу юм бэ гэхээр яг 1 дүгээрт тоон мэдээлэл нь зөрөх юм бол тэр тэдэн удаа гадагшаа явсан. Гэтэл тэдэн удаа явсан шүү дээ. Энэ худал мэдээлэл байна гэх зэрэг энэ асуудал нь гэмт хэрэгт тооцогдохгүй. Нийтийн албан тушаал эрхэлж байгаа хүний асуудлыг бичиж шүүмжлэх юм бол гэмт хэрэгт тооцохгүй. Нийгмийн сүлжээгээр угаасаа явж байгаа юмыг дахин түгээсэн бол энийг гэмт хэрэгт тооцохгүй.

Юуг гэмт хэрэгт тооцох вэ гэхээр мэдсээр байж зориуд, албаар худал мэдээлэл бэлтгэж, нийтэд тарааж, хүний алдар хүндэд эдийн болон эдийн бус ашигтай байдал бий болгох үүднээс мэдээллийг бэлтгэсэн бол энэ гэмт хэрэг гэж тодорхойлж өгсөн нь өөрөө өнөөдөр хэвлэл мэдээллийн байгууллагуудын хардах эрхийн хүрээнд юу гэдэг юм, нийтлэх эрхийн хүрээнд бичиж байгаа мэдээллийг гэмт хэрэгт тооцохгүй. Харин энэ заалтыг ашиглаад өнөөдөр хянан шалгаж байна гээд хясан боогдуулах, хэлмэгдүүлээд байгаа энэ уже процессын асуудал. Энэ бол хуулийн заалттай холбоогүй асуудал юм гэдгийг бас .../минут дуусав/

**Л.Соронзонболд:** Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан Пүрэвдорж гишүүн.

**Б.Пүрэвдорж:** Тэгэхээр 2002-2017 оны хооронд гүтгэх гэдэг заалт Эрүүгийн хуульд байсан. Тэгээд үүгээр бол тухайн үед бас сошиал бага байсан учраас ер нь бол энэ хэргээр яллагдсан хүмүүс их цөөхөн байдаг юм. Тэгээд ер нь бол 10 гаруй хүн гэж яриад байдаг. Гэтэл 2017-2020 оны хооронд гүтгэх гэдэг заалт Эрүүгийн хуульд байгаагүй. Тэгээд 2020 оноос өнөөдрийг хүртэл бусдын нэр хүндэд халдах гэдэг заалт явж байгаа. Энүүгээр бол 110 худал мэдээлэл тараах, худал мэдээлэл тараах, 116 хүн яллагдсан байж байгаа юм. Яагаад гэвэл энэ сошиал маш их хөгжсөнтэй холбоотойгоор энэ гэмт хэрэгт яллагдаж байгаа хүмүүс их байгаад байгаа юм. Тэгэхээр энэ хооронд 2017 оноос 2020 оны хооронд энэ гүтгэх гэдэг зүйл алга болчихсон гэж бодож байна уу. Тийм юм байхгүй шүү дээ.

2017 онд яг энэ гүтгэх гэдэг заалтыг оруулах дээр сэтгүүлч дээр маш их эсэргүүцэл зарласан юм. Тэгээд нэлээн хэл ам болонгуут Нямдорж сайд байсан. Нямдорж сайд юу хийсэн бэ гэхээр гэмт хэрэг зөрчлөөс, Эрүүгийн хуулиас гүтгэх гэдэг заалтаа авч хаячихаад, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуульд бусдын нэр хүндэд халдах гэдэг ийм заалт оруулаад, Зөрчлийн хуулиар 100 нэгжээр торгох, тэгээд давтан бол 500 нэгжээр торгох, тэгээд дахиад давтах юм бол 1 сар баривчлах гээд. 2017 онд Дорлигжав яаж байдаг юм. Тэгээд ингээд залилсан байхгүй юу. Залилж оруулсан. Үүний дагуу 1000 гаруй хүнийг ерөөсөө шүүхийн шийдвэргүйгээр прокурорын хяналтгүйгээр бүгдийг нь аваачаад л эрүүгийн цагдаа дээр 3 давхарт аваачаад 1000 гаруй хүнийг торгож айлгаад, ийм юм явж байсан. Энийг нь би 2019 он, 2018 онд хууль өргөн бариад, энийг байхгүй болгох хуулийн төсөл өргөн бариад, энэ явсаар байгаад Энхбаяр сайд сайд болоод бид нар хамтдаа энэ хуульд өөрчлөлт оруулсан гэсэн үг. Энийг байхгүй болгосон гэсэн үг.

Тэгэхээр ер нь бол энэ чинь бүр сүүлийн 3 жилийн хугацаанд бас замбараагүй болсон байхгүй юу даа. Бүх сэтгүүлч нарыг бүгдийг нь айлгадаг болсон. Ийм л юм байгаа юм. Тэгэхээр мэдээж гүтгэх гэдэг заалтаа бас нэлээн нарийвчлаад, бас ажлын хэсэг дээр нэлээн яриад бас гайгүй болгож байгаа юм байна. Тэгэхдээ л та нарт 1 зүйлийг хэлье. МАН-ын энэ .../минут дуусав/

**Л.Соронзонболд:** Пүрэвдорж гишүүнд нэмэлт 1 минут.

**Б.Пүрэвдорж:** МАН-ын мөрийн хөтөлбөрт аливаа сэтгүүлчдийг яллахгүй гэсэн тийм амлалт байдаг шиг санагдаад байна. 785 хоног үлдэж байгаа. Амлалт чинь дуусахад. Тэгээд та нар өнөөдөр тэр amlalt.mn дээр биччихсэн байгаа тэр зүйлийг нэлээн сайн тогтож уншаарай. Мөнхбаатар бичсэн юм шиг байна. Ер нь бол нэлээн ул суурьтай бичсэн. Тэгээд ер нь бол энэ ажлын хэсэг дээр ч гаргасан энэ саналуудыг чинь ч гэсэн бас сэтгүүлч нар хүлээн зөвшөөрөхгүй байгаа шүү. Тийм учраас энэ асуудлаа бас нэлээн сайн нарийвчилж сайн ярилцах ёстой шүү гэдгийг хэлье.

**Л.Соронзонболд:** Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан гишүүд асуулт асууж, үг хэлж, саналаа хэллээ.

Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асууж, үг хэлэх гишүүд нэрсээ өгнө үү. Пүрэвдорж гишүүнээр тасаллаа. Ороогүй. Сайнзориг гишүүний микрофоныг нээе.

**П.Сайнзориг:** Бид хэд бас Цэцийн шийдвэрийн дагуу уг хуулийн төслийг боловсруулж байгаа гэдэг зүйлийг 1 дүгээрт бас тодотгож хэлье. Яах вэ, зүгээр Цэцийн энэ худал мэдээлэл тараах гэмт хэргийн шинжийг бас Үндсэн хуулийн

тодорхой зүйл заалт зөрчсөн байж болзошгүй гэдэг хүрээнд зүгээр яах вэ, энэ асуудлыг бид хэд ингээд хөврөөд явж байгаа. Ер нь хэн ч анзаарахгүй 1 зүйл бол ингээд ялын бодлогод Цэц маань орооцолдоод ирж байгаа гэдэг зүйлийг би бас энд хэлэх нь зүйтэй байх.

Яг энэ 13.14 буюу гэмт хэргийн худал мэдээлэл тараах гэмт хэргийн шинжийг яриад байгаа мэт боловч яг энэ дотроо бол бид нар явж явж Улсын Их Хуралд хадгалагддаг ялын бодлого энэ зүйл рүү ороод, дүгнэлтээ гаргачихсан юм. Тэгээд яах вэ, энийг хүлээж аваад гэмт хэргийн шинжийг тодорхой болгоё гээд явж байна. Ер нь энэ алсдаа юу харагдаж байна гэхээр сая тодорхой бас шүүх эрх мэдлийн байгууллагууд татварын бодлогыг тодорхойлж эхлээд байгаа. Сүүлдээ энэ ялын бодлогыг тодорхойлж эхлээд байгаа ийм хууль зүйн техникүүд бол өрнөөд байна шүү. Энэ би асуудлуудыг бас цаашдаа манай Байнгын хороо мэргэжлийн Байнгын хороод анхаарахгүй бол Улсын Их Хурлын онцгой бүрэн эрхэд байдаг энэ зүйлүүд рүү, агуулга руу орж шийдвэр гаргаж байгаа юм. Бусдаар би бол энэ зүйлүүдийг сайжруулаад явах ёстой гэдэгтэй бас санал нэг байгаа. Тэгээд энийгээ бас хэдүүлээ зааг ялгаатай, би протоколын хувьд үлдээчихгүй бол нөгөө гуя дагаж хүзүү гэгчээр яаж ийж байгаад энийг зөрчил болгохын тулд гэж байгаад ялын бодлогыг барьж авч байгаад ингээд энэ бол болохгүй байна гэдэг дүгнэлтээр гаргаж байх жишээтэй. Тэгэхээр энийг нөгөө юм 2 талтай буюу аль ч орон бас өөрийнхөө өвөрмөц эрх зүйн тогтолцооны онцлогоор зохицуулаад явж байгаа юмыг нэгийг нь үгүйсгээд, нөгөө талд нь тийм гэж хариулах бололцоогүй учраас ийм зүйлүүд рүүгээ гаргалаа. Тэгэхдээ энийг цаашдаа өөгшүүлж болохгүй. Маш олон гэмт хэргүүдийн юмнууд дээр ингэж нөлөөлөх бололцоотой болоод ирлээ шүү. 1 дүгээрт энийг хэлье.

2 дугаарт сая бас Пүрэвдорж дарга маань андуурч байх шиг байна. Эрүүгийн хууль, Зөрчлийн хууль яг энэ асуудлууд нь маргаан мэтгэлцээн гарч байхад би Хууль зүйн байнгын хороонд зөвлөх байсан юм. Тэгээд тухайн үеийн АН төр барьж байх үед бол Зөрчлийн хуульд орсон. Таны ярьж байгаа юм бол сүүлд ковидын хуулиар орсон худал мэдээлэл тараах асуудал яваад, энэ гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх хууль дээр нөгөө байгууллага албан тушаалтан, үгүй ээ, иргэний хуульд заасан үүргээ биелүүлээгүй бол гэдгээрээ яваад байсан байхгүй юу Пүүжээ дарга аа. Тэрийг бол зассан бид хэд. Та мэдэж байгаа. Та бас өөрөө тодорхой хууль санаачлаад, энэ гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх үүргээ биелүүлээгүй этгээдийг бас торгоод байсныг нь болиулсан. Ийм зүйлтэй юм. Тэгээд хэн хэнийгээ буруутгаад яах вэ дээ. Энэ дээр чинь Тэмүүжин гишүүн гээд Хууль зүйн байнгын хороо бас бид нар арай туршлагатай, энэ чиглэлийнхээ юмнуудыг бас аваад явчхаж болно гээд бид хэд тал талаасаа л ажиллалаа. Одоо тэгээд л танай, манай гэж хэдүүлээ зүйлүүдийг яриад яах вэ. Энийг зүгээр сайжруулаад явах зүйлүүд бол бас алсдаа ч бас гарахыг үгүйсгэхгүй байна.

2 дугаарт энэ худал мэдээлэл тараах гэмт хэргийн асуудлыг бас ../минут дуусав/

**Л.Соронзонболд:** Сайнзориг гишүүн 1 минут.

**П.Сайнзориг:** Бас анхаарахгүй бол болохгүй. Энд бол нөгөө улс орны эдийн засгийн аюулгүй байдал, тодорхой бусад аюулгүй байдалтай холбоотой ийм худал мэдээллийг тараах байдал гарч болзошгүй. Өөрөөр хэлэх юм бол үүнээсээ болоод бараа материал тасалдах, гэнэт үнүүд нэмэгдэх, хомсдол бий болгох ч гэдэг юм уу ийм зүйлүүд дээр улс орны аюулгүй байдалтай холбоотойгоор худал мэдээлэл тараах асуудлыг хувь хүн рүү биш, энэ нийгэмд нь ерөнхий байдлаар цацаж бас энэ

улс орныг донсолгодог ийм үйл явдлууд байдаг. Тэгэхээр энийг цаашдаа бид нар бас анхаарч, энэ гэмт хэргийн шинжийг бас үнэхээр хуульчлах ёстой бол бас анхаарах ёстой шүү гэдгийг Засгийн газар, Хууль зүй, дотоод хэргийн яам маань бас анхаараач. Энийг бас энэ хуулийнхаа хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ хийж байгаад бас шаардлагатай тохиолдолд холбогдох хуулийн төслийг өргөн бариарай. Битгий мартаарай л гэж би протоколын хувьд үлдээх гээд байгаа юм. Баярлалаа.

**Л.Соронзонболд:** Алтангэрэл гишүүний микрофоныг нээе.

**О.Алтангэрэл:** 1 л зүйлийг ер нь тодорхой болгож бид нар ойлгомоор байгаа юм. Сэтгүүлчид, хэвлэл мэдээллийнхэн гэдэг шүхэр дор энэ асуудалтай чинь холбоотой 90 гаруй хувь нь нуугдаж, хариуцлагагүй үлдэх гээд байна. Ерөөсөө сэтгүүлчид хэвлэл мэдээллийн байгууллагынханд хариуцлага хүлээлгэх гэдэг юм уу, шалгахыг дэмжиж байгаа гишүүн энэ дотор байхгүй байх. Гол нь Монгол хүний тэр нэр төр хамгаалагдахгүй үлдэх гээд байгаа учраас энэ асуудлыг ярьж байгаа юм. Тэгэхээр энэ 2 дугаар зүйл дээр жишээлбэл, хиймэл оюунд суурилсан технологийн тусламжтайгаар хүний дүр төрх, дуу хоолойны өнгө, үйл хөдлөл эсвэл бодит нөхцөл байдлыг бүрэн эсвэл хэсэгчлэн дуурайлгах, өөрчлөх, хувиргах, шинээр бүтээх замаар хуурамч зураг, дуу, дүрсний бичлэг ашиглаж гээд. Энэ бол ер нь deepfake хэлж байх шиг байна. Хүний яриагүйг ярьсан болгож байн. Хийгээгүйг хийсэн болгож байна. Өөр бичлэг зураг дээр нүүрийг нь нааж байна. Дуу хоолойны өнгийг нь хувиргаж байна. Энийг бол, жишээлбэл сэтгүүлчид ийм юм хийгээд суухгүй. Тэр зориудын тролл баг, гүтгэгчид, хэн нэгэн улс төрчийн захиалгаар ажиллагсад, хэн нэгний бизнесийн нэр төрд халдъя, гутаая, нэр хүндийг нь унагаая гэсэн мөнгөтэй, техниктэй ийм хэсгийн хийдэг ажил.

Тэгэхээр ер нь энэ цагдаагийн байгууллага, би бас цагдаагийн байгууллагаас 1 асуулт. Дахиад би Хууль зүй, дотоод хэргийн яамнаас асууя. Энэ дээр бодит жишээ баримтууд байна уу. Дэлхий нийтээр энэ deepfake буюу энэ дуу, дүрсийг хуурамч хийхтэй холбоотой асуудал дээр ер нь ямар чиг хандлага байна гэсэн ийм асуулт асууя.

**Л.Соронзонболд:** Пүрэвдорж гишүүний микрофоныг нээе. Зөвхөн 2 дугаар зүйлтэй холбоотой асуулт асууна шүү.

**Б.Пүрэвдорж:** Тэгэхээр сая бас яг амьдрал дээр бол тийм 100 мянган нэгжээр торгоогүй. Ер нь бол амьдрал дээр таны хэлснээр бол 2 саяар иргэн хүнийг торгоод, сэтгүүлч хүмүүсийг торгоод, 20 саяар тэр сайтыг нь торгоод байсан юм гэж байна шүү дээ. Тэгээд ерөөсөө мэдээж юу байдаг юм, яг энэ гүтгэх гэдэг асуудлаар, бусдын нэр хүндэд халдах тухай асуудлаар бол яг ихэнхдээ бол нөгөө торгох, өөр юу байдаг юм заавал хорихгүйгээр ял өгдөг юм байна лээ л дээ.

Тэгэхдээ сүүлдээ энэ бусдын нэр хүндэд халдах гэдэг тэр Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийг биелүүлээгүй гэдгээр Зөрчлийн хуулиар ингээд 20 саяар, 2 саяар торгоод байхаар нөгөө сэтгүүлч нар чинь ерөөсөө юм хэлэх, ярихаа болиод, яг эдийн засгийн аргаар нь л энэ асуудлыг нь ингээд шийдээд явчихаар тэр гэр бүлээсээ олсон мөнгөнөөсөө арай гэж торгуулиа төлөөд явна гэдэг чинь сэтгүүлч хүнд маш их хэцүү байсан байхгүй юу даа. Тийм учраас энэ угаасаа ингээд харж байхад жишээ нь юу байдаг юм, Алтанхуяг даргыг нэг нөхөр гүтгэсэн. Тэгээд Алтанхуяг дарга өргөдөл өгсөн. Тэгэнгүүт тэр нөхөр 1 жил 8 сар юугаар явсан байхгүй юу даа. Хууль хяналтын байгууллагаар явсан. Тэгэхдээ энүүгээр би бол ял авахгүй юм байна. Угаасаа ял аваагүй. Ямар ч шийтгэл аваагүй. Хэрэгсэхгүй

болсон. Тэгэхдээ тэр нөхөр яасан бэ гэхээр ер нь бол ингээд сэтгүүлч нарыг шоглоод суугаад байж болох юм байна гэдэг. Хууль хяналтын байгууллагаар явуулаад л, шоглоод л ингээд байгаад байж болох юм байна гэдгийг тухайн үед мэдэж авсан байхгүй юу даа.

Тийм учраас яг энэ асуудлаар ингээд ер нь бол энэ хүмүүсийг эдийн засгийн аргаар нь тэр гэр бүлдээ зарцуулах мөнгөнөөс нь торгох замаар ингэж асуудалд хандах нь илүү хор хохиролтой юм байна гэдгийг л энэ өнөөдрийн МАН-ынхан бүгдээрээ мэдэж авсан юм байгаа юм л даа. Тэгээд энэ нь л өнөөдрийг хүртэл ингээд яваад байгаа юм.

**Л.Соронзонболд:** Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан гишүүд асуулт асууж, санал хэлж дууслаа.

Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух, саналтай гишүүд нэрсээ өгнө үү. Ганбат гишүүнээр тасаллаа. Ганбат гишүүний микрофоныг нээе.

**Д.Ганбат:** Үндсэн хуулийн цэцээс дүгнэлт гарчээ. Тэр дүгнэлтийнхээ дагуу хууль өөрчилж байгаа юм байна. Энэ Эрүүгийн хуулийн 13.14 дүгээр зүйлийг ингээд байхгүй болгож байгаа юм байна. Би бас хэдэн зүйл асууж тодруулъя гэж бодож байна.

Энэ гүтгэх үйл ажиллагааг чинь цаанаасаа захиалгатай хийдэг. захиалагч нарыг нь яаж шийтгэх гээд байгаа юм. Захиалагчийн талаар юу байгаа юм. Миний мэдэхийн энэ олон түмний толгойг бол маш чадмаг угааж байна шүү дээ. Тэгээд энэ улс орны хувь заяаг бол эргүүлж байна шүү дээ. Хэдэн 10 жилээр нь Монгол Улсын хөгжлийг гацааж байна. Би энийг бол гадна, дотнын даалгавартай хийгддэг байх гэж бодож байна. Ийм юмыг энэ ажлын хэсэг энэ хуулийг боловсруулсан хүмүүс авч хэлэлцсэн юм уу, үзсэн юм уу, харсан юм уу.

Ингээд харж байхад бол хаалтын гэрээг бол бүгдээрээ л хийдэг юм шиг байгаа юм. Ялангуяа МАН-ын дарга нар, МАН-ын гишүүд, энэ сайд нар. Гэхдээ энэ санхүүжилтийг байнга тэр гэмт хэргээс орж ирсэн байж болзошгүй мөнгөөр, мөн бас татвар төлөгчдийн мөнгөөр хийдэг. Ийм юмыг хаасан, боосон юм байдаггүй юм уу. Хамгийн гол юм чинь энэ дээр байна шүү дээ. Энэ асуудалд яаж хандсан юм бэ.

Тэгээд харж байхад бүх дэлхийн хэвлэл бараг нийлээд тийм байхааргүй тийм их аппараттай, тийм олон сурвалжлагч, микрофонтой хүмүүс цугларчих юм. Тэгээд би гайхдаг. Манайхаас Монгол Улсаас өөр улс оронд бол бараг ийм юм байхгүй байх. Тэгээд эд нар хаанаас яаж санхүүждэг юм. Яаж амьдраад байдаг юм. Зүгээр реклам сурталчилгаа ч юм уу, өөр үйл ажиллагаанаас санхүүжилт олоод ингэж амьдарна гэж байхгүй. Ямар ч эрүүл, саруул ухаантай хүн бол тэрийг хараад ойлгодог л байхгүй юу. Тэгээд ийм юмаа ярьсан юм уу, яриагүй юм уу. Энэ дээр та бүхэн юу гэж үзэж байгаа юм. Энэ юмаа оруулахгүйгээр, энэ юмаа шийдэхгүйгээр энэ хууль чинь нэг их болохгүй байх. Тэр цаад талын тэр зорилгодоо хүрэхгүй байх. Хамгийн гол юман дээрээ бид нар анхаараагүй, ажиллаагүй ингээд орхигдуулчихсан. Ойр зуурын жижигхэн юман дээр ярьсан ийм байдалтай энэ хуулийг боловсруулсан байна. Тэгэхээр энэ талаар бас тодруулъя гэж бодож байна.

**Л.Соронзонболд:** Ажлын хэсгийн ахлагч Тэмүүжин гишүүний микрофоныг нээе.

**Х.Тэмүүжин:** Энэ ажлын хэсэг Үндсэн хуулийн цэцийн 10 дугаар дүгнэлттэй холбоотой байгуулсан ажлын хэсэг. Бидний мандат ажиллах хүрээ бол ерөөсөө л худал мэдээлэл тараах гэдэг гэмт хэргийг хүчингүй болгох 1 дүгээр даалгавар. Үндсэн хуулийн цэц энийг Үндсэн хууль зөрчсөн гэж үзсэн учраас.

2 дахь даалгавар нь энэ гэмт хэргийн чинь дотор байгаа хүний нэр төр, алдар хүнд рүү халдаж байгаа энэ төрлийн гэмт хэргээ эрүүгийн хуулийнхаа аль хэсэгт бичих юм гэдгийг шийдэх. Үндсэн хуулийн цэц чинь маш сонирхолтой дүгнэлт гаргачихсан шүү дээ. Эрүүгийн хууль дээр энэ төрлийнхөө гэмт хэргийг бичиж болно. Тэгэхдээ хорих ял бичиж болохгүй шүү гээд бүр ялын бодлого руу орж ирээд биччихсэн. Тэгэхээр бид хэд гүтгэх гэдэг гэмт хэргийг нь Эрүүгийн хууль дээр байх уу, байхгүй юу гэдгийг тусад нь дахиад шийдэх гэж байгаа. Саяын хэвлэл мэдээллийн хэрэгсэл бол тэр наад тогтолцоотой чинь холбоотой асуудал бол манай ажлын хэсгийн даалгавар ерөөсөө биш.

Засгийн газар энэ хэвлэлийн эрх чөлөөтэй холбоотой болон хэвлэл мэдээллийн хэрэгсэлтэй холбоотой энэ хууль тогтоомжоо боловсронгуй болгох чиглэлийнх нь юм нь бол тусдаа яригдах байх. Мөн бас 1, 2 гишүүдийн үгэнд гарсан. Манай Алтанхуяг гишүүн нь ч гэсэн болгоомжилж хэлэх шиг боллоо.

Эрүүгийн процессын хуулиудаар энэ дью процесс гэж яриад байгаа. Энэ цагдаагийн байгууллага болон энэ хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцож байгаа байгууллагууд чинь хуулиа зөв хэрэглэхгүй байх, хүнийг хэлмэгдүүлэх, хүн нь байвал хэрэг нь олдono гэх мэтчилэн энэ фишинскийн аргаар явж байгаа энэ процессоо янзлах чинь бас манай ажлын хэсгийн ажил ерөөсөө биш. Засгийн газар, Хууль зүйн яам энэ чиглэлээрээ хуулиа боловсронгуй болгох чиглэлээрээ яаж ажиллах юм, тэрнийх нь даалгавар. Тэгээд бид хэд хүний өмнөөс ажлыг нь хийх боломжгүй. Бас Цэцийн дүгнэлтээс гадуур хууль боловсруулж өргөн барих бас боломжгүй.

Би ч гэсэн яг энэ санал хураалт дээр 3 тусдаа санал хураах ёстой гэж тийм байр суурьтай байгаа. 1 санал хураалт ерөөсөө явж болохгүй. Гүтгэх гэмт хэргийг эрүүгийн хуулиар бичих асуудал тусдаа санал хураалт явах ёстой. 13.10-ыг хасахтай холбоотой санал хураалт тусдаа явах ёстой. Мөн энэ 13.11 дээр хүний нэр төр, алдар хүндийг гутаах зорилгоор гэдэг 2.2 бичигдэж байгаа энэ санал хураалт тусдаа явах ёстой. Ингээд 3 санал хураалт тусдаа явах ёстой гэж бодож байгаа. Тусдаа явахгүй бол нэг уутан дотор авчирч та нар Цэцийн дүгнэлтийг хүлээж авахдаа аваачиж нөгөө тусдаа санал хураалтгүйгээр бөөнд нь хураалгаад гүтгэхийг оруулж ирсэн, эсхүл тэгсэн гээд хэл ам гарах магадлал өндөртэй. Хэрвээ санал хураалт тусдаа явахгүй, үүгээр 1 явуулна гэх юм бол ажлын хэсэг буцаж хуралдаад энэ санал хураалтынхаа хэлбэрүүдийг 3 тусад нь гаргаад, дахиад санал хураалтад бэлтгэх ёстой тийм байр суурьтай байгаа.

**Л.Соронзонболд:** Асуулт асуух жагсаалтад Баасанжаргал гишүүнийг нэмье. Ганбат гишүүн тодруулъя.

**Д.Ганбат:** Энэ ажлын хэсэг их хязгаарлагдмал хүрээнд ажилласан байна. Тэгээд хамгийн гол нь тэр гүтгэлгийг захиалж байгаа зорилго, шалтаг, шалтгаан ийм юмыг бид нар авч үзмээр байгаа юм л даа. Хэрвээ цаанаасаа зорилготойгоор захиалсан бол энэ бол Эрүүгийн хуулиар шийдэх ёстой. Энэ бол маш том гэмт хэрэг. Энийг ялгаж салгамаар байгаа юм. Үүний санхүүжилт энэ тэр нь яаж явагддаг энэ тэрээ судалсан, харсан юм байгаа юу. Мэдээж хэрэг сэтгүүлчид нөгөө мэдээлэл

тараах, андуурах, эндүүрэх ийм тохиолдлууд байж болно. Тэрийг бол Иргэний хуулиараа л шийдэж байх ёстой л доо. Энийг бас ялгаж салгаж үзмээр байгаа юм. Ингэж ажиллавал яасан юм бэ. Энэ талаар үзсэн, харсан, судалсан юм байгаа юу та бүхэнд.

**Л.Соронзонболд:** Ажлын хэсгийн ахлагч Тэмүүжин гишүүний микрофоныг нээе. Пүрэвдорж гишүүний үг хэлэх жагсаалтад нэмье.

**Х.Тэмүүжин:** Ганбат гишүүний тэр гэмт хэрэгтэй гэж ярьж байгаа 2 зүйл энэ 14.10 дугаар зүйлийн 2.3, 2.4 дээр бичигдсэн юм. Бид хэд ингэж бичиж байгаа. Захиалгаар гүйцэтгэж гэж. Хэн нэгэн мөнгө төлөвлөөд хэн нэгнийг гүтгэх зорилготой захиалга өгөөд тэр захиалгаа биелүүлж байгаа бол тэр захиалагч нь энэ гэмт хэргийн гэм буруутай этгээд болж энэ гэмт хэрэгтээ татагдаж ирж байх ёстой. Тэгээд энэ агуулга бол 2.3 дээр орсон. Бүлэглэж гэж бичсэн. Дахиад 2.4 дээр нь. Зохион байгуулалттайгаар санхүүжилтийг нь гаргаад, төлөвлөөд, олон хүмүүсийг хамааруулаад, тэгээд санаатайгаар гүтгэж байгаа энэ төрлийн гүтгэлэг бол нэг талаараа бизнес дээр гарч ирдэг юм байна лээ. Нөгөө талаараа улс төр дээр гарч ирдэг юм байна лээ. Та бүхэн ч гэсэн бүгдээрээ анзаарч л байгаа биз. Улс төрийн өрсөлдөгчөө намнахын тулд яаж гүтгэлэг зохион байгуулж, зохион байгуулалттайгаар мөнгө төлөвлөж, хуурамчаар мэдээллүүд бэлдэж, тэгээд тарааж байгаа гэдгийг бүгдээрээ л харж байгаа. Тэгээд энэ бол дахиад л гэмт хэрэг гэж үзээд энэ дээр бичсэн байгаа. Сэтгүүлчид ч юм уу тэр нөгөө мэдээ баримттай холбоотой хэсгүүдийг бол яагаад гэмт хэрэг болохгүй вэ гэдгийг бас энэ тайлбарууд дээр бичсэн байгаа шүү.

**Л.Соронзонболд:** Ажлын хэсгийн гишүүн Сайнзориг гишүүн хариулъя.

**П.Сайнзориг:** Ганбат гишүүн маань зөв юм яриад байна. Тэгэхээр өнөөдөр бол Соронзонболд гишүүн даргалж байна. Уг нь Цогтбаатар дарга бас Засгийн газраас буюу Алтангэрэл сайдын үед өргөн барьсан энэ Хэвлэлийн эрх чөлөөний хуулиа ер нь явуулах асуудлаа бас нэг яримаар байна. Тэгээд сэтгүүлчид бас энэ мэргэжлийн алдаагаа засаж залруулдаг өөрийн удирдлагын зохицуулалт нь ямар байх юм. Эсвэл хэвлэл мэдээллийн арбитрай байгаад уг асуудлаа ярьдаг байх уу гээд энэ олон хувилбарт зүйлүүдийг бас ярьж болно.

2 дугаарт яг Ганбат гишүүний хэлж байгааг би бас давтаад хэлье. Манай Хууль зүй, дотоод хэргийн яамны төлөөлөл байна. Энд бол бид нар дандаа хувь хүний тухай ярьсан. Цаана нь улс орны эрх ашиг болоод хуулийн этгээдийн бас асуудлууд хөндөгддөг. Зарим худал мэдээлэл тараах байдлаар хуулийн этгээдийг дампууруулж болж байгаа юм. Улс орныг гамшиг осол ч гэдэг юм уу эсвэл ийм нийгмийн эмх замбараагүй байдал руу оруулж болж байгаа юм. Дээрээс нь бараа материалын үнийн хөлсийг хөөрөгдүүлж болж байгаа юм. Эсвэл бусад ийм сөрөг үр дагавруудыг авчирч байгаа юм. Тэгэхээр энэ асуудал бол орхигдсон шүү. Тэгээд Тэмүүжин гишүүн хууль зүйн техникийн хувьд хэлж байна. Бид хэд энийг арай хөндөх бололцоогүй. Энэ Засгийн газрын үүрэг даалгавар шүү. Энийг битгий мартаарай бас Ганбат гишүүн бас хэлээд байна. Энийг би бас таны зөв, тантай санал 1 байна гэдгээ бас илэрхийлж байна.

**Л.Соронзонболд:** Баасанжаргал гишүүний микрофоныг нээе.

**Х.Баасанжаргал:** Би нөгөө түрүүчийнхээ хэлсэн асуулттай холбоотой л үг хэлэх гээд байгаа юм. Хүний нэр төр, алдар хүндийг гутаах зорилгоор гээд 2 дугаарт

болоогүй үйл явдлыг болсон мэтээр гээд гэх мэтээр ингээд ийм субъектив байдлаар тайлбарлах хэд хэдэн үг, өгүүлбэр орчхоод байгаа нь л гол санаа зовох зүйл болоод байгаа юм. Тэгээд ялангуяа нөгөө процессын сэтгүүлчдийн гаргаж ирж ярьж байгаа асуудал нь дандаа нөгөө процессын шударга байдлыг хангахтай холбоотой асуудал дийлэнхтэй байгаад байгаа. Илтэд юу гэдэг юм гомдлын асуудлыг хэрэг үүсгээд, сэтгүүлчдийг саатуулаад байцаагаад, удаа дараа дуудаад нэг ийм нөгөө процессын асуудлууд удаа дараа гараад, тэгсэн мөртөө яг ял шийтгэл эдэлсэн хүмүүсийг нь харахаар сэтгүүлчид маш цөөхөн байгаад байдаг. Яг процесс ажиллагаанд хамгийн их эрх ашиг нь хөндөгдөөд, хамгийн их залхаан цээрлүүлэлтэд ороод, цаашид үг хэлэх, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг хамгийн их хязгаарлалтад орж болзошгүй гэдэг ийм нөхцөл байдал үүсгэх ийм зүйл нь болохоор яг сэтгүүлчид өртөөд байдаг.

Тэгэхээр яг энэ 2 асуудал дээр ялангуяа процессын шударга байдлын асуудлыг бид нар цаашид анхаарах ёстой. Гэхдээ яг энэ ажлын хэсэг дээр бол зайлшгүй бид нарын нөгөө хүрээ хязгаар өөрөө тэр хэсэг байхгүй учраас бас боломжгүй байгаад байгаа юм. Гэхдээ энэ дээр би зүгээр субъектив байдлаар хандаж болохуйц хэд хэдэн үг, өгүүлбэрийг, ойлголтуудыг жоохон засах, эсвэл хасах ийм зүйл санал байгаад байна. Тэгээд нөгөө өөрөө ажлын хэсэгт байсан болохоор болохгүй л болох гээд байна л даа.

2 дугаарт би түрүүн тэр ярьсан жишээн дээр дурдсан тэр асуудлаар тэр хүнд бол жишээ нь би бол эрүүгийн хариуцлага хүлээлгэх нь бол өөрөө утгагүй, тийм байх ёсгүй гэж бодож байгаа. Гэвч яг хэрвээ би биш өөр хүн байсан болоод ингээд гомдол гаргах юм бол яг энэ томьёоллоор бол эрүүгийн хариуцлага татагдах, ямар ч байсан мөрдөн байцаалт, хэрэг бүртгэлтийн хэрэг үүсгээд, тэр хүнийг байцаалтад дуудах ийм хангалттай үндэслэл бас яг энэ томьёолол дээр бичигдчихсэн байна. Тэгэхээр энийг бас бид нар цаашид анхаарахгүй бол нөгөө хор уршигтай нь холбох, дээрээс нь тухайн яг бодит хохирол, хор уршиг, тэр нь хэрвээ хэр ноцтой байх вэ гэдэг дээр л илүү бид нар үндэслэж, яг эрүүгийн хэрэг үүсгэх эсэх нь явах нь зөв байсан болов уу гэснийг ийм саналтай байгаа. Тэгээд энийгээ яг протокол дээр тэмдэглэж үлдье.

Тэгээд хамгийн гол нь хэвлэл мэдээллийн мэргэжлийн өөрөө удирдах ёс, хэвлэл мэдээллийн байгууллагын үндсэн үйл ажиллагаа, мэргэжлийн үйл ажиллагаатай холбоотой гаргасан мэдээлэлд энэ нь өөрөө хамаарахгүй ч гэдэг юм уу, дараах гэмт хэрэгт тооцохгүй гэдэг дээр 1 ийм зүйл орох байсан уу гэсэн нэг ийм санал байгаагаас бас тэмдэглэлд үлдээе.

**Л.Соронзонболд:** Пүрэвдорж гишүүний микрофоныг нээе.

**Б.Пүрэвдорж:** Тэгэхээр 2002-2017 онд Эрүүгийн хуулийн 111-д гүтгэх гэдэг заалтын дагуу нийтдээ 100 орчим хүнийг л шийтгэсэн юм байна. 15 жилийн хугацаанд. Гэтэл 2020-2025 оны хооронд нийтдээ 110 хүнийг 5 жилийн хугацаанд шийтгэсэн байгаа нь бол ямар их хүний эрх, хэвлэн нийтлэх, үзэл бодлоо илэрхийлэх тэр эрх чөлөө хумигдсан бэ гэдэг нь эндээс харагдаж байгаа. Тэгэхээр МАН-ын мөрийн хөтөлбөрийн 4.2.7-д сэтгүүлчийг хэвлэн нийтэлсний төлөө хорьж цагддаг, хууль бусаар мөрдөн хавчдаг, үндэслэлгүйгээр хууль зүйн хариуцлага татдаг явдлыг зогсооно гэж ингэж заасан байгаа юм. Тэгэхээр энэ нь хууль, эрх зүйн энэ мөрийн хөтөлбөрийг бас манай Сайнзориг гишүүн тухайн үедээ мөрийн хөтөлбөрийн ажлын хэсэгт ороод, яг энэ заалтыг оруулсан гэж байгаа юм. Гэвч

өнөөдөр энэ байгаа заалтаар нь бас тодорхой асуудлыг шийдвэрлэж чадахгүй байна л даа.

Би жишээ нь энэ хууль дээр байгаа 1 зүйлийг хэлье. Нийтийн албан тушаалтан шүүмжлүүлсэн асуудал дээрээ тайлбар өгөх үүрэгтэй ч сэтгүүлч шүүмжилсээр байвал гэмт хэрэг үйлдсэн гэж тооцно гэж байгаа юм. Мэдээж нөгөө нэг нийтийн албан тушаалтан чинь өөрийгөө өмгөөлж л ярина. Тэгээд өмгөөлөөд ярингуут нь дахиад нөгөө сэтгүүлч, хэвлэн нийтлэгч нь шүүмжлээд байх юм бол шууд гэмт хэрэг гээд үзчихээр ийм заалт орчихсон байна шүү дээ. Тэгэхээр нөгөө мөрийн хөтөлбөрийн чинь 4 2.7 чинь хэрэгжихгүй болчихоод байна Сайнзориг гишүүн ээ. Тийм учраас энэ дээрээ 785 хоног үлдэж байна. Мөрийн хөтөлбөр чинь хэрэгжиж дуусахад. Тэгээд энэ оруулсан заалт дээрээ эзэн болоод энэ сэтгүүлч нарын эсрэг янз янзын хуулийн заалт гаргаж, энэ хүмүүсийг хавчин хяхдаг, үг хэлэх эрх чөлөөг нь хэвлэн нийтлэх эрх чөлөөг нь боодог энэ явдлаа болих хэрэгтэй. Тэрний төлөө ажиллаарай гэж эрхэм гишүүнд зөвлөө.

**Л.Соронзонболд:** Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулан гишүүд асуулт асууж, санал хэлж дууслаа.

Тэмүүжин гишүүн горимын санал авах юм уу. Тэмүүжин гишүүний микрофоныг нээе.

**Х.Тэмүүжин:** 1 горимын санал байна. Буцаагаад ажлын хэсэг хуралдаад, энэ санал хураалтыг 3 удаагийн санал хураалт явах ёстой.

1 дүгээрт нь ямар санал хураалт явах ёстой вэ гэхээр Эрүүгийн хуулийн 13.14 дүгээр зүйлийг хүчингүй болсонд тооцох санал хураалт тусдаа явах ёстой. Энэ Үндсэн хуулийн цэцийн дүгнэлттэй холбогдуулаад нөгөө Үндсэн хууль зөрчсөн гэдэг заалтаа түдгэлзүүлсэн заалтыг хүчингүй болгож байгаа юм.

2 дугаар санал хураалт нь хаана явах ёстой вэ гэхээр энэ 14.10 дугаар зүйл дээр Гүтгэх гэдэг гэмт хэргийг бичихтэй холбоотой асуудлаараа тусад нь санал хураалт явах ёстой.

3 дугаар санал хураалт нь дахиад хаана явах ёстой вэ гэхээр 13 дугаар зүйлийн 11 дүгээр зүйлийн 2.2 дахь заалт дээр 2.2 гэдэг заалт нэмэх тухай тэн дээрээ бас тусдаа санал явах ёстой. Ийм 3 санал хураалт тусдаа явах учраас энэ 3 тусад нь багцлаад, 3 тусад нь хууль болгоод, тэгээд 3 тусад нь санал хураалт Хууль зүйн байнгын хороо дээр, чуулган дээр гээд явна. Тэгээд тийм байдлаар бэлтгэх боломж олгоод ажлын хэсгийг буцаж хуралдуулаад, энэ хуулиа задлаад 3 санал хураалт бэлтгээд, дараагийн Хууль зүйн байнгын хороо дээр оруулж ирээд санал хураалт руу оруулъя. Тийм горимын санал.

**Л.Соронзонболд:** Ажлын хэсгийн ахлагч Тэмүүжин гишүүнээс ажлын хэсэг дахиж хуралдаж, 3 зүйл, заалт тус бүрээр нь ажлын хэсэг дээрээ хэлэлцэх ийм горимын санал гаргасан. Тийм учраас Тэмүүжин гишүүний саналыг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулна. Гишүүд санал хураалтаа бэлдье.

Тэмүүжин гишүүний горимын саналыг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт. Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 13.3 дугаарт зааснаар хуралдаанаар 1 асуудлыг хэлэлцэж эхэлсэн боловч түүний

хэлэлцүүлгийг горимын саналаар хойшлуулсан тохиолдолд хуралдаан даргалагч дараагийн асуудлыг хэлэлцүүлнэ гэсний дагуу дараагийн асуудалдаа оръё.

Тэмүүжин гишүүний горимын санал 17 гишүүнээс 9 гишүүн буюу 52,9 хувь нь дэмжсэн байна. Санал дэмжигдсэн.

16.52 цаг.

**Улсын дээд шүүхийн шүүгчид нэр дэвшигчтэй танилцах тухай асуудлыг хэлэлцэж эхэлье.**

Улсын дээд шүүхийн шүүгчид нэр дэвшигчийн танилцуулгыг Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга Пунцагийн Золзаяа танилцуулна.

Танилцуулаарай. Индэр дээрээс. Улсын дээд шүүхийн шүүгчид нэр дэвшигчийн танилцуулгыг Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга Пунцагийн Золзаяа танилцуулна.

**П.Золзаяа:** Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе.

Монгол Улсын Үндсэн хуулийн 51 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1 дэх хэсэгт зааснаар Улсын Дээд шүүхийн шүүгчийн сул орон тооны сонгон шалгаруулалтад тэнцсэн нэр дэвшигч Төмөрбаатарын Өсөхбаярыг та бүхэнд танилцуулж байна.

Төмөрбаатар овогтой Өсөхбаяр 1976 онд Сүхбаатар аймгийн Баруун-Урт сумд төрсөн. 50 настай, эрэгтэй, ам бүл 5. 1984-1994 онд Сүхбаатар аймгийн 1 дүгээр бүрэн дунд сургууль, 1995-1999 онд Их засаг их сургуульд эрх зүйч бакалавр, 2020 онд Монгол Улсын Их Сургуулийн Хууль зүйн сургуульд Хууль зүйн ухааны магистрын зэргийг тус тус хамгаалсан байна.

2000-2006 онд дүүргийн шүүхэд нарийн бичгийн дарга, шүүхэд жижүүр, шинжээч, шүүгчийн туслах зэрэг ажлыг хийж байгаад 2006 онд анх БЗД-ийн шүүхийн шүүгчээр томилогдсон. Үүнээс хойш 2009-2012 онд БГД-ийн шүүхийн шүүгч, 2012-2013 онд Нийслэлийн давж заалдах шатын шүүхийн шүүгч, 2013-2015 онд Эрүүгийн хэргийн давж заалдах шатын шүүхэд шүүгч. Сүхбаатар аймгийн Баруун-Урт сумд төрсөн хүн байна. 2015 оноос Нийслэлийн Эрүүгийн хэргийн давж заалдах шатын шүүхийн ерөнхий шүүгч, одоо шүүгчээр ажиллаж байгаа. Ингээд нийтдээ бол 20 жил шүүгчээр ажиллаж байгаа.

Хуульд заасан шалгуурыг хангасан талаар та бүхэнд танилцуулъя.

Өсөхбаяр нь 1995-1999 онд Их засаг их сургуульд эрх зүй, эрх зүйч бакалавр, 2020 онд МУИС-ийн Хууль зүйн сургуульд Хууль зүйн ухааны магистрын зэргийг тус тус хамгаалсан байна. Хуульд зааснаар 45 нас хүрсэн, Монгол Улсын иргэн. Эрүүгийн хариуцлага хүлээж байгаагүй. Шүүгчид нэр дэвших үед яллагдагчаар татагдаагүй тухай баримт бүрдсэн байна. Шүүгчээр ажиллахад харшлах өвчин, сэтгэцийн эмгэггүй болохыг тогтоосон мэргэшсэн эмчийн магадалгаа, хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөлтэй байгаа. Шүүгчээр ажиллах мэдлэг чадвар ёс зүйн хувьд сонгон шалгаруулалтад хууль зүйн мэдлэг чадварын шалгалтад 51,29 оноо, мэргэшил, ёс зүй, зан төлөвийн шалгалтад 27 оноо авч хяналтын шатын шүүхийн шүүгчийн сонгон шалгаруулалтад бол тэнцсэн.

Өсөхбаяр шүүгчийн хувьд мэргэжлээрээ 10-аас доошгүй жил ажилласан байх энэ шаардлагыг бүрэн хангасан байна. Шүүгчээр нийтдээ 20 жил 1 сар ажиллаж байна. Сүүлийн 6 жил улс төрийн болон улс төрийн намын удирдах албан тушаал эрхэлж байгаагүй. Шүүхийн тухай хуулийн 31.6-д улс улсын дээд шүүхийн нийт шүүгчийн 2/3-оос доошгүй нь шүүгч байх гэсэн энэ шалгуурт бол шаардлагыг бол хангаж байгаа.

Шүүхийн тухай хуулийн 34.1-д зааснаар нэр дэвшигч Өсөхбаяр нь хууль зүйн мэдлэг чадварын шалгалтад 51,29 оноо, мэргэшил, ёс зүй, зан төлөвийн шалгалтад 27,43 оноо, нийт 78,72 оноо авч 1 дүгээрт эрэмбэлэгдсэн байгааг Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2026 оны 73 дугаар тогтоолоор баталсан байна.

Ингээд Шүүхийн ерөнхий зөвлөлөөс хяналтын шатны шүүхийн шүүгчийн сул орон тооны сонгон шалгаруулалтад 1 дүгээрт эрэмбэлэгдсэн нэр дэвшигч Төмөрбаатарын Өсөхбаярыг Байнгын хороонд танилцуулж байна.

**Л.Соронзонболд:** Золзаяа даргад баярлалаа. Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга болон нэр дэвшигчээс асуулт асууж, үг хэлэх гишүүд нэрээ өгнө үү. Алтангэрэл гишүүнээр тасаллаа. Сайнзориг гишүүн асуулт асууя.

**П.Сайнзориг:** Шүүхийн ерөнхий зөвлөлөөс асуугаадахъя. Ер нь зүгээр ингээд сонгон шалгаруулалтад хэчнээн хүн оролцов. Ерөнхийдөө ямархуу байдлаар тэнцсэн юм. Тэгээд энэ хүн маань мэдээж Шүүхийн ерөнхий зөвлөлөөс хамгийн өндөр оноо аваад л гарч ирж байгаа байх л даа. Тэгэхээр энийг бас танилцуулаадхаач.

2 дугаарт яах вэ, зүгээр энэ далимд асуухад энэ шүүхийн захиргааны ажилтны хангалт бас анхан шатанд ялангуяа сум, сум дундын шүүхүүдэд бол нэлээн хүндрэлтэй байна гэсэн ийм асуудлууд гарч байна. Сая бас тодорхой хэрэг маргаан шийдэх гээд тэгсэн чинь 2 нарийн бичигтэй, шүүхийн нарийн бичигтэй. 1 нь ажлаасаа гараад, 1 нь шүүх хуралдааны нарийн бичиг хийж байхад ээж нь прокурор талаас орж ирээд ингээд бүхэл бүтэн шүүхийн үйл ажиллагаа зогсож байна гээд яригдаж байх шиг байна лээ. Тэгэхээр ер нь зүгээр шүүхийн захиргааны ажилтны хангамж, ажиллах нөхцөл байдаг юм уу ийм зүйлүүд ер нь ямархуу байдалтай бас орон нутгууд байна. Сая аль аймагт гарсныг би мартчихлаа. Тэгэхээр иймэрхүү зүгээр тохиолдлууд ер нь хэр элбэг байгаа юм бэ. Тэгээд энэ шүүн таслах ажиллагаа бас гацаж байна ч гэдэг юм уу, зогсож байна, эргээд тодорхойгүй байдлаар бас хойшлуулж байна гэдэг маань иргэдэд бас их буруу мессеж очоод байна л даа. Тэгэхээр ийм зүйлүүд дээр Шүүхийн ерөнхий зөвлөл ямархуу бодлогын асуудлууд зүгээр бодож байгаа вэ гэдэг ийм зүйлүүд хэлээч.

2 дугаарт ер нь гэр бүл, хүүхдийн шүүх байгуулагдах асуудал хууль, эрх зүйн орчны хувьд бас ингээд явж байна. Тэр 2 шүүгч маань ингээд ямархуу байдалтай байна. Иргэний шүүх рүү түр сэлгэн ажиллуулах тийм бололцоог эрэлхийлж байгаа юу. Бас хэвлэл мэдээллийн байгууллагаараа харахаар хууль батлахад зүгээр ажиллаж байна гэх маягтай ярилцлага өгчихсөн байна лээ. Зүгээр сууж байна гээд. Тэгэхээр ийм байдлаар бид нар шүүхийн захиргааны байгууллага маань асуудалд бас хөшүүн хандаад байгаа юм уу. Үнэхээр тэр 2 хүн зүгээр хий хоосон ингээд сууж байгаа юм уу. Эсвэл би бол амьхандаа сэлгэн ажиллуулж байгаа байх л гэж бодсон байхгүй юу. Тэгсэн чинь саяхны 1 телевизийн ярилцлага үзсэн чинь хууль батлагдаагүй юм чинь бараг л ингээд байж байна гээд ярилцлага өгчихсөн байна лээ. Тэгэхээр иймэрхүү зүйлүүдэд, 3 асуултад товчхон хариулаад өгчихье.

**Л.Соронзонболд:** Индрийн микрофоныг нээе.

**П.Золзаяа:** Сая улсын хяналтын шатын шүүхэд 4 сул орон тоо зарласан. Нийтдээ 16 хүн шалгалт өгсөн. Энэ шалгалтыг өгөхөөс өмнө шүүгчийн сонгон шалгаруулалтын журамд өөрчлөлт оруулж, Хууль зүйн яаманд бүртгүүлсэн. Энд хяналтын шатын шүүхийн хувьд ямар өөрчлөлт орсон бэ гэхээр тестийн шалгалтыг бол байхгүй болгосон. Тестийн шалгалт бол зөвхөн анхан шатын шүүхэд үлдээд, давж заалдах, хяналтын шатын шүүхэд бол энэ байх нь яг оновчтой шалгалтын хэлбэр биш байна гэж үзсэн юм. Тэгээд энэ 16 хүнээс шалгалт өгөөд, бичгийн шалгалтдаа бол 5 хүн тэнцсэн. Бичгийн 30 онооны шалгалтдаа, дараагийн шалгалтдаа бол 1 хүн тэнцээд, ер нь бол 4 оронтой дээр ер нь бол 3 хүн тэнцэх дөхсөн. 1 оноо л дутсан юм. 1 оноо түүнээс дотор нь маш бага оноо дутаж, ингээд зөвхөн 1нэр дэвшигч бол тэнцсэн байгаа.

2 дугаарт захиргааны ажилтны орон тоо бол дутуу байгаа. Яагаад гэвэл 2016 онд орон тоо батлахдаа 216 захиргааны ажилтны орон тоо хасчихсан. Тэгэхээр энэ хязгаар дотроо бол ажиллаж байгаа. Ер нь бол Шүүхийн тухай хуульд өөрчлөлт оруулахад бас нэлээн энэ захиргааны ажилтантай холбоотой бас оновчтой зохицуулалт хэрэгтэй байгаагийн 1 нь юу вэ гэхээр нарийн бичгийн дарга, туслах, шүүгчийн туслах гэсэн энэ 2 орон тоо шаардлагатай тохиолдолд бие биеийнхээ ажлыг хийдэг ийм бас ажлын байрны тодорхойлолтыг уян хатан болгохгүй бол жишээлбэл саяын энэ шүүх дээр бол шүүгчийн туслах байсан байгаа юм. Гэтэл туслах нь болохоор би нарийн бичгийн даргын ажлыг хийхгүй. Миний ажлын байрны тодорхойлолтод байхгүй гэсэн байгаа. Тэгэхээр нөгөө 1 нарийн бичиг нь орж орж болохгүй, 1 нарийн бичиг нь үлдэхээрээ ашиг сонирхлын хамааралтай болчихсон ийм тохиолдол бол үүссэн байна лээ. Тийм учраас энэ холбогдох хуульд бас өөрчлөлт оруулах, захиргааны ажилтны орон тоог бол оновчтой тогтоох ийм шаардлага бол байгаа.

Гэр бүл, хүүхдийн хэргийн шүүх дээр анхан шатны шүүхэд шинээр 3 шүүгч томилогдсон. 9 шүүгч бичиг бол анхан шатын шүүхээс шилжүүлэх замаар анхан шатын шүүх дээр нийтдээ 12 орон тоог бүрдүүлж байгаа. Энэ шинээр томилогдсон 3 шүүгч бол 3-уулаа Баянзүрх, Чингэлтэй, СБД-ийн эрүүгийн хэргийн анхан шат, иргэний хэргийн анхан шатад шүүгчээр ажиллаж байгаа. Ерөөсөө зүгээр байгаагүй. Шүүгчээр ажиллаад, гэр бүлийн хэргийг дагнаад шийдээд явж байгаа.

**Л.Соронзонболд:** Алтангэрэл гишүүний микрофоныг нээе.

**О.Алтангэрэл:** Би нэр дэвшигчээс асууя. Өсөхөө шүүгч бол бас олон жил яг энэ систем дээр шүүн таслах ажиллагаа хийж байгаа. Давж заалдах шатын шүүх дээр бас Эрүүгийн танхимын тэргүүн байсан туршлагатай хүн дэвшиж байгааг дэмжиж байна. Тэгээд 2 асуулт байна.

1 дүгээрт Монгол Улсын дээд шүүхийн нэн ялангуяа Эрүүгийн танхим бол Монгол Улсын эрүүгийн бодлогыг тодорхойлоход маш чухал үүрэг бүхий ийм институц. Энд хэрэг яаж шийдэж байна гэдэг бол цааш цаашдаа хэдийгээр манайх жишгийн улс биш боловч энэ шүүн таслах ажиллагаанд маш ихээр нөлөөлдөг, эрүүгийн ялын бодлогод туйлын чухлаар нөлөөлдөг газар. Тэгэхээр энд бол зөвхөн шүүн таслах ажиллагааны чиглэлээр туршлагатай төдийгүй бас тодорхой хэмжээний судалгаа хийж байсан байх ийм туршлага шаарддаг. Та урьд өмнө нь энэ хуулийн төсөл боловсруулах, хууль тогтоомжийг боловсронгуй болгох үйл ажиллагаанд оролцож байсан ийм мэдлэг туршлага байна уу гэдэг 1 дүгээр асуулт.

2 дахь асуулт иргэд хамгийн ихээр очдог анхан шатын шүүх байгаа. Ачааллаасаа шалтгаалаад өнөөдөр хуулийнхаа хугацаанд шийдэх тогтоолоо гаргадаг, гардуулдаг ийм шүүх ер нь байхаа болилоо. Хялбар ажиллагааны шүүх бий болсон боловч эрүү дээр энэ өөрчлөлт нь тодорхой харагдахгүй байна. Шүүгч нарын ажлын ачаалал их байна. Энэ дээр ер нь цаашаагаа яаж шийдвэрлэх ёстой гэж таны хувьд боддог вэ. Шийдвэрлэх арга замынх нь талаар цаашдаа ямар бодлого баримталбал энэ ачаалал буурах вэ. Шүүн таслах ажиллагааны чанар яавал сайжрах вэ гэдэг дээр та өөрийнхөө бодлыг бас хэлээч.

**Л.Соронзонболд:** Нэр дэвшигч Төмөрбаатарын Өсөхбаяр шүүгчид нэр дэвшигч хариулна. Индрийн микрофоныг нээе.

**Т.Өсөхбаяр:** Нэр дэвшигч Өсөхбаяр хариулъя. Хуулийн төслийн багт ажиллаж байсан уу гэсэн эхний асуулт байна. Миний хувьд 2 хуулийн төсөл дээр ажилласан. 2015 онд ЭХХШТХ-ийн төсөл, 2020 онд байна уу, Төлбөрийн чадваргүй этгээдэд хууль зүйн туслалцаа үзүүлэх хууль дээр ажиллаж байсан. Мөн Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн нэмэлт, өөрчлөлттэй холбоотой ажлын хэсэгт ажиллаж байсан.

ЭХХШТХ 2015 онд шинэчилсэн найруулга хийхэд бол дэлхийн жишиг ийм загвар хуулийг нэлээн баримталсан. Тэгээд дээрээс нь өөрийнхөө уламжлалт бас процессын үндсэн эрүүгийн процесст хэрэглэдэг хэм хэмжээнүүдээ бол авсан.

Юуны хувьд 2 дахь асуулт дээр эрүү, иргэний хялбар ажиллагааны анхан шатны тойргийн шүүх байгуулагдсан. Энэ бол 2019 онд Үндсэн хуульд нэмэлт,, өөрчлөлт оруулсантай холбоотойгоор тойргийн шүүх дагнасан шүүх байгуулах энэ эрх зүйн үндэслэлийг тавьсан. Тэгэхээр иргэнд шүүх үйлчилгээний байгууллага. Тэгэхээр иргэн төвтэй шүүх байгуулах, иргэдэд шүүхийн үйлчилгээг ойртуулах энэ асуудал бол тойргийн шүүх байгуулах ийм асуудал байгаа. Тэгээд тойргийн шүүхийг бол нутаг дэвсгэрийн харьяалал, хүн амын тоо, хэргийн тоо зэргийг харгалзаж байгуулдаг.

Эрүү, иргэний хэргийн хялбар ажиллагааны анхан шатны тойргийн шүүх бол өнөөдрийн байдлаар бол ачаалал өндөр байгаа. Тэгэхээр 1 дүгээрт энэ хэрэгт хэргийн харьяаллын асуудал байж байгаа юм. Энэ дээр зөрчлийн хэрэг бол асар их гарч байна. Нөгөө талдаа иргэний хэргийн жижиг маргаанууд. Энэ бол жижиг маргаанд хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 20 дахин нэмэгдүүлсэнтэй холбоотой үнийн дүнтэй маргаанууд байж байгаа. Тэгэхээр миний авсан мэдээллээр бол энэ зах зээл дээр маш олон төрлийн бизнес, үйлчилгээнүүд орж ирж байна. Энэ үйлчилгээг дагаад шүүхийн ачаалал ихсэж байгаа. Тэгэхээр энэ төрлийн ачаалалтай уялдуулаад орон тоо гэхээсээ илүү буцаж нөгөө эрүү, иргэний хэргийн хялбар ажиллагааны анхан шатын тойргийн шүүхийн хянан шийдвэрлэж байгаа хэргийн тэр зарим харилцааг нь авч ердийн төрөлжсөн шүүхдээ өгөх байдлаар ингэж тэнцвэржүүлж бас байж болох юм л гэсэн бодолтой байна.

**Л.Соронзонболд:** Ганбат гишүүн асуулт асууя.

**Д.Ганбат:** Яах вэ, Шүүхийн ерөнхий зөвлөл, Улсын дээд шүүхэд дэвшиж байгаа шүүгч нараас тэр болгон асуугаад байх биш. Шүүгч нартай бол бид нар протоколтой л уулзаж байх ийм хуультай л даа. Гэхдээ ганц нэг юм бас тодруулмаар байна.

Байнга улс төрч нар янз бүрийн юманд орооцолдох юм. Би ч ямар тийм юманд орооцолдох биш. Шүүх шүүхээр явах ч биш дээ. Гэхдээ Шүүхийн ерөнхий зөвлөл шалгаруулаад ингээд яваад байдаг. Шүүхийн хараат бус бие даасан байдал маш чухал. Ийм байх ч ёстой. Гэтэл өнөөдөр бол энэ гаднын хөрөнгө оруулагчдын ярьж байгаагаар ер нь гадаадын хөрөнгө оруулалт гэж байхгүй болчихлоо. Эрүү ч бай, иргэн ч бай энэ асуудлаа шийдүүлэхэд тийм итгэлтэй бус байна. Оюутолгойг оруулахгүйгээр гадаадын хөрөнгө оруулалт ингээд буурчхаад байна. Ярихаараа яг шударга бие даасан шүүх Монгол Улсад байна уу, байхгүй юу гээд ингээд ярьдаг. Энэ дээр бол Казакстан бол аягүй ахиц дэвшил гаргасан. Хэдэн жилийн өмнө шүүгч нараа гаднын шүүгч нараар Францаас, Германаас авчирч ирээд томилоод ажиллуулсан. Тэр нь маш их үр дүн өгсөн гэж байгаа. Энэ талаар та нар ямар бодолтой байна вэ.

Нөгөө талаар бол явал сайжрах вэ. Шүүх үйл ажиллагааг Монгол Улсад ганцхан шүүх явуулна гэж байгаа. Гэтэл энэ сахилгын хороо чинь яагаад байгаа юм бэ. Нэлээн хэдэн шүүгч нар орсон юм билээ. Тэгээд шүүгч нарыг шүүсэн юм билээ. Ингэж ойлгож болох уу. Тэр нь гэмт хэргийг нуун даллаад байна уу. Нөгөө шүүгчийг бараг гэмт хэрэг үйлдсэн шахуу юм яриад, гэм буруутайг нь тогтоогоод, шүүгчээс нь авчихдаг. Тэр нь нэг бодлын нөгөө шүүгчээ өмгөөлөөд ч байгаа юм шиг, үгүй ч юм шиг. Хэрвээ гэмт хэрэг үйлдлээ, гэм буруутайг нь тогтоосон бол тэр бол тэр хуулиараа л шийдэгдэх ёстой. Энийг та бүхэн юу гэж үзэж байна вэ гэсэн ийм асуултууд байна.

**Л.Соронзонболд:** Золзаяа дарга. Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга хариулна. Индрийн микрофоныг нээе.

**П.Золзаяа:** Энэ саяын асуулт бол маш чухал бөгөөд яг нийгэмд хариултаа нэхэж байгаа, нийгэмд үнэлэгдэж байгаа үнэлэмжтэй холбоотой ийм бодлогын асуулт байна.

Шүүх иргэдийн итгэлийг хүлээсэн байх шударга байх гэдэг тэр хэмжүүр бол хэрэглэж байгаа хуульд байгаа 1 дүгээрт. Хууль өөрөө яг бодит амьдралыг зохицуулж чадсан уу, үгүй юу гэдэг асуудал. 2 дугаарт хуулийг хэрэглэж байгаа шүүгч өөрөө яг зөв хэрэглэж байна уу, шударга байна уу гэдэг 2 юман дээр тогтдог. Ер нь бол аль алинд нь асуудал байгаа гэж боддог. Тэгэхдээ бас баримтаар ингээд судалгаагаар үзэх юм бол шүүхийн шийдэж байгаа хэрэг хэдэн хувь нь давж заалдах гомдол гаргаад, хэдэн хувь нь хяналтын журмаар гомдол аваад байдаг маш чухал байгаа. Жишээлбэл эрүү, иргэн, захиргааны гэсэн энэ 3 төрлийн эрх зүйн маргаанаас иргэний эрх зүйн маргааны давж заалдах гомдлын тоо дандаа буурсаар байгаад өнөөдөр 3 хувьд хүрээд, анхан шатны шүүхээс 97 хувийг нь шийдээд, хүчин төгөлдөр болж байгаа ийм үзүүлэлт байгаа. Тэгэхээр би энийг бол ямар ч байсан сайн тал руугаа явж байна гэж харж байгаа.

Сахилгын хорооны хувьд бол Шүүхийн тухай хууль дээр 50.1.23 гээд хуулийн илт тодорхой заалтыг буруу хэрэглэсэн гэдэг ийм заалтаас болж ер нь бол мэргэжлийн алдаа, ёс зүйн алдаа гэдэг 2 юм холилдоод, өнөөдөр ингээд тогтож өгөхгүй ийм ээдрээтэй асуудал байгаа. Тэгээд энэ дээр бол хууль тайлбарлаж байгаа, дээд шүүхийн тайлбар ч байгаа. Энүүгээр ингээд ойлгоод явбал уг нь боломжтой байгаа. Гэтэл яг нэг мөр ойлгохгүйгээр янз бүрийн шийдвэр гарч байгаа тохиолдлыг бид нар бас энэ дээр эвлэрэхгүй. Яадаг ч байсан байр сууриа илэрхийлээд л явж байгаа. Сахилгын хорооны хувьд бол цэвэр сахилгын зөрчил, ёс зүйн алдааг хянаж, хариуцлага ногдуулах л ийм эрх байгаа болохоос биш яг ийм

хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаатай холбоотой хэрэг шийдвэрлэхтэй холбоотой хуулийг зөв тайлбарласан уу, буруу тайлбарласан уу гэдэг асуудал бол ерөөсөө огт хамаа байхгүй. Тэгээд энэ дээр бол цаашид Шүүхийн тухай хуульдаа өөрчлөлт оруулах, мэргэжлийн алдааг ялгаж салгаж зохицуулах ийм шаардлага бол байгаа гэж бодож байгаа.

**Л.Соронзонболд:** Ганбат гишүүн болсон уу. Ганбат гишүүн тодруулъя.

**Д.Ганбат:** Сүүлийн үед шүүгчийн сонгон шалгаруулалт явагдаад, 1 бол тэнцэхгүй байна гэсэн, 1 бол шүүгч болох хүмүүсийн тоо цөөрөөд байна гэсэн. Энэ юутай холбоотой байна вэ. Нөгөө талаар шүүгч нарын дундаж нас ямар байна вэ. Бид нарын мэддэг АНУ гэхэд бол шүүгч нар бол бүх насаараа л байдаг шүү дээ.

Нөгөө талаар бол гишүүд сая Ерөнхийлөгчийн хуультай холбогдуулаад ёс зүйг хуульчилна, хуульчлахгүй гээд хэзээ ч хуульчилдаггүй гэж яриад байна лээ. Миний ойлголтоор бол Шүүхийн тухай хуульд шүүгчийн ёс зүй гэдэг ойлголт байгаа байх. Би хуульчилчихсан юм байна гэж ойлгоод байгаа. Энэ талаар ямар ойлголттой байна.

**Л.Соронзонболд:** Индрийн микрофоныг нээе.

**П.Золзаяа:** Ер нь нэлээн хэдэн жил ингээд шүүгчийн сонгон шалгаруулалт явуулаад тэнцэж байгаа шүүгчийн тоо бол их цөөн байсан. Тэгээд энэ дээр бид нар судалгаа хийгээд, шүүгчийн сонгон шалгаруулах журамд өөрчлөлт оруулсан. Үүнийг судлаад үзэхээр шалгалтын хэлбэр нь бол оновчгүй байсан ийм тохиолдлууд байгаа.

2 дахь нь нөгөө шалгалтыг үнэлж байгаа үнэлгээ өөрөө яг хуульд нийцэж байна уу, үгүй юү гэдэг ийм асуудал байсан. Тэгээд энэ дээр бид нар судлаад, ер нь бол үнэлгээнд бас шинжээч оролцуулж болно гэж журамдаа оруулаад, сая хяналтын шатын шүүхийн шалгалтыг авахад бол 1 удаагийн тэр хууль тайлбарлах шалгалт дээр бол шинжээч нарыг оролцуулсан. Улсын дээд шүүхээс 1 хүн, Үндсэн хуулийн цэцгээс 1. Дандаа докторын зэрэгтэй, тэгээд Их сургуулиас 1 доктор багш ингээд тус тус оролцуулаад, хариултынх нь талаар тэр хариулт хангалттай юу, үгүй юү, нэмж анхаарах зүйл байна уу, үгүй юү гээд санал бодлоо солилцоод .../минут дуусав/

**Л.Соронзонболд:** Хариултыг гүйцээе. Индрийн микрофоныг нээе.

**П.Золзаяа:** Шүүгчийн дундаж нас ер нь бол шүүгч нар 60 хүрээд л тэтгэвэртээ гарч байгаа. Нийтдээ 504 шүүгч бол яг ажиллаж байна. Үүнийг бол насны ангиллаар ангилсан. 10 жилд бол ер нь 2 хувь хүрэхгүй ийм өөрчлөлт ордог. Шүүгч нарын бүрэлдэхүүнд. Яг насны хувьд гэвэл 10 жил ажиллахаар байгаа 20 хувь нь. Хамгийн удаан ажиллах байгаа нь 20 жил ажиллах нь 34 хувь гэсэн ийм үзүүлэлтүүд гараад явж байгаа. Тэгэхээр бид нар энийг яагаад гаргадаг вэ гэхээр нөгөө шүүгчийн хөдөлгөөнд ямар өөрчлөлт орох нь, тэгээд дараагийн цаашид юу төлөвлөх вэ гэдэг зорилгоор энэ шүүгч нарын дундаж насыг тодорхойлж бас цаашид нөгөө хяналтын шатад давж заалдах шатад ажиллах, тэгээд анхан шатад ямар хэмжээний шүүгч шинээр авах гэсэн энэ асуудлуудаа бол төлөвлөдөг.

**Л.Соронзонболд:** Ганбат гишүүн тодруулъя. Ёс зүйн асуудлаар асуусан. Тэрэнд хариулъя. Индрийн микрофоныг нээе.

**П.Золзаяа:** Ёс зүйг хуульчилдаггүй гэдэг тэр онол үзэл баримтлал бол зөв. Шүүхийн тухай хуульд бол шүүгч ёс зүйн нийтлэг болсон заавал мөрдөх ёстой болоод хэм хэмжээ болж орсон зохицуулалтууд бол байгаа. Шүүгчийн ёс зүйн дүрэм гэж тусдаа дүр юм бол байхгүй болсон. Тэгээд Шүүхийн тухай хуулиар бол тэр хэм хэмжээгээр илэрхийлээд, ёс зүйн хувьд бол хариуцлага хүлээх ийм нөхцөл бол бүрдсэн байгаа. Одоо жишээлбэл наад зах нь гэхэд ажилдаа ирэхгүй, ажлаа таслах гэдэг бол хэдийгээр ёс зүй яригдаж байгаа боловч энэ нь өөрөө заавал байх ёстой ийм нийтлэг байгаа учраас хэм хэмжээ болоод ингээд хуульд орсон байгаа.

**Л.Соронзонболд:** Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга болон Улсын дээд шүүхийн шүүгчид нэр дэвшигчээс 1 асуулт асууя. Одоо энэ шүүхийн үйл ажиллагаа, эрх зүйн байдалтай холбоотой нэн яаралтай шийдэх шаардлагатай ямар асуудлууд байгаа вэ. Энэ талаар саналаа хэлээч гэж асуух гэсэн юм. Индрийн микрофон дээр хариулъя.

**П.Золзаяа:** Энэ дээр эрх зүйн орчныг бүрдүүлэх тухайд гэвэл Шүүхийн тухай хуульд нэлээн өөрчлөлт оруулах шаардлага бол байгаа. Энэ дээр бид нар ажлын хэсэг гарчихсан ажиллаж байгаа. Дээрээс нь Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, Гэр бүлийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль гэх мэт энэ гол гол хуулиуд дээр өөрчлөлт оруулж байж бид нар энэ шүүхэд бол нэлээн өөрчлөлт гарах юмнууд бол байгаа. Жишээлбэл, хялбар ажиллагааны шүүх дээр шүүх хуралдаангүйгээр шийдвэр гаргадаг процесс бол бусад улс оронд байдаг юм байна лээ. Тэгэхээр өнөөдөр хуралдаан заавал хийхгүйгээр шийдвэрээ гаргах тийм нөхцөл бол байгаа гэдэг нь тогтоогдоод байгаа. Ер нь бол судалгаагаар шууд шийдвэрээ гаргачих ийм нөхцөл байхад заавал хуралдаан хийх, дуудах, эсвэл тэгээд л нөгөө заалаа хүлээх гэх мэт ийм ажил бол байхгүй байх боломжтой байгаа. Гэх мэтчилэн яг шаардлагатай хуулиуд дээр бол бид нар нэлээн идэвхтэй оролцоод явж байгаа.

**Л.Соронзонболд:** Нэр дэвшигч хариулъя. Индрийн микрофон.

**Т.Өсөхбаяр:** Нэр дэвшигч Өсөхбаяр. 2021 оны шүүхийн тухай хуулиар бол нийт шүүгчдийн чуулганы хуралдаан гэсэн ийм өөрөө удирдах ёсны зарим асуудлыг өөрсдөө шийдэх ийм эрх зүйн зохицуулалт орсон. Энэ нийт шүүгчийн чуулганы хуралдаанаар хэлэлцэх асуудалд бол тодорхой асуудлуудыг буюу шүүх эрх мэдлийн байгууллага өөрсдөө шүүхийн хэмжээнд хэрэглэгдэх хуулийг сайжруулах, нэн шаардлагатай байгаа эрх зүйн зохицуулалтыг Улсын дээд шүүхээр дамжуулж, хууль тогтоогчид, хууль санаачлагчид уламжлах ийм эрх зүйн зохицуулалттай болсон. 2025 онд 3 дугаар чуулган болсон. Энэ 3 дугаар чуулганаар бол ЭХХШТХ-д заасан хэргийн бодит байдлыг тогтоох .../минут дуусав/

**Л.Соронзонболд:** Гүйцээж хариулъя. Индрийн микрофон.

**Т.Өсөхбаяр:** Хэргийн бодит байдлыг тогтоохтой холбогдуулж асуудлыг хөндсөн. Энд 1 дүгээрт ЭХХШТХ-д анхан болон давж заалдах шатны шүүхүүд давж заалдах шатны шүүх, анхан шатны шүүх хэргийн бодит байдалтай нийцээгүй дүгнэлт хийсэн, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны ноцтой зөрчил гаргасан, Эрүүгийн хуулийг буруу хэрэглэсэн энэ үндэслэлүүдээр анхан шатныхаа шүүх рүү буцаах ийм эрх хэмжээг бол хязгаарлачихсан ийм зохицуулалттай байгаа. Тэгэхээр энэ саналыг бол бас уламжилсан байгаа байх гэж бодож байна.

**Л.Соронзонболд:** Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга болон нэр дэвшигчээс гишүүд асуулт асууж, үг хэлж дууслаа. Улсын дээд шүүхийн шүүгчид нэр дэвшигчтэй танилцсан талаарх Байнгын хорооны санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Оюунсайханы Алтангэрэл танилцуулна.

17.21 цаг.

Дараагийн асуудалдаа оръё.

**Монгол Улсын нэгдсэн төсвийн 2027 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2028-2029 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төсөл Засгийн газар 2026 оны 5 дугаар сарын 1-ний өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлгийг явуулъя.**

Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан хуралдаанд оролцож байгаа албан тушаалтнуудыг танилцуулъя. Жадамбын Энхбаяр Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд, Загджавын Мэндсайхан Сангийн сайд, Содномдаржаагийн Даваасүрэн Эдийн засаг, хөгжлийн дэд сайд, Идэшийн Батхүү Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Бат-Ирээдүйн Анар Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Лхагвабаярын Энх-Амгалан Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга, Батчулууны Мөнгөнсүх Эдийн засаг, хөгжлийн яамны Хөгжлийн нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын дарга, Батхишигийн Мөнх-Эрдэнэ Эдийн засаг, хөгжлийн яамны Хөрөнгө оруулалтын бодлогын газрын дарга, Даринчулууны Эрдэнэтуяа Эдийн засаг, хөгжлийн яамны Худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааны бодлогын газрын дарга, Мижиддоржийн Санжаадорж Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга, Жамъяншаравын Дэлгэржаргал Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга, Солонгын Тулга Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын дарга, Отгондэмбэрэлийн Мягмардорж Эдийн засаг, хөгжлийн яамны Төсвийн хүрээний төлөвлөлтийн хэлтсийн дарга, Цасчихэрийн Мөнхдэлгэр Эдийн засаг, хөгжлийн яамны Эдийн засгийн бодлого төсөөллийн хэлтсийн дарга, Батжаргалын Төгөлдөр Эдийн засаг, хөгжлийн яамны хөгжлийн төсөл, хөрөнгө оруулалтын удирдлагын хэлтсийн дарга, Райымбек Эдийн засаг, хөгжлийн яамны Салбар дундын бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга, Пүрэвдоржийн Чандмань Эдийн засаг, хөгжлийн яамны Тогтвортой хөгжил, нийгмийн бодлогын хэлтсийн дарга, Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс Жамсрандоржийн Дэлгэрсайхан Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн дарга, гишүүн, Амаржаргалын Энхбат Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн, Намжилдоржийн Энхбаяр Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн, Төсвийн ерөнхийлөн захирагч нарыг танилцуулъя. Заяадэлгэр Монгол Улсын дээд шүүхийн Тамгын газрын дарга, Эрдэнэчимэг Шүүхийн сургалт, судалгаа мэдээллийн хүрээлэнгийн захирал, Сүглэгмаа Улсын дээд шүүхийн Ерөнхий нягтлан бодогч, Шүүхийн ерөнхий зөвлөлөөс Энхбаатар Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүн, Эрдэнэтулга Шүүхийн ерөнхий зөвлөлийн Гүйцэтгэх нарийн бичгийн дарга, Наранбилэг Шүүхийн ерөнхий зөвлөлийн Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга, Шүүхийн сахилгын хорооноос Энхтөр Шүүхийн сахилгын хорооны ажлын албаны дарга, Ариунжаргал Шүүхийн сахилгын хорооны ажлын албаны Ерөнхий нягтлан бодогч, Хүний эрхийн Үндэсний Комиссоос Ихтамир Хүний эрхийн Үндэсний Комиссын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Захиргаа, удирдлагын хэлтсийн дарга, Авлигатай тэмцэх газраас Баасанням Авлигатай тэмцэх газрын Тамгын хэлтсийн дарга, УЕПГ-аас Чулуунбат УЕП-ын туслах прокурор, Хэрэг эрхлэх газрын дарга, Ганболд УЕПГ-ын Бодлого, төлөвлөлт,

шинжилгээ, үнэлгээний газрын ахлах прокурор, Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах улсын комиссоос Очирсүрэн Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах улсын комиссын Ажлын албаны дарга, Хажидмаа Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах улсын комиссын нягтлан бодогч, Хууль зүй, дотоод хэргийн яамнаас Амарсайхан Хууль зүй, дотоод хэргийн сайд, Мягмар Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Отгонбаяр Хууль зүй, дотоод хэргийн яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга, Базаргүр Хууль зүй, дотоод хэргийн яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын ахлах шинжээч, Хатантуул Хууль зүй, дотоод хэргийн яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын ахлах шинжээч, ЦЕГ-аас Батчулуун Цагдаагийн ерөнхий газрын Санхүү, ар талын албаны дарга, цагдаагийн хурандаа, Оюунбаатар Цагдаагийн ерөнхий газрын Санхүү, ар талын албаны Санхүүгийн хэлтсийн Дотоод хяналт хариуцсан чиглэлийн ахлах мэргэжилтэн, цагдаагийн дэд хурандаа, Бямбасүрэн ХХЕГ-ын дарга, Хилийн цэргийн командлагч, бригадын генерал, Чойжилсүрэн ХХЕГ-ын Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга, ерөнхий нягтлан бодогч, хурандаа, Ариунаа ХХЕГ-ын Санхүү, хөрөнгө оруулалтын газрын Төсөв, төлөвлөлтийн ахлах офицер, дэд хурандаа, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар Намсаманд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын Тэргүүн дэд дарга бөгөөд Хорих ял эдлүүлэх албаны дарга, хурандаа, Өнөртуяа ШШГЕГ-ын Санхүү, үйлдвэр, хөрөнгө оруулалтын газрын дарга, хурандаа, Энх-Од ШШГЕГ-ын Эдийн засаг, төлөвлөлтийн хэлтсийн дарга, хошууч, Давааням УБЕГ-ын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Энхнаран УБЕГ-ын Санхүү, аж ахуйн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Ганбаяр Шүүх шинжилгээний ерөнхий газрын дарга, цагдаагийн хурандаа, Алтансүх Шүүх шинжилгээний ерөнхий газрын Санхүү, хангамжийн газрын дарга, цагдаагийн хурандаа, Ууганбаяр ГИХГ-ын дарга, Солонгоо ГИХГ-ын Санхүү, хяналт үйлчилгээний газрын дарга, Хууль зүйн үндэсний хүрээлэн Жамъянхүү Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн захирал, Уранчимэг Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн Захиргаа, удирдлагын хэлтсийн ахлах нягтлан бодогч, Нямгэрэл АЕГ-ын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Лхамсүрэн АЕГ-ын Санхүү, аж ахуйн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Ганзориг Мэдээлэл шуурхай удирдлагын төвийн дарга, цагдаагийн хурандаа, Уянга Мэдээлэл шуурхай удирдлагын төвийн Захиргаа, удирдлагын газрын Санхүү, ар талын тасгийн дарга, цагдаагийн ахмад, Азбаяр Дотоод хэргийн их сургуулийн дэд бөгөөд Эрдэм шинжилгээ, инновацын газрын захирал, цагдаагийн хурандаа, Гантулга Дотоод хэргийн их сургуулийн Санхүү, төлөвлөлтийн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, цагдаагийн хошууч, Нарантуяа Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлгийн захирал, хурандаа, Баярсайхан Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлгийн Төлөвлөлт үйл ажиллагаа эрхэлсэн дэд захирал, дэд хурандаа, Уянга Хууль зүйн туслалцааны төвийн дарга, Болор-Эрдэнэ Хууль зүйн туслалцааны төвийн ахлах нягтлан бодогч, Буянбат Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн Ажлын албаны дарга.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-д заасны дагуу хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэх бөгөөд хуулийн төсөл 1 зүйлтэй. Гишүүн хуулийн төслийн тухайн зүйлтэй холбогдуулан Төсвийн тогтвортой байдлын зөвлөл болон төсвийн ерөнхийлөн захирагч нараас асуулт асууж болно.

Хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү. Номинчимэг гишүүнийг нэмье. Номинчимэг гишүүнээр тасаллаа. Сайнзориг гишүүн асуулт асууя.

**П.Сайнзориг:** Товчхон л асууя даа. 1 дүгээрт олон байгууллага байгаа учраас товч товч асуугаад явчихъя.

ОХУ-тай хилийг шалган баталгаажуулах ажиллагаа ер нь ямар явцтай байна. Ирэх жилүүдэд энэ ажлууд ер нь ямар гүйцэтгэлтэй байх юм. Төсөв мөнгө зохион байгуулалтын ажил дээр ямар нэгэн саад гарч байгаа юм байгаа юу. Ер нь бид хэд бас том зургаараа хойд хөрштэйгөө хилээ баталгаажуулж бас НҮБ-д бүртгүүлэх тийм том амбиц бол байгаа шүү дээ. Тэгэхээр энэ дээр ямар явцтай байна. 1 дүгээрт хариулж өгөөч.

2 дугаарт Хууль зүй, дотоод хэргийн яам ер нь зүгээр эдийн засаг, бизнесийг дэмжих чиглэлийн асуудал дээр яг энэ Засгийн газрын мөрийн хөтөлбөрийг биелүүлэх чиглэлд ер нь ямар бодлогын арга хэмжээнүүдийг төлөвлөж, Улсын Их Хуралд оруулж ирэхээр төлөвлөж байгаа вэ. Хүмүүс бол ингээд харахаараа нөгөө Хууль зүй, дотоод хэргийн яам, цагдаа хүчний байгууллагатай харьцдаг гэдэг боловч маш их хэмжээний бизнесийн хууль тогтоомжуудыг бол бас энэ яам шинэчилж, дүгнэж, энийг бас сайжруулж явах ёстой. Тэгэхээр энэ дээр ер нь ямар бодлогын өөрчлөлтүүдийг, хаврын чуулганд ямар хуулиуд байна. Намрын чуулганд ямар байна?. Их жилүүдэд ер нь ямар бодлого, төлөвлөлтүүд байна. Энэ дээр бас нэг хариулаач.

УБЕГ-аас асууя. Би бас орон сууц захиалгатай холбоотой залилантай холбоотойгоор урьдчилан сэргийлэх чиглэлээр хуулийн төсөл боловсруулж байгаа. Энэ хуулийн төслийн маань бас гол 1 амин сүнс нь тодорхой мэдээллүүдийг нээлттэй мэдээлэл болгож, мэдээлэл солилцох, иргэд байр захиалгын гэрээ гэдэг юм уу, энийг давхар захиалга байна уу, өмнө нь захиалга байна уу, үгүй юу гэдгийг шалгаж, нягтлах энэ дэд бүтцийг бий болгох зайлшгүй шаардлагатай байгаа. Энийг бас Хууль зүй, дотоод хэргийн яам дээр олон жил бас яригдаж байсан. Төлөвлөлтүүд бол хийгдээд явж байсан. Тэгэхээр энэ бас ирэх жилийн хөгжлийн төлөвлөгөө болон ер нь ирэх жилүүдэд энэ чиглэлийн ажлууд дээр хөрөнгө, санхүү, зохион байгуулалтын хувьд юу гэж төлөвлөж харж байгаа вэ. Энийг хариулж өгөөч.

Прокурорын ерөнхий газраас асууя. Энэ ЭБАТ-ууд 12, 13 мянган ЭБАТ-уудын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны, зөрчлийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны цахимжуулах асуудал байгаа. Программ хангамжийн хувьд Германы техникийн хамтын ажиллагааны шугамаар Нямбаатар сайдын үеэс эхлээд л хийгээд явж байсан. Яг ашиглалтад орлоо гэдэг зүгээр тууз бол хайчилчихсан. Энэ яг бодит хэрэгжилтийн хувь дээр ямархуу байна вэ. Хүн, хүч хэмнэж чадаж байна уу. Эргээд энийг ЭБАТ-ууд маань хэрэглэж болж байна уу. Эдийн засгийн үр ашиг байна уу. Цаад талын хүний эрхийг хамгаалах чиглэлд уг нь чухал юм байгаа юм л даа. Тэгэхээр энэ чиглэлийн нөгөө зохион байгуулалт, төсөв мөнгө ер нь прокурорын газраас ямархуу байдлаар хангаж, ер нь энэ зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааг цаасгүй болгох энэ ажиллагаа дээр ямар ахицууд байна вэ. Энэ бас ирэх жилийн юмнууд дээр ямархуу байдалтай явж байна.

Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх зөвлөлөөс асууя. Энэ хар тамхитай тэмцэх чиглэл дээр ер нь ямар арга хэмжээ авах гэж байна. Гамшиг боллоо гээд үе үеийн сайд .../минут дуусав/

**Л.Соронзонболд:** Бямбасүрэн генерал индрийн микрофоноор хариулъя. Бусад байгууллагын төлөөллүүд хариулахад бэлдэж байгаарай. Индэр дээрээс хариулна шүү.

**Ж.Бямбасүрэн:** Сайнзориг гишүүний асуултад хариулъя.

ХХЕГ-ын дарга, хошууч генерал Бямбасүрэн илтгэж байна. Монгол, Оросын хилийг хамтран шалгах ажлын явц өнөөдрийн байдлаар 78 хувьтай явагдаж байна. 2022 онд эхэлсэн. Одоо гол хүндрэлтэй хэсэг буюу Минжийн хилийн хэсэгт Хөвсгөл далайн 2 талын хэсгийн хилийн төхөөрөмжийн ажлууд хийгдэж байгаа. Хил хамгаалах байгууллагын хувьд бол хилийн төхөөрөмжийн ажил буюу яг хилийн багана суурилуулах ажлыг хариуцаж байгаа. Саяхан 7 хоногийн өмнө Минжийн хэсгийн багана суурилуулах ажлыг бол эхлүүлсэн. Энэ өвөл бид нар хилийн багануудыг тээвэрлэж хүргэсэн. Ажлын явц бол үндсэндээ 78 хувьтай. Энэ жил бид нар 90 хувьд хүргэнэ гэж тооцож байгаа. Төсөв, санхүүгийн хувьд бол энэ онд 4,5 тэрбум төгрөг тавигдсан. Хил хамгаалах байгууллагын хувьд бол яг энэ хилийн төхөөрөмжийн ажлаа хариуцаад суурилуулчих боломжтой гэж үзэж байгааг танд танилцуулж илтгэе.

Тэгээд ер нь бол 2027 ондоо бид нар багтаж төхөөрөмжийн ажлыг дуусгана. Цаашдаа бас протокол, бичиг баримтын ажил бүрэн гүйцэт дууссан тохиолдолд хойд хилийг НҮБ-д бүртгүүлэхээр бас төлөвлөж зорьж ажиллаж байгааг илтгэе. Илтгэж дууслаа.

**Л.Соронзонболд:** Улсын бүртгэлийн ерөнхий газар.

**Д.Давааням:** Та бүхэнд өдрийн мэнд хүргэе. УБЕГ-ын дарга Давааням. Гишүүний асуултад асуугдсан дуусаагүй барилга залилангийн гэмт хэрэгт өртөөд байгаа захиалгын гэрээг улсын бүртгэлд бүртгэх асуудал өнөөдрийн хувьд бол Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хуулиар бол захиалагчийн буюу иргэний хүсэл зоригийн шинжтэй байгаа. Бүртгүүлж болно гэсэн хуулийн заалттай. Энэ хуулийн заалтад өөрчлөлт оруулахаар эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлд нэмэлт, өөрчлөлт оруулах төсөл явагдаж байгаа.

Энэ иргэний захиалгын гэрээгээ баталгаажуулах буюу улсын бүртгэлд бүртгүүлэхдээ мэдээлэл, лавлагаа авдаг, өргөдөл, хүсэлт өгч, түүнд нь хариулт хийдэг AI төхөөрөмжийн худалдан авах ажиллагааг сая зарлаад, гэрээ байгуулагдаад ажиллаж байгаа. Ингээд энэ гэрээ программын асуудлууд шийдэгдчихвэл Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн шинэчилсэн программтай холбогдоод тэндээсээ манайх .../минут дуусав/

**Л.Соронзонболд:** Прокурорын ерөнхий газар.

**Д.Чулуунбат:** Сайн байцгаана уу. Зөрчлийн мэдээллийн систем маань 100 хувь ашиглалтад орсон. Германы техник хамтын ажиллагаагаар хийгдээд, энэ жилээс эхлээд 100 хувь ашиглалтад орж байгаа. Нийтдээ 12 мянга гаруй ЭБАТ-ууд сургалтаа ороод, одоо хэрэгжээд явж байгаа. Зөрчлийн мэдээллийн систем ашиглалтад орсноор тухайн албан хаагчийн ачаалал болон эдийн засгийн үр ашиг дээшилж байгаа. Гэхдээ Эдийн засаг, хөгжлийн яамнаас энэ зөрчлийн мэдээллийн системтэй холбоотой системийн өргөтгөл, дээр нь системийн тоног төхөөрөмжид нэмэлтээр шаардлагатай байгааг бид нар дурдсан боловч бас эдийн засгийн хөгжлийн төлөвлөгөөнөөс бас хасаж, тусгасан байгаа. Энэ л жоохон хүндрэл учирч магадгүй. Тэрнээс бусад зөрчлийн мэдээллийн систем ЭБАТ-ууд бүгд ашиглаад явж байгаа.

**Л.Соронзонболд:** Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх төв.

**Ж.Буянбат:** Сайн байцаана уу. Ажлын албаны дарга Буянбат. Хар тамхитай тэмцэх чиглэлээр Засгийн газар гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, тэмцэх чиглэлийн хуулийн шинэчилсэн найруулгын төслийг Их Хуралд өргөн барьсан байгаа. Үндэсний аюулгүй байдлын зөвлөлөөс 2 удаа зөвлөмж гаргасан. Ерөнхий, тусгай, нэг бүрчилсэн энэ арга хэмжээнүүд төлөвлөгдөөд явж байгаа.

Ажлын алба дээр энэ онд бол яг энэ хар тамхины чиглэлээр төсөв байхгүй. Төсөв батлагдаагүй. Ирэх жилийн 2027 оны хөгжлийн төлөвлөгөө дээр Донтолтыг сэргээн засах төв, тэгээд сургалт соён гэгээрүүлэх чиглэлээр 6,5 тэрбум төгрөгийн санал тусгагдчихсан явж байгаа.

**Л.Соронзонболд:** Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Мягмар.

**Н.Мягмар:** Сайнзориг гишүүний асуултад хариулъя. Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Мягмар. Эдийн засаг, бизнесийн чиглэлийг дэмжих чиглэлээр ялангуяа хувийн эрх зүйн чиглэлийн холбогдолтой хууль тогтоомжийн төслүүдийг 2024-2028 онд хууль тогтоомжийг боловсронгуй болгох үндсэн чиглэлд тусгасны дагуу мөн Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгасны дагуу бас боловсруулаад явж байна. Яг одоогийн байдлаар Улсын Их Хуралд өргөн мэдүүлчихсэн, хэлэлцэх эсэхийг нь шийдүүлэх хүлээгдэж байгаа Төлбөрийн чадваргүйдлийн буюу дампуурлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл явж байна. Мөн одоо эцэслэн боловсруулаад, санал авах төсөлд гаргачихсан хуулийн төсөл маань Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл явж байна. Мөн нөгөө талаасаа цаашид боловсруулж байгаа санал гаргахаар бэлтгэж байгаа төслүүд болох Компанийн тухай хуулийн шинэчилсэн .../минут дуусав/

**Л.Соронзонболд:** Хариултыг гүйцээе. Индрийн микрофоныг нээе.

**Н.Мягмар:** Компанийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон арилжааны хуулийн төслүүдийг санал авахаар бэлтгэж байна. Мөн нөгөө талаасаа шүүхийн шийдвэр гүйцэтгэлтэй холбоотой ялангуяа иргэний шийдвэр гүйцэтгэл хуулийн этгээдийн данс, төлбөр тооцоог шийдвэр гүйцэтгэлийг албадан гүйцэтгүүлэх хүрээнд шийдвэрлэдэг бас хууль тогтоомжийн төслүүд болох Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн багц хуулийн төслүүд болон мөн санал аваад эцэслэн дахин улсын Засгийн газраар хэлэлцүүлэхээр бэлтгэлийг хангаж байна.

**Л.Соронзонболд:** Сайнзориг гишүүн тодруулъя.

**П.Сайнзориг:** Тэгээд улс орны аюулгүй байдлаас харамлах юм бол ирээдүйд бас том дүнгээр төлдөг гэдэг ерөнхий 1 зарчим байдаг. Тэгээд би бас зүгээр сая товчхон л асуулаа. Асуудлууд мэдээж энэ том салбар учраас заримаас нь бол асууж амжсангүй. Сая бас хүний эрхийн үндэсний тайлан дээр тэр шүүх шинжилгээний байгууллагын бас асуудалтай орон нутагт ялангуяа цогцос хадгалах хөргүүр байхгүйгээс алба хаагчид нь хүртэл сэтгэл санааны асуудалд орчихсон байна гээд тэгсэн. Энэ чиглэлийн ажлууд дээр ямархуу бас тавьж байна.

Архины санг ашиглах асуудлыг Эдийн засгийн сайд, Сангийн яам маань анхаарч өгөөч. Энэ төсвийн мөнгө биш байхгүй юу. Архи үйлдвэрлэгч этгээдүүд өөрсдөө сангаа бүрдүүлээд, энийг хар тамхи, дэлгэцийн дон, архины донтой хүмүүсийг эмчлэх асуудалд зарцуулъя гэхээр мөнгийг нь ингээд хэрэглүүлэхгүй гээд

байлгаад байгаа. Тэгэхээр бид хэд энэ дотоод нөөц бололцоонуудыг ерөөсөө ашиглах энэ юман дээрээ бас анхаараач ээ. Тэгээд сая хар тамхитай тэмцэхэд мөнгө байхгүй гээд сууж байгаа байхгүй юу. Ирэх жил 6,8 тэрбумыг тавина гээд .../минут дуусав/

**Л.Соронзонболд:** Сангийн яамнаас Санжаадорж.

**М.Санжаадорж:** Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга Санжаадорж. Сайнзориг гишүүний асуултад хариулъя. Бид нарын өргөн барьсан байгаа төсвийн хүрээний мэдэгдэл дээр бол 9 тоо байгаа. Зарлагын нийт дээд хэмжээ гэж байгаа. Суурь зарлагын нийт дээд хэмжээ гэж байгаа. Суурь зарлага маань цалин хөлс гэх мэт урсгал зардал, дээр нь хөрөнгө оруулалтын зардлууд бол багтаж байгаа. Энэ суурь зарлага маань нийтдээ 2,8 их наядаар энэ жилийн төсвөөс нэмэгдэхээр тооцож, бид нар 2,6 их наядаар нэмэгдэхээр тооцож оруулж ирсэн байгаа. Энэ хүрээндээ намар төсвийн ерөнхий захирагч бүрээр нь, байгууллага бүрээр нь, тэгээд зориулалт хөтөлбөр тус бүрээр нь бид нар задлаад оруулж ирнэ. Энэ үедээ таны хэлж байгаа энэ саналуудыг аль болох тусгах гээд багтаах гээд оруулж ирнэ. Ер нь тэр архидан согтуурахтай тэмцэх сан яг өөрийнх нь орлого нь бүрдчихээд байж байгаа. Улсын төсвөөс зарлага авахааргүйгээр хэрэгжих ийм боломжтой байгаа учраас зориулалтынх нь дагуу бид нар .../минут дуусав/

**Л.Соронзонболд:** Шүүх шинжилгээний байгууллага индрээс хариулъя.

**Н.Ганбаяр:** Гишүүний асуултад хариулъя. Шүүхийн шинжилгээний ерөнхий газар хурандаа Ганбаяр илтгэж байна. Сая ХЭҮК-оос явуулсан дүгнэлтээр тэр цогцос хадгалах байрны асуудлаар ярьсан. Энэ асуудлаар бид 2027 оны хөгжлийн хөтөлбөрт тусгахдаа саналаа хүргүүлчихсэн байгаа. Тухайн нөхцөл байдал бол яах вэ 21 аймагт байдаг. Тэр болгон сумдад бас энэ нөхцөл байдал үнэхээр хүндрэлтэй байгаа. Сум болгонд цогцос хадгалах байр, эрүүл мэндийн төвүүд байдаггүй. Ийм учраас манайхан яг 21 аймгийн хувьд сумын эмнэлэгтэй ойрхон байгаа сумын эмнэлэгт цогцсоо хадгалж, тэнд цогц хадгалах байргүй байгууллагууд маань очиж задлан шинжилгээгээ хийдэг. Тэгэхээр нөхцөл байдлыг арилгах үүднээс сумд болон 21 аймгийн эрүүл .../минут дуусав/

**Л.Соронзонболд:** Хариултыг гүйцээе. Индрийн микрофоныг нээе.

**Н.Ганбаяр:** Харилцан ажиллах байдлаар энэ асуудлыг шийдэж байгаа. 2027 оны төсөвт бол тусгагдсан байгаа энэ асуудлууд.

**Л.Соронзонболд:** Баасанжаргал гишүүн асуулт асууя.

**Х.Баасанжаргал:** Би шүүхийн төсөвтэй холбоотой 2 асуулт, ХЭҮК-той холбоотой 1 асуулт гээд нийт 3 асуулт асууна. Бараг намайг юу асуух гэж байгааг нь Сангийн яам, Эдийн засгийн яамныхан бол бараг гадарлаж байгаа байх.

Нөгөө Шүүхийн тухай хуулийн 46.8-ыг хэзээ амилуулах вэ л гэдэг асуултаа асуух гээд байна. 46.8-аар ингээд Төсвийн хүрээний мэдэгдлийг бид нар өнөөдөр энэ 7 хоног, энэ сард баталчихдаг. Үүний дараа дахиад Улсын дээд шүүх, Шүүхийн ерөнхий зөвлөлийн төсвийг Хууль зүйн байнгын хороо төсвийн төсөөллийг баталдаг. Энэ 2 цикл зөрөөд байгаа байхгүй юу. Тэгэхээр эргээд нөгөө намар Хууль зүйн байнгын хорооны баталсан хэмжээгээр Шүүхийн ерөнхий зөвлөлийн төсөв орж ирэх байтал нөгөөдөх нь Сангийн яамнаас, Эдийн засаг хөгжлийн яамнаас буулгаад

ороод ирдэг. Сүүлд тайлбараа юу гэж хэлж байна гэхээр төсвийн хүрээний мэдэгдэлд багтаагүй. Энэ мэдэгдэлд ороогүй дүнгүүд байдаг учраас бид нар баталдаггүй юм гээд байгаа байхгүй юу. Гэтэл Хууль зүйн байнгын хороо хамгийн гол нь нөгөө шүүхийн бие даасан төсвийн бие даасан байдлыг хангах гэж энэ Шүүхийн тухай хуулийн 46.8-д заасан Хууль зүйн байнгын хорооны баталсан энэ хэмжээнээс буулгахгүйгээр эргээд тэгээд нөгөө төсөв маань өөрөө орж ирэх ёстой байгаад байдаг. Тэгэхээр энэ циклийн гэх юм уу, энэ хууль тогтоомжийн зөрчлийн асуудал гэх юм уу энэ зүйлийг арилгах тал дээр ямар нэгэн арга хэмжээ авах тийм зүйл байна уу. Сангийн яам, Эдийн засгийн яам 2 энэ дээр хариулаад өгөөч. Шүүхийн ерөнхий зөвлөлөөс бас хүн байгаа байх. Тэгээд шүүх ч гэсэндээ энэ дээрээ санаачилгатай ажиллаад энэ төсвийн хүрээний мэдэгдэл орж ирэхээс өмнө шүүхийн энэ төсвийн төсөөлөл өөрөө орж ирдэг баймаар байна. Эсвэл Шүүхийн ерөнхий зөвлөлийн төсөв нь өөрөө энэ төсвийн хүрээний мэдэгдлээс хамаарахгүйгээр явах ёстой юм уу гэдэг ийм асуулт гэсэн үг.

2 дугаарт шинээр хүүхэд, гэр бүлийн шүүх гээд дагнасан маш том дагнасан шүүхийн тогтолцоо бий болж байгаа. Энэтэй холбоотой төсөв шинээр 2027 онд орж ирсэн үү. Шинэ хүүхэд, гэр бүлийн шүүхтэй холбоотой юу орж ирсэн бэ гэдгийг асуумаар байна. Юу нь орж ирээгүй, юу нь орж ирээгүй вэ гэдгийг Шүүхийн ерөнхий зөвлөл ч гэсэндээ энэ дээрээ бас хариултаа бэлдэж байгаарай. Ялангуяа Хүүхэд, гэр бүлийн шүүхийн хувьд байрны стандарт өөрөө маш нарийн хүүхдийн асуудал байдаг учраас одоогийн байгаа манай шүүхийн байруудаас 1 нь ч шаардлага хангахгүй ийм зүйл байгаа.

3 дахь асуулт ХЭҮК энэ Ази, Номхон далайн хүний эрхийн сургалт судалгааны төвийг байгуулах асуудал сая энэ 2027 оны төсөв дээр би ороогүй гэж ойлгож байгаа зөв үү. Гэтэл бид нар ОУБ-аас, НҮБ-аас хүний эрхийн дээд комиссоор ирэхээр бид нар байгуулна, барина. Монгол улс тодорхой хэмжээний төсвийг тавина гээд байдаг. Эргэж хараад яг төсөв дээрээ орох гэхээр энэ нь ерөөсөө орохгүй. Тэгээд олон улсын өмнө очоод энэ чинь аль 2023 оноос хойш явж байгаа, олон улсын өмнө өгч байгаа, НҮБ-ын өмнө өгч байгаа амлалт. Тэгээд энэ асуудал яагаад явахгүй байна вэ гэсэн ийм 3 асуулт байна.

**Л.Соронзонболд:** Индрийн микрофоныг нээе.

**М.Санжаадорж:** Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга Санжаадорж гишүүний асуултад хариулъя. Үндсэн хуулиараа бол төсөв боловсруулах онцгой бүрэн эрх нь бол Засгийн газрын эрх байгаа. Батлах нь бол Улсын Их Хурлын эрх байгаа. Төсвийг боловсруулахдаа болон батлахдаа төсвийн тухай хууль дээр юу гэж заасан байдаг вэ гэхээр 9.1.2 дээр шүү заалтаараа бол. Төсвийн хүрээний мэдэгдэлд нийцүүлж Улсын жилийн хөгжлийн төлөвлөгөө, улсын төсөв, Ирээдүйн өв сангийн төсөв, Үндэсний баялгийн сангийн төсөв, Нийгмийн даатгалын сангийн төсөв, Эрүүл мэндийн даатгалын сангийн төсөв, тэдгээрийн тогтоол, тодотголыг хэлэлцэж батална гэсэн. Өөрөөр хэлбэл энэ хүрээ гэдэг маань нийт манай олж болох орлого маань. Нийт гарч болох зарлага маань энэ байна. Зарлагаа ингэж тогтоож байж бид нар инфляцаа ийм түвшинд барьж байгаа, эдийн засгийн хөгжлийн өсөлтөө ингэж барьж байгаа гэдэг ийм санаа байгаад байгаа юм. Тэгэхээр бид нар байхгүй орлого байсаар байтал гэнэт шүүхийг ороод ирэхээр энэ маань өөрөө төсвийн тухай хууль дээр зөрчил болчихоод байгаа юм. Ер нь зүгээр анх энэ маань яагаад эхэлсэн бэ гэхээр та мэдэж байгаа байх. Илүү юу гэдэг юм, Улс төрийн түвшинд шийдвэр гаргахдаа Их Хурал дээр бол илүү багш, эмч нарын цалинг нэмэх ийм зүйлүүд яваад байдаг учраас нөгөө талдаа бас төрийн үйлчилгээ

болсон шүүхийн энэ бас шүүх засаглалын маань энэ төсөв хоцрогдоод байсан учраас ийм зүйл болчихсон. Тэгэхээр бид хүчээр юу гэдэг юм шууд Их Хурал дээрээ төсвийг нь шууд боловсруулаад, батлаад, Засгийн газар өөрөө орлогоо 1 талд нь тооцож байхад, орлогыг нь үл тооцоод, зарлагыг нь Их Хурал дээр шийдээд, шууд энийг тусга гэж оруулж ирэхээсээ илүү шүүхийн төсвийг бид нар яаж тооцох аргачиллаа илүү боловсронгуй болговол их зүйтэй байна гэж үзээд байгаа юм.

Сая сүүлд бол Шүүхийн ерөнхий зөвлөлийн даргатай бид нар бас яг энэ асуудлаар санал солилцсон. Жишээ нь, хэрэг шийдвэрлэлтийн хувьд бол аль шат дээрээ хамгийн их хэрэг шийдэж байна. Үүнтэй нь холбоотойгоор бид нар 1 хэргийг шийдэх хугацаа, өртөг, тэгээд оролцож байгаа хүний тооноос нь хамаараад суурь зардлыг өгдөг болъё. Энэ нь автоматаар тооцогддог болж байна. Энэ дээрээ нэмээд дахиж сайжруулах ёстой зүйлүүдийг явъя. Стандартаа илүү Их Хурлаас баталъя. Жишээ нь бүгд камертай байна ч гэдэг юм уу, энэ хугацааны хувьд бол ингэж явна ч гэдэг юм уу ийм агуулгаар явах юм бол илүү хэрэгжихэд бодитой болох болов уу гэдэг агуулгаар харж байна.

Харин гэр бүлийн шүүхийн хувьд энэ асуудал маань намар төсөв маань орж ирэхдээ дахиад орж ирнэ. Процессын хувьд таны саяын хэлдгээр Хууль зүйн байнгын хороогоор дахиад шүүхийн төсөв маань хэлэлцэгдээд, энэ төсвийг шууд нэгтгэ гээд орж ирнэ. Засгийн газар дээр очингуут мэдээж хэрэг 2,6 их наядын бид нарт нэмэх л орон зай байгаа. Энэ орон зайндаа нөгөө багшийн цалингаа нэмэх үү, эмч нарын цалингаа нэмэх үү, шүүхээ багтаах уу, тэтгэврээ багтаах уу, хүн амын өсөлтөө яах вэ гээд энэ бүх проблемуудаа яаж шингээх вэ гэдэг дээрээ л тооцож байгаад л оруулж ирнэ гэсэн үг. Тэгэхлээр илүү деталь чинь байгууллага болгоноороо, ерөнхийлөн захирагч болгоноороо намар орж ирэхээр байгаа.

**Л.Соронзонболд:** ШЕЗ хариулъя. Индрийн микрофон.

**Б.Эрдэнэтулга:** Баасанжаргал гишүүний асуултад хариулъя. ШЕЗ Эрдэнэтулга. Бид бүхэн 2027 оны хөгжлийн төлөвлөгөөнд бол хөрөнгө оруулалт гээд 150 тэрбум төгрөг тусгасан байдаг. Үүнээс гэр бүлийн шүүхийн 30 тэрбум төгрөг, шинээр хөрөнгө оруулалтууд гээд энэ төсвүүд бол бүгд хасагдсан байдаг. Мөн 2025, 2026 онд үргэлжилж явж байгаа барилгуудын нийтдээ 43 тэрбум төгрөг уг нь шаардлагатай байдаг. Гэвч 2027 онд ШЕЗ-д бол зөвхөн 33 тэрбум төгрөг төсөвлөгдсөн байгаад байгаа. Ингэхээр бид бүхэн 2025 онд эхэлсэн шүүхийн цогцолбор барилга, БЗД-ийн шүүхийн эрүүгийн шүүхийн барилгуудын үлдэгдэл төлбөр байхгүйгээс холбоотойгоор ингээд энэ байрнууд бол хугацаандаа ашиглалтад орохгүй болж байна. Нийтдээ бол 154 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтыг хийсэн. Гэр бүлийн шүүхийн 30 тэрбум төгрөг бол 2027 оны улсын хөгжлийн төлөвлөгөөнөөс бүр хасагдсан. Мөн цогцолбор барилгын үлдэх 38 тэрбум төгрөг маань 33 тэрбум төгрөг болж буурч .../минут дуусав/

**Л.Соронзонболд:** ХЭҮК индрийн микрофон.

**Т.Ихтамир:** Та бүхнийхээ энэ өдрийн мэндийг эрье. ХЭҮК бол 2027 онд нийт 38,5 тэрбум төгрөгийн төслийн саналыг бол өгсөн байгаа. Энэ дотор хөрөнгө оруулалтын буюу Ази, Номхон далайн НҮБ-ын харьяа Ази, Номхон далайн бүсийн хүний эрхийн төвийг байгуулах энэ амлалтыг бол НҮБ-ын хамтын нийгэмлэгийн өмнө Засгийн газар бол амласан байгаа. Энэ амлалтын хүрээнд бол 2024-2028 оныг Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн 4.12-т ингээд тусгагдсан боловч одоогоор бол санхүүжилтийн барилгын төсөв ингээд батлагдах асуудал бол

эргэлзээтэй байна. 13,4 тэрбум нь бол урсгал зардал буюу үйл ажиллагааны зардлуудад ингээд 38,5 тэрбум ингэж зарцуулагдаж байгаа. Зарцуулагдахаар төсвийн саналаа өгсөн.

**Л.Соронзонболд:** Энхбаяр гишүүн ирцдээ орчих юм бол шууд наанаас хариулж болох юм байна лээ.

**Ж.Энхбаяр:** Төсвийн бүх ерөнхийлөн захирагч нараас бүх саналууд ирсэн. Нийт 45 их наядын урсгал зардал, хөрөнгө оруулалтын 29,9 их наядыг нэмье гэж орж ирж байгаа. Тэгэхээр бид нар төсвийн хүрээний мэдэгдэл гарч байгаа гол зорилт бол яг л энэ хүсэлтийг, эрэлтийг зохицуулаад, эдийн засгийнхаа гол суурь тоонуудаа боломжуудаа гаргаад, ингээд төсвийн хүрээнд батлаад өгнө. Төсвийн хүрээнд дээрээ үндэслээд Сангийн яам төсвөө энэ зуны хугацаанд зохиогоод, 9 сард өргөн барьчихна. Энэ Төсвийн хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хуулиар нэлээн чамбайруулчихсан. 2026-2030 оныг хөгжүүлэх нийгэм, эдийн засаг хөгжүүлэх хөтөлбөрөө бид нар батлаад авсан Их Хурал. Зөвхөн тэр хөтөлбөр батлагдсан төсөл хөтөлбөрүүд энэ 5 жил хэрэгжинэ. Энэ хуулийн гол зорилт бол улс төрөөс ангид, бодлогын тасралтгүй үргэлжлэх, хэрэгжих гэдэг гол зүйлийг нь нэлээн сайн .../минут дуусав/

**Л.Соронзонболд:** Хариултаа гүйцээе.

**Ж.Энхбаяр:** Хэрвээ улс төрийн нам сонгуульд нэр дэвшигч энэ хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хуульд тусгаагүй зорилтыг хэрэгжүүлнэ гэж орж ирэх юм бол сонгуульд нэр дэвшилтийг нь бүртгэх намын жагсаалтаас хасах хүртэл зохицуулалттай. Энэ бол үнэхээр бодлого тогтвортой байна. Энэ бодлогоо 5 жилийн бодлогоо дагаад, жил жилийн төлөвлөгөө гаргана. Тэнд үндэслээд энэ төсвийн хүрээ төсөв зохиогддог. Ингээд шат шатны хяналт шалгалт сайжраад, энэ процесс дээр нь Төсвийн тогтвортой байдлын зөвлөл гээд Их Хурлын дэргэдэх бүтэц бас ажиллаад, 2 талаас нь хянадаг болоод эхэлж байгаа юм. Тэгэхээр ийм хүсэлт байна. Бид нарын эдийн засгийн бололцоо чинь энэ байна. Эдийн засаг 2027 онд 5,8 хувиар өсөх нь байна. Инфляц 7 хувьтай байна. Орлого, зарлага энэ байна. Төсвийн тэнцэл 1,7 хасах алдагдалтай гарахаар байна. Энэ алдагдлын хэмжээгээр бид нар гадаад зээлийн ашиглалтаа нэмэгдүүлнэ. Энэ хүрээнд л ярина даа. Гол анхаарах зүйл бол бид урсгал зардлын хэт тэлэлт хөрөнгө оруулалт хийх боломжийг үндсэндээ хязгаарлачхаж байгаа юм. 2027 онд шинэ .../минут дуусав/

**Л.Соронзонболд:** Энхбаяр гишүүний микрофоныг нээе.

**Ж.Энхбаяр:** 2027 онд улсын төсвөөр шинэ хөрөнгө оруулалт хийгдэх бололцоо байхгүй. Үргэлжилж байгаа 3,6 их наядын хөрөнгө оруулалт байгаа. Үүнээсээ 2,2 их наядыг л санхүүжүүлэх бололцоо үүснэ. Хэрвээ НӨАТ-ын хууль. НӨАТ-ын хуулийн 20 хувийн олголтыг 50 хувь болгож байгаа шүү дээ буцаан олголтыг. Болгож байгаа хуулийг бид нар хүчингүй болгох санал оруулж байгаа. Хэрвээ энэ дэмжлэг авбал эх үүсвэр нэмэгдэнэ. Дэмжлэг авахгүй бол 2,2 их наядаас ахиад 1,8 их наяд дахин хасагдана буюу 2027 онд бид нар 400 тэрбум төгрөгийн л шилжих хөрөнгө оруулалт хийнэ. Ийм л болж байгаа юм. Үндсэндээ манай төсвийн чадавх урсгал зардал, цалин, тэтгэвэр тэтгэмжээсээ илүү гарч чадахаа больж байна л гэсэн үг. Ингээд гадаад өр зээлээ төлөөд, шинэ хөрөнгө оруулалт хийх боломжгүй болж байгаа юм. Үндсэндээ дээд хэмжээндээ тулж байна л гэсэн үг.

**Л.Соронзонболд:** Баасанжаргал гишүүн тодруулъя.

**Х.Баасанжаргал:** Энэ шүүхийн тухай хуулийн 46.8-ыг би байнга төсөв хэлэлцэх болгонд л яг төсвийн ерөнхийлөн бусад захирагчтай адилхан энэ Шүүхийн ерөнхий зөвлөлийн төсөв, Улсын дээд шүүхийн төсвийг үзэхгүй. Энэ чинь үндсэн хуулийн асуудал. Үндсэн хуулийн эрх мэдлийн асуудал гэж удаа дараа хэлэх юм. Тэгээд энэ асуудлыг хэрвээ үнэхээр ингэж биелэх боломжгүй юм бол Шүүхийн тухай хуулийн 46.8-ыг бараг хүчингүй болгомоор юм биш үү. Ямар ч ийм бодитой биелэх боломжгүй, шүүхийн төсөв ерөөсөө бие даасан хараат бус байх шинж нь огт хангагдахгүй. Энэ баталгаа нь ерөөсөө эрх зүйн баталгаа нь өөрөө бодит амьдрал дээр огт хэрэгжихгүй байгаа байхгүй юу. Тэгэхээр Төсвийн хүрээний мэдэгдлийн өмнө гээд байгаа юм миний санаа. Одоо төсвийн хүрээний мэдэгдлийн дараа болохоор та нар намар болохоор юу гэдэг вэ гэвэл төсвийн хүрээний мэдэгдэл баталсны дараа орж ирж байгаа төсөв учраас бид нар оруулах боломжгүй гээд ам хаачаад байгаа байхгүй юу. Тэгвэл төсвийн хүрээний мэдэгдлээс өмнө энэ төсвийг Шүүхийн ерөнхий зөвлөлийн, Улсын дээд шүүхийн энэ төсвийг хэлэлцээд, Хууль зүйн байнгын хороо батлаад .../минут дуусав/

**Л.Соронзонболд:** Энхбаяр сайд хариулъя.

**Х.Баасанжаргал:** Таны байр суурийг сайн ойлгож байна. Гэхдээ манайх энийг хэрэгжүүлэх эдийн засаг төсвийн боломж байхгүй. Ингээд улсын төсвөөс тусдаа Шүүхийн ерөнхий зөвлөлийн төсвийг тусад нь Засгийн газраар орохгүйгээр, Сангийн яамаар төсвийн нэгдсэн бодлогод орохгүйгээр шууд баталдаг ийм зохицуулалт хийх юм бол нэгдсэн төсөв, нэгдсэн улсын бодлого, үндсэн зарчим бас алдагдана. Дээрээс нь бид нар 2 том алдаа хийчихсэн байна. Одоо алдаа гэнэ үү, асуудал. Орон нутгийн төсөв улсын төсвөөсөө давж эхэлсэн. Сүүлд нь төрийн өмчит компаниудын хөрөнгө оруулалтын төсөв улсын төсвийн хөрөнгө оруулалтаа давж эхэлж байгаа. Гэтэл Улсын Их Хурал яг бид нар төсөв дээрээ суугаад энэ орон нутгийн төсөв төрийн өмчит компаниудын өр авлага төсвийн асуудлыг гадуур орхигдуулчихсан. Энэ дээр яаралтай эрх зүйн өөрчлөлт, бодлогын шийдэл гаргаж, нэгдсэн улсын хувьд нэгдсэн төсөвтэй болж жоохон цэгцэд нь оруулахгүй бол тэнд жоохон асуудлууд их суларч байна. Нийт бид нарын яриад байгаа энэ .../минут дуусав/

**Л.Соронзонболд:** Номинчимэг гишүүн асуулт асууя.

**О.Номинчимэг:** Төсвийн хүрээ хэлэлцэж байгаа учраас энэ төсвийн хүрээ дээр орж ирсэн тоонд нөлөөлөх 3 л асуулт асууя гэж бодож байна.

1 дүгээрт яах вэ манай энэ Хууль зүйн байнгын хороонд ирчихсэн байгаа, харьяалж байгаа энэ яам, Тамгын газар, агентлагууд бол ерөөсөө орлого олдог агентлагууд бол биш шүү дээ. Орлого олдог газрууд бол биш, салбарынхан биш байгаа. Энэ бол дандаа төрийн үйлчилгээнийхэн буюу зардал гаргадаг. Гол нь энэ зардал нь иргэддээ хүртээмжтэй, шударга, чанартай хүрэх үү л гэдэг асуудал дээр бид нар анхаардаг. Ингээд олон байгууллага байгаа. Мэдээж зардал байгаа. Тэгээд энэ төсвийн хүрээний мэдэгдэл дээр ер нь нэгдсэн төсвийн нийт зарлага бол ингээд өсөж байгаа. Гэхдээ ДНБ-д эзлэх хувиар бол багасаж байгаа. Тэгээд зүгээр ерөнхийдөө Эдийн засаг, хөгжлийн сайд хариулчихна биз. Манай энэ Хууль зүйн байнгын хороонд харьяалагдаж байгаа. Энэ байгууллагуудаас урсгал зардал нь ихсэж байгаа байгууллагууд байгаа юу. Байгаа бол ямар учир шалтгаанаар ихсэж байгаа вэ гэдэг дээр 1 дүгээр асуулт. Яагаад гэвэл орлого олохгүй юмыг чинь зарлага дээр нь яаж бид нар анхаарах ёстой вэ л гэдэг дээр анхаарах гээд байна.

2 дугаарт болохоор юу байна. Орлого олох асуудал. Манай энэ дээр юугүй байгаа ч гэсэн орлого олох юмнуудаа нэлээн бас ингээд тооцоолоод орж ирсэн байх л даа. Уул уурхайгаас орлого орно гэж байгаа. Гэхдээ миний нөгөө санаачилсан хуультай холбоотойгоор би урьд нь ч гэсэн олон дахин хэлж байсан. Евроазийн хэлэлцээр, худалдааны хэлэлцээр удахгүй 7 сараас хэрэгжих гэж байгаа гээд сая Төсвийн байнгын хороо дээр Энхбаяр сайд ярьж байлаа л даа. Тэгээд энүүгээр юу болсон бэ гэхээр нөгөө нөгөө Казахстан, Орос улсаас оруулж ирэх, импортолж оруулж ирэх янжуур тамхины гаалийн 30 хувийн татварыг тэглэчихсэн байгаа. Надад нөгөө 2024, 2025 онд энэ хэлэлцээр зөвшилцөхөөр орж ирэхэд ирсэн мэдээллээр бол жилдээ 70-аад тэрбум төгрөг бол энэ гаалийн албан татвараар авдаг гэж байгаа юм. Одоо энэ 7 сард хэрэгжээд эхлэх юм бол ямар ч гаалийн татваргүй тамхи орж ирэх нь л дээ. Хямдхан. Тэгээд энэ чинь өөрөө эдийн засгийн хувьд, хүмүүсийнхээ эрүүл мэндийн хувьд маш хохиролтой асуудал гэдгийг хэлсээр байгаад энэ асуудлыг түрүү жил энэ оны 4 сарын 15 гэхэд энийгээ дотоодын хууль тогтоомжоор буюу онцгой албан татвараараа энийг зохицуулаад ороод ирэх юм байна гэдэг шийдэл байгаа гэхээр нь чиглэл өгөөд, 4 сарын 15 гэхэд оруулж ир гэсэн. Одоо орж ирээгүй байна. Хэзээ орж ирэх юм. Орж ирэхгүй байсаар байгаад тамхины компаниудын лоббинд орж байгаа юм шиг ингээд та нар төсвийн орлогоо алдаад, нийт иргэдийнхээ эрүүл мэндийг хохироох ажил байгаад байна уу. Энэ дээр мэдээлэл байвал өгөөч ээ.

3 дугаарт орлоготой холбоотой бас 1 асуудал байгаа бид нарын хувьд. Эхлээд 2 асуулт дээрээ хариулт авчихъя. Тэгээд нэмэлт дээрээ тэр асуултаа явчихъя. Хугацаа нь дуусаад байх шиг байна.

**Л.Соронзонболд:** Тэргүүн шадар сайд Энхбаяр хариулна.

**Ж.Энхбаяр:** Өнгөрсөн хугацаанд урсгал зардал Хууль зүйн байнгын хорооны харьяа бүх байгууллагад өссөн. Өсөх өсөхдөө эрс өссөн. Тийм ч нийгэм, эдийн засгийн шаардлага байсан. Цалин өссөн. Шинэ төсөл хөтөлбөрүүд хэрэгжсэн. Тэрийгээ дагаад ашиглалтууд нэмэгдсэн. Шинэ шинэ байшин барилгууд орсон. Урсгал зардлууд нэмэгдсэн. Албаны насжилт бас их нэлээн өндөрсөж байгаатай холбоотой тэтгэвэрт гарч байгаа тоо сүүлийн жилүүдэд эрс нэмэгдсэн. 36 сарын нэмэгдэлтэй холбоотой урсгал зардал бас нэмэгдсэн. Тэгээд зэвсэг техник, хил хамгаалалт, хууль сахиулах үйл ажиллагааг сайжруулах хүрээнд бас бодлогын бөгөөд бүх хөрөнгө оруулалтын чиглэлээр бүх талаар нэмэгдсэн. Цаашдаа бол нэмэгдэх бололцоо үндсэндээ ингээд хязгаарлагдаж байна. Манай эдийн засгийн чадавх маань үүнээс илүү цаашаа даахгүй. Нийт төсвийн маань 80 гаруй хувь нь урсгал зардал, цалин, тэтгэвэр, тэтгэмж болсон. Үлдэж байгаа дээр бид 2027 онд 2,2 их наядын хөрөнгө оруулалт хийх л орон зай гарч ирж байна. Тэр нь үргэлжилж байгаа хөрөнгө оруулалт. Шинэ хөрөнгө оруулалт, шинэ төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх бололцоо байхгүй. Бидэнд тавигдаж байгаа гол даалгавар юу вэ гэвэл эдийн засгаа тэлэх, гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжих, шинэ эдийн засгийн үйлдвэрлэл, бүтээмж, нэмүү өртөг олдог салбараа л дэмжихгүй бол одоо байгаа бий болсон салбар маань үндсэндээ бүхий л түвшиндээ дээд хүчин чадалдаа хүрээд урсгал зардал маань бас дээд хэмжээндээ хүрээд үндсэндээ ингээд тулж байна. Зөвхөн багш, эмч нарын цалинтай холбоотой 2027 онд 4 их наяд, тэгээд бусад асуудлууд, тэтгэврийн нэмэгдэл, бусад шаардлагатай зардлууддаа тооцоход 6 их наядын нэмэлт зардал үүснэ. Ингэж бид нар санхүүжүүлэх үнэхээр үндсэндээ боломж чадавх дуусаж байгаа шүү.

Иймд Засгийн газар бизнесийг дэмжих, хөрөнгө оруулалтыг дэмжих, хувийн хэвшлийг дэмжих хууль, эрх зүйн багц төслүүдийг бэлдээд, энэ хаврын чуулгандаа батлуулна. Бизнесийн эрх чөлөөний, эдийн засгийн эрх чөлөөний, хөрөнгө оруулалтын, худалдааны, зөвшөөрлийн, төр, иргэний хяналт шалгалтын гэх мэт ийм эдийн засгийг либералчлах, хөрөнгө оруулалтыг татах таатай орчныг бүрдүүлэх ажлуудыг хийх болно.

Нөгөө талаар энэ олон жил болсон хөрөнгө оруулагчтай холбоотой маргаануудыг шийдэхгүй бол Монголын нэр хүндэд муугаар нөлөөлж байна. Агаарт өлгөгдөөд олон зүйл болсон. Хууль, шүүх, шийдвэр гүйцэтгэл дээр гацчихсан зүйлүүд олон байна. 5 жил, 8 жилээр шийдвэр хэрэгжихгүй байгаа зүйлүүд байна. Олон хөрөнгө оруулагчтай арбитрын маргаанууд үүсчихсэн байна. Ер нь бид нар энэ хөрөнгө оруулалтынхаа орчныг сайжруулахгүй бол бид гадаадын хөрөнгө оруулалтыг татаж чадахгүй нь. Одоо Монголд байгаа гадаадын хөрөнгө оруулалтай аж ахуйн нэгжүүд чинь Монгол Улсын төсвийн орлогын 20 хувийг дангаараа бүрдүүлж өгч байгаа шүү дээ. 4 мянга орчим аж ахуйн нэгж байгаа. Нийт Монголд 230 мянган аж ахуйн нэгж ажиллаж байна, 32, 33 мянга. 4 мянган үйл ажиллагаа идэвхтэй явуулж байгаа аж ахуйн нэгжүүд маань ийм үүрэг гүйцэтгэж байна. Гэтэл гадаадын хөрөнгө оруулалтын орчин маань маш хүнд байна. Энийгээ эрс сайжруулах арга хэмжээг .../минут дуусав/

**Л.Соронзонболд:** Нөгөө Евро Азийн худалдааны гэрээ, тамхитай холбоотой асуусан шүү дээ. Тэрийг нь хариулъя. Тэргүүн Шадар сайдын микрофоныг нээе.

**Ж.Энхбаяр:** 1 минутад амжихгүй байна л даа. Евроазийн гэрээтэй холбоотойгоор Евроазийн орнуудаас импортлох тамхины татвар тэглэгдэнэ. Энэ зохицуулалтын арга хэмжээг хийхийн тулд бусад бүх орноос орж ирж байгаа тамхины импортыг тэглээд, харин онцгой албан татвараа нэмж зохицуулалт хийж, зах зээлийн өрсөлдөөн тэгш байдлыг хангах бололцоо байгаа. Евроазийн гэрээгээр бид нар онцгой татвараа тогтоох асуудлаа өөртөө аваад үлдчихсэн юм. Тийм болохоор гаалийн татвар нь чөлөөлөгдсөн ч, онцгойг нь өсгөж өгөөд, бусад орнуудын импортод адил тэнцүү байх бололцоотой.

Төсвийн хүрээ даган өргөн барьж байгаа төсвийн тодотгол хийх 3 сарын хугацааг хүчингүй болгох асуудлыг хөндөж байгаа. Энийг дэмжээд өгвөл 6 сарын 1-нд энэ төсвийн хүрээ батлагдана. Маргааш нь бид нар төсвийн тодотголыг цаг алдалгүй өргөн барина. Тэр хүрээнд энэ төсвийн, төрийн байгууллагуудын бүтцийн зохион байгуулалтын, хөрөнгө оруулалтын олон асуудлаа нэг мөр шийдье гэж бодож байгаа. Тэгэхгүй бол .../минут дуусав/

**Л.Соронзонболд:** Номинчимэг гишүүн тодруулъя.

**О.Номинчимэг:** Тамхины юун дээр та ер нь хэлэлцээр эхлэхээс нь өмнө энийгээ засаж чадна, чадахгүйгээ л хэл. Чадахгүй бол өдөрт 11 хүн тамхинаас үүдэлтэй өвчлөлөөр нас барж байгаа. Энэ чинь ихэснэ. Үүний хариуцлагыг би энэ хэлэлцээрийг хийсэн, тэгээд эс үйлдэхүй гаргаж энэ хуулийг оруулж ирээгүй хүмүүстэй хатуу ярина шүү гэдгээ 1 дүгээрт хэлье.

2 дугаарт дараагийн нөгөө 3 дахь асуулт бол энэ хууль дагуулаад НӨАТ-ын хууль орж ирсэн. Энэ бол мэдээж төсөвт маш ачаалал байх юм. 1,6 билүү 1.0 их наядын ачаалал гээд. Тэрийгээ та бүхэн ингээд орлого дээрээ нэмээд тооцсон юм шиг байгаа юм. Энэ төсвийн хүрээ баригдсаны дараа Засгийн газраас татварын

багц хууль орж ирсэн. НӨАТ-ын тухай хууль орж ирсэн. ХХОАТ-тай холбоотой асуудлууд орж ирсэн. ААН-тэй. Энэ татварын багц хуулиас гарч байгаа нөлөөлөл татварын орлогод нөлөөлөл гарна шүү дээ. Энэ төсвийн хүрээний мэдэгдэлд энэ тооцоологдсон байгаа юу. Тэрийг баталлаа гэхэд энэ бол өөрчлөгдөхгүйгээр шууд энэ тоонууд өөрчлөгдөхгүй гэж ойлгож болох уу. Эсвэл өөрчлөгдөх үү гэдэг дээр хариулт авъя.

**Л.Соронзонболд:** Тэргүүн Шадар сайд Энхбаярын микрофон.

**Ж.Энхбаяр:** Энэ Татварын багц хууль нь ААН-ийг дэмжих чиглэл рүү явж байгаа. Иргэн талдаа биш. Одоо бид нар иргэн рүү НӨАТ-ын олголтыг нэмэгдүүлэх асуудлаа хойшлуулъя. Энэ эдийн засаг, төсвийн хүндрэлтэй үед бол аж ахуйн нэгжүүдээ, хувийн хэвшлээ, ажил олгогчоо дэмжих нь их чухал байна. Ажил олгогч, ажлын байр бий болгоно. Дээрээс нь татвар төлөлтийг нэмэгдэхэд хувийн хэвшлийг дэмжих нь зүйтэй гэсэн багц хуулиуд байгаа юм. Энэ дээр НӨАТ-ын босго, нөгөө үл хөдлөх хөрөнгийн борлуулалтын асуудлууд, нөгөө ашгийн татвар ноогдох хувь хэмжээ гээд нөгөө тоо хэмжээ эд нарыг нь өсгөж байгаа зүйлүүд байгаа. Тэр тамхитай холбоотой татварын асуудлыг Сангийн яам олон Байнгын хороон дээр хөндөгдөж байгаа. Энийгээ оруулж ирэх асуудлаа тодорхой болгоод, төсвийн тодотголтой хамт оруулж ирэх байх. Боллоцотой. Эдийн засаг, хөгжлийн яамны тухайд бол ингэж байж эдийн засаг дахь тэгш өрсөлдөөнийг хангана шүү дээ. Тэгш бус байдал үүсэж болохгүй. Яагаад гэвэл Евроазийн орнууд нь татваргүй орж ирээд, Япон, Солонгос нь татвартай байж болохгүй. Тийм биз.

**Л.Соронзонболд:** Пүрэвдорж гишүүнийг нэмье. Номинчимэг гишүүн тодруулъя.

**О.Номинчимэг:** Энхбаяр сайд нөгөө Улсын Их Хуралд өргөн мэдүүлчихсэн байгаа Татварын багц хуулийн хүрээнд Хүн амын орлогын албан татварын хуулиар тодорхой хэмжээний анхан орлогыг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хүн амын орлогын албан татвараас чөлөөлж байгаа. Тийм үү. 10 хувийн хүн амын орлогын албан татвараас чөлөөлж байгаа байхгүй юу. Аж ахуйн нэгжүүд дээр бид нар яагаад аж ахуйн нэгжүүдээсээ тэгвэл орлого олж магадгүй, илүү идэвхэжнэ гэж төсөөлж байгаа юм байна. Тэр Татварын багц хуулийн тооцоолол чинь төсвийн хүрээнд туссан байгаа юм уу. Хүн амын орлогын татвараас ингээд багасгаад ирэхээр энэ чинь бас орох орлого энэ дээр нөлөөлнө. Энэ нөлөөлөл чинь энэ төсвийн хүрээ дээр орж ирсэн тоон дээр тооцоологдоод ороод ирчихсэн байгаа юм уу, тооцоологдоогүй байгаа юм уу гэдгийг л асууж байгаа юм.

**Л.Соронзонболд:** Тэргүүн Шадар сайд Энхбаяр хариулъя.

**Ж.Энхбаяр:** Төсөв маань ингээд намар деталиараа задарна шүү дээ. Бид нар бол зарлага дотроо болохоор яг орон зайг нь үүсгээд л оруулаад ирж байгаа юм. Тэтгэвэр бол инфляцтай уялдуулаад 8 хувь гарах нь уу, 9 хувь болох нь уу, 10 хувь болох нь уу. Бид нар бол 10-аар нь аваад, тэтгэврийг 10 хувиар нэмэгдүүлнэ гэсэн хэмжээний ийм орон зайнуудыг нь үүсгээд өгч байна. Энэ дээр Сангийн яам нарийвчлан ажиллаад, яг детальный хуваарилалтуудаа хийнэ шүү дээ. Сангийн яам нэмж хариулаач. Санжаа энэ дээр, тэр тамхины асуудалтай холбоотой бас.

**Л.Соронзонболд:** Индрийн микрофон Сангийн яам Санжаадорж хариулъя.

**М.Санжаадорж:** Санжаадорж Сангийн яам. Гишүүний асуултад хариулъя. Тамхины татвартай холбоотой асуудал бол Евроазийн хэлэлцээр орж ирсэнтэй холбоотойгоор нөгөө улсууд нь бас татвартай байгаад байгаа. Ингээд 1 тэгш бус байдал үүсчихээр магадлал харагдаад байгаа. Тэгэхээр нөгөө талд нь Онцгой албан татвараар бид нар бол тэгшитгээд нэмэгдээд явах боломжтой юм байна гэж тухайн үед нь ярьж байсан. Энэ асуудал бол татвартай холбоотой асуудал бас төсвийн тухай хуультайгаа бол хамт ороод ирэх боломжтой гэж харж байна.

2 дугаарт бол Төсвийн хувьд яг шинээр Засгийн газраас бол татварын хуулиуд өргөн барьчихсан байгаа. Энэ дээр мэдээж хэрэг орлогын нөлөө орж ирнэ. Гэхдээ энэ хуулиудаас аль болох 2027 ондоо нөлөөлөл бага байхаар тийм байдлаар оруулж ирсэн. Гол нөлөөлөл нь бол 2028 оноос нөлөөлөхөөр бол орж ирсэн байгаа. Тэгэхээр одоогийн өргөн барьсан байгаа .../минут дуусав/

**Л.Соронзонболд:** Пүрэвдорж гишүүн асуулт асууя.

**Б.Пүрэвдорж:** Тэгэхээр цагдаагийн байгууллагын цалин бол бага байгаад байгаа. Ялангуяа эргүүлийн жирийн цагдаа нар, бага тушаалын офицерууд яг энэ энэ монголчууд Монгол Улсын аливаа болохгүй байгаа, бүтэхгүй байгаа тэр бүх зүйл дээр очиж ажилладаг. Ковид гээд эрүүл мэндээ үл хайхраад л явж байдаг. Хүн алга болно, тэнд хүн үхнэ, бүгд дээр нь очиж, тэр цогцос энэ тэр болохгүй, бүтэхгүй байгаа бүх зүйл дээр, дээрээс нь галзуу солиотой нь мэдэгдэхгүй хүмүүс архи уусан ийм янз янзын хүмүүстэй очиж, тулж ажилладаг. Эрсдэлтэй ийм ажил дээр байдаг хүмүүсийн цалин бага байгаад байгаа юм.

Тэгээд энэ хүмүүсийг дэмждэг учраас 3, 4 удаа энэ Хууль зүйн сайдын багцад бол шаардлагагүй хөрөнгө оруулалт зардлууд байдаг юм. Тэндээс нь энэ хүмүүсийн цалинг нэмэх тухай хэд хэдэн санал гаргаад, унагаачихдаг юм л даа. Яагаад гэвэл энэ сайд нар чинь Их Хурлын гишүүдээ барьдаг учраас тэд нарыгаа аргалж байгаад, өөрсдийгөө тэр үрэлгэн зардлаасаа хасуулахгүй ингээд явчихдаг. Тэгээд энэ асуудлыг заавал дараагийн төсөв барихад зарчмын зөрүүтэй санал гаргахгүйгээр эртхэн шиг 2027 оны төсөв дээрээ энэ асуудлыг оруулж ирээрэй гэж хэлмээр байна. Одоо ямар цалинтай байгаа юм. Одоо цаашдаа яаж нэмэгдүүлэх талаар бас тодорхой хариултыг авъя.

2 дугаарт нь миний авсан мэдээллээр бол маш цөөхөн мөрдөн байцаагч нар цагдаагийн байгууллагад ажиллаж байгаа. Тэгээд цагдаагийн байгууллага ер нь бол их тийм олон даргатай байгууллага болсон. Тийм учраас энэ чадвартай мөрдөн байцаагч нар нь дарга болоод явчихдаг. Дээрээс нь тагнуул, АТГ гээд өндөр цалинтай газар луу мөрдөн байцаагчаар явчихдаг. Өөрөөр хэлбэл хэн нь илүү цалин өгнө. Тийшээ л явна шүү дээ чадвартай хүмүүс. Тэгээд дээрээс нь цагдаагийн байгууллагууд дарга нарын нөлөө маш их байдаг учраас янз янзын тэр шаардлага, янз бүрийн бүх зүйлээр тэр дарамтууд ирдэг. Тийм дарамттай байдаг учраас тэндээс яваад байх шиг байгаа юм. Тийм учраас энэ мөрдөн байцаагч нар чинь багасаад байна. Хэрэг маш их болж байна. Тийм учраас энэ хүмүүсийн, ялангуяа мөрдөн байцаагч нарын цалинг нэмэгдүүлэх, тусгайлан нэмэгдүүлэх, тэр дарга нарыгаа хаях хэрэгтэй. Тэд нарын цалинг нэмэгдүүлэх замаар чадвартай мөрдөн байцаагч нарыг цагдаагийн байгууллагатай уяж ажиллуулах энэ ажил дээр ямар ажлууд хийж байгаа юм бэ. Тэгээд энэ ажил дээрээ ахиц гарахгүй байгаа бол 2027 оны төсөв дээр бас тодорхой ажлуудыг энэ намрын чуулган хүртэл хийх боломжтой шүү.

**Л.Соронзонболд:** Цагдаагийн ерөнхий газраас. Индрийн микрофоныг нээе.

**Д.Батчулуун:** Цагдаагийн ерөнхий газрын Санхүү, ар талын албаны дарга, хурандаа Батчулуун гишүүний асуултад хариулъя.

Цагдаагийн байгууллага өнөөдөр цагдаа, дотоодын цэргийн байгууллага 12 мянга орчим бие бүрэлдэхүүнтэй. Үүний 1800 орчим нь мөрдөгч нар эзэлж байгаа. Мөрдөгч нар нь дотроо эрүүгийн мөрдөгч, мөрдөн байцаах албаны мөрдөгч гээд хариуцсан харьяалал, шалгадаг гэмт хэргээрээ бас мөрдөгч нар маань ялгаатай байгаа. Өнөөдрийн байдлаар 100 орчим орон тоо сул байна.

Гишүүний хэлж байгаа бас үнэн. Манай албанаас бас мөрдөгч нар төрийн тусгай албад руу бас шилжих хөдөлгөөн нэлээн байдаг. Бид нар энийг бас цалин мөнгөтэй холбоотойгоор хардаг. АТГ зэрэг мөрдөх байгууллагууд руу бас шилждэг тохиолдол байгаа. Манайх жил бүр төсөвт бол ер нь алба хаагчдынхаа цалинг нэмэгдүүлэх саналуудыг бол жил болгон л өгч байгаа. Хамгийн ойрын зорилт бол бас алба хаагчдынхаа онцгой албаны нэмэгдлийн 40 хувь болгож жигдлэх зэрэг тун ойрын тийм зорилтууд бол байна. Ирэх жилийн төсөвт бол төсвийн төсөлтэй саналаа нэгтгэж хүргүүлэхээр 6 сарын 1-нд төсвийн хязгаарт өгөхөөр бэлдэж байгаа.

**Л.Соронзонболд:** Эдийн засаг, хөгжлийн яамнаас 1 асуулт асууя.

Хууль зүйн байнгын хорооны харьяанд тайлагнадаг төсвийн ерөнхийлөн захирагчдын 2028-2029 оны хөрөнгө оруулалтын болоод урсгал зардлын төсөөллүүдийг улсын нэгдсэн төсвийн 2027 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2028-2029 оны төсвийн төсөөлөлд яаж тусгадаг вэ гэдэг асуултад хариулаач.

Одоо энд чинь ингээд бүх байгууллагууд, харьяа байгууллагууд ирчихсэн байна шүү дээ. Тэгвэл энэ хүмүүс чинь бүгдээрээ 3 жилээр тодорхой хэмжээнд урсгал зардлаа, хөрөнгө оруулалтуудаа тооцоолоод ингээд өгч байгаа шүү дээ. Тэгэнгүүт тэрийг манай 2027 оны улсын төсвийн хүрээний мэдэгдэл дээр 2028-2029 оны төсвийн төсөөлөл дээр яаж тусгадаг юм бэ л гэж асуугаад байгаа байхгүй юу.

**Ж.Энхбаяр:** Ингээд ерөнхийдөө бүх хүсэлтээ авчихна. Хүсэлт гээд нөгөө 45 их наяд хөрөнгө оруулалт нь 29,9 их наяд гээд авчихна. Энэ бол ерөнхий хэрэгцээ. Нөгөө талдаа чадавхаа тооцно. Монгол Улсын эдийн засаг яаж өсгөх нь вэ, инфляц яаж явах нь вэ. Төсвийн орлого бүрдүүлдэг гол нөгөө орлого бүрдүүлж байгаа гол 4, 5 суурь орлогуудын маань эрх зүйн орчин ямар байна. Шинээр гадаадын хөрөнгө оруулалт орох нь уу. Экспорт, импорт ямар байна. Экспорт идэвхжих нь үү. Экспорт дотроо гарч байгаа гол түүхий эдийн маань дэлхийн дэлхийн зах зээлийн эрэлт, хандлага, үнэ ямар байх нь вэ. Ингээд бүхий л томоохон татвар бүрдүүлж байгаа томоохон бүх аж ахуйн нэгжүүдтэй нэг бүрчлэн уулзана. Хэрэгжүүлж байгаа төсөл хөтөлбөрүүдийг нь гаргана. Ингээд нийт энэ эдийн засгийн эргэлтээс ийм зүйлийн орлого бий болгоно. Энэ орлогоосоо зарлага нь ийм байх нь зохистой гээд яг төсвийн тусгай шаардлагадаа нийцүүлээд ингээд гараад ирж байна. Энийгээ гарахын тулд Статистик, Монгол банк, Сангийн яам, Төсвийн тогтвортой байдлын зөвлөл ингээд бүх холбогдох байгууллагуудтайгаа ярина. Тоонуудаа нааш нь, цааш нь болгоно. Шинжлэх ухааны, иргэдийн, нийгмийн, олон байгууллагуудаар хэлэлцүүлнэ. Ингэж байгаад нөгөө ОУБ-ын дүн шинжилгээнүүдийг судална, тааруулна. Энэ чинь бүтэн намраас хавар хүртэл 4, 5 саяын тасралтгүй үйл ажиллагаа байгаа. Тэгж байж тоо гарч байгаа юм. Ингээд тоогоо ердөөсөө

ойртуулсаар байгаад гараад ирнэ. Энэ дээр чинь Засгийн газрын төсвийн бодлого, Монгол банкны мөнгөний бодлоготойгоо бас уялдуулж, нийцлээ хангана. Ингээд л Монгол Улсын макро эдийн засгийн гол 9 тоогоо хамгийн түрүүнд гаргаж авна. Энэ 9 тоон дээрээ Сангийн яам цаашаа задаргаагаа хийнэ. Энэ дээрээ тэгээд л төслүүдээ эрэмбэлнэ, шаардлагуудаа эрэмбэлнэ. Тэгээд яагаад төсвийн нэгдсэн бодлоготой улс орон гэдэг чинь ердөө л энэ. Энэ дээрээ л хамаг юмаа үзэж гаргана шүү дээ.

Ахиад хэлье. Эдийн засгаа л тэлэхгүй бол одоо байгаа манай бий болгосон эдийн засгийн чадавх маань үндсэндээ энд хүрээд үндсэндээ дуусаж байна. 100 их наядын эдийн засаг хүрээд манай бий болсон үйлдвэрлэл, потенциал, дэд бүтэц, эрчим хүч, бүх суурь түвшин тулж байна. Одоо бидэнд шинэ Эрдэнэт, шинэ Оюутолгой, шинэ төмөр зам, шинэ цахилгаан станцыг бий болгож бүтээж байж, шинэ экспортод шинэ зах зээл гаргаж байж шинэ хөрөнгө оруулалтыг татаж байж бид нар дараагийн 100 их наядаа бий болгоно. Тэгж байж энэ нийгэм, эдийн засагт тулгамдсан олон асуудлаа шийдэхгүй бол одоо манай орлогын боломж энэ түвшинд ирээд үндсэндээ ингээд зогсож байгаа шүү.

Одоо яаж ч шахаад Эрдэнэт дахиж баяжуулалт, олборлолт нэмэгдэхгүй. Нүүрсний зах зээл 100 сая хүрээд зогсоно. Хятадын зах зээл өөрөө хязгаартай байсан. Төмөр зам дээд хүчин чадалдаа хүрчихсэн. Эрчим хүчний салбар цахилгаан, дулааны үйлдвэрлэл дээд хүчин чадалдаа хүрчихсэн. Ажиллах хүчний оролцоо 63 хувь нэлээн өндөрдөө хүрчихсэн. Одоо бидэнд дайчлаад байх хүн нь байхгүй болж байна. Гаднаас ажиллах хүчний .../минут дуусав/

**Л.Соронзонболд:** Хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүн байна уу. Байхгүй байна.

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2027 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2028-2029 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хоёр дахь хэлэлцүүлгийг явуулсан талаар Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлтийг Төсвийн болон Эдийн засгийн байнгын хороонд хүргүүлнэ.

Санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Соронзонболд танилцуулна. Хуулийн төслийн хоёр дахь хэлэлцүүлгийг хэлэлцэж дууслаа.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул өнөөдрийн хуралдаан хаасныг мэдэгдье. Ажлын хэсгийн гишүүдэд болон хуралдаа оролцсон Улсын Их Хурлын гишүүдэд баярлалаа.

18.18 цаг.

*ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ  
ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ, ХЯНАСАН:  
ШИНЖЭЭЧ*

*Э.СУВД-ЭРДЭНЭ*